



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2026 оны 06 дугаар сарын 24-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1-2
Хуралдааны товч тэмдэглэл:	3-42
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	43-143

1. Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох тухай	43-62
2. Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	62-81
3. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	81-88
4. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	88-90
5. Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	90-91
6. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	91-92
7. Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай төсөл /Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	92-93
8. Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	93-94
9. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	94-95

10.Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	95-97
11.Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	97-99
12.Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	99-101
13.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 37 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	101
14.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/	101-113
15.“Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	113
16.Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо болон Хүний эрхийн Үндэсний Комиссын 2027 оны төсвийн төслийн талаар хэлэлцэх	113-139
17.“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	139-141
18.“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	141-142
19.“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	142-143

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 06 дугаар сарын 24-ний өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 28 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 53.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 17 цаг 55 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Баярбаатар;
Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Х.Баттулга, Э.Батшугар, Б.Дэлгэрсайхан,
У.Отгонбаяр;
Тасалсан: Д.Батлут.

Нэг.Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох тухай

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшигч Ж.Сүхбаатар, Г.Эрдэнэбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Г.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулах тухай захирамж болон нэр дэвшигчдийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт танилцуулав.

Танилцуулга болон нэр дэвшигчдээс Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, М.Нарантуяа-Нара, Б.Тулга, Х.Баасанжаргал нарын тавьсан асуултад Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшигч Ж.Сүхбаатар, Г.Эрдэнэбат нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, Х.Тэмүүжин, О.Алтангэрэл, Х.Баасанжаргал, О.Номинчимэг, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: 1.Монгол Улсын Их Хурлаас Үндсэн цэцийн гишүүнд санал болгосон нэр дэвшигч Жамьянхорлоогийн Сүхбаатарыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 5
Бүгд: 20
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийг дэмжсэнээр тооцож, 80 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Монгол Улсын Их Хурлаас Үндсэн цэцийн гишүүнд санал болгосон нэр дэвшигч Ганбатын Эрдэнэбатыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 5
Бүгд: 20
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийг дэмжсэнээр тооцож, 80 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 19 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга Д.Мөнгөнтуул, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Давааням, мөн газрын Иргэний бүртгэлийн газрын дарга Н.Наранцэцэг, мөн газрын улсын ахлах бүртгэгч Б.Отгон, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Оюунзул, Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Э.Баярбаясгалан, Шүүх шинжилгээний ерөнхий газрын Гадаадын иргэн, харьяатын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Энхсүх, мөн газрын харьяат хариуцсан ахлах мэргэжилтэн С.Солонго нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Г.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-т нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгаагүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсний дагуу санал хураалт явуулав.

Нэг.Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар:

Д.Цогтбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, А.Ариунзаяа, Л.Мөнхбаясгалан, О.Номинчимэг, Ж.Алдаржавхлан, Б.Баярбаатар, Д.Ганмаа, Б.Жаргалан, С.Одонтуяа, У.Отгонбаяр, Д.Пүрэвдаваа, П.Сайнзориг, Л.Соронзонболд, Х.Тэмүүжин, Д.Үүрийнтуяа, Б.Хэрлэн, Х.Баасанжаргал, Г.Хосбаяр /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2.7 дахь заалтын “дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөө” гэснийг “хамтран өмчлөх дундын хөрөнгөө” гэж, 9.1 дэх хэсэг, 9.2.8 дахь заалтын “эд” гэснийг тус тус хасаж, 9.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 9.2 дахь хэсэг болгох:

“9.2.Гэрлэгчид гэр бүлийн харилцаанд дараах үүрэг хүлээнэ:

9.2.1.бие биеэ тэжээн тэтгэх, асран халамжлах;

9.2.2.бие биеийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, зөрчихгүй байх;

9.2.3.гэр бүлийн угийн бичиг хөтлөх;

9.2.4.гэр бүлийн үнэт зүйл, үндэсний соёл, уламжлал, зан заншлыг эрхэмлэх;

9.2.5.хамтын үүрэг, хариуцлагаа ухамсарлан бие биедээ үнэнч байх, гэр бүлийн хамтын амьдралаа тогтвортой байлгах, гэр бүлийн амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 9

Бүгд: 20

55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10 дугаар зүйл.Гэрлэлт дуусгавар болох

10.1.Гэрлэлтийг дараах тохиолдолд дуусгавар болсонд тооцно:

10.1.1.гэрлэгчдийн хэн нэг нь нас барсан;

10.1.2.гэрлэгчдийн хэн нэгнийг нас барсан гэж зарласан, эсхүл сураггүй алга болсон гэж тооцсон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;

10.1.3.Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу гэрлэгчдийн хэн нэг нь хүйсийн өөрчлөлтөө улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн.

10.2.Гэрлэлт дараах тохиолдолд дуусгавар болно:

10.2.1.захиргааны, эсхүл шүүхийн журмаар гэрлэлтээ цуцлуулсан;

10.2.2.гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон.

10.3.Энэ зүйлийн 10.1.3-т заасан хүйсийн өөрчлөлт тухайн хүний хөрөнгийн эрх болон эцэг, эхийн эрхийг хязгаарлах, үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 6
Бүгд: 20
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13 дугаар зүйл.Гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлах

13.1.Энэ хуулийн 12.1-д зааснаас бусад тохиолдолд гэрлэлт цуцлуулах асуудлыг гэрлэгчдийн хэн нэгний, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүйд тооцогдсон эхнэр, нөхрийн асран хамгаалагчийн гаргасан нэхэмжлэлийн үндсэн дээр шүүх шийдвэрлэнэ.

13.2.Энэ хуулийн 10.1.3-т заасны дагуу гэрлэгчдийн хэн нэг нь хүйсийн өөрчлөлтөө иргэний улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, гэрлэлт дуусгавар болсон бол гэрлэлт цуцлахаас бусад хүүхдийн асрамж, тусдаа амьдрах эцэг, эсхүл эхийн хүүхэдтэй уулзах хуваарь, тэтгэлэг, хамтран өмчлөх дундын хөрөнгө хуваах асуудлаар гэрлэгчид нэхэмжлэл гаргах үүрэгтэй бөгөөд эдгээр асуудлыг уг нэхэмжлэлийн үндсэн дээр шүүх шийдвэрлэнэ.

13.3.Гэрлэгчид гэрлэлтийн гэрээнд хөрөнгийн эрх, үүргийг тусгасан эсэхээс үл хамаарч, гэрлэлт цуцлуулах үед хөрөнгийн эрх, үүргийн талаар харилцан тохиролцож болно.

13.4.Гэрлэгчид гэрлэлт цуцлах үед хүүхдийн асрамж, тусдаа амьдрах эцэг, эсхүл эхийн хүүхэдтэй уулзах хуваарь, тэтгэлэг болон хөдөлмөрийн чадваргүй эхнэр, нөхрөө тэжээн тэтгэх, хамтран өмчлөх дундын хөрөнгө хуваах асуудлыг бие даан, эсхүл эвлэрүүлэн зуучлалын журмаар харилцан тохиролцож болно.

13.5.Шүүх гэрлэлт цуцлах шийдвэр гаргахдаа хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаалах бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настан, хөдөлмөрийн чадваргүй, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэр бүлийн гишүүний эрүүл мэндийн байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг харгалзан үзнэ.

13.6.Шүүх гэрлэлт цуцлахдаа нэхэмжлэлийн шаардлагаас үл хамааран дараах асуудлыг шийдвэрлэнэ:

13.6.1.хүүхдийн асрамж;

13.6.2.хүүхдээс тусдаа амьдрах эцэг, эсхүл эхийн хүүхэдтэй уулзах хуваарь /нөхцөл, хэлбэр, байршил, хугацаа/;

13.6.3.тэтгэлгийн хэмжээ, нэмэлт зардал.

13.7.Шүүх энэ хуулийн 13.6.1, 13.6.2-т заасан асуудлыг шийдвэрлэхдээ хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хангаж, дараах нөхцөлийг харгалзан үзнэ:

13.7.1.хүүхдийн нас, бие махбод, оюун санаа, нийгэмшихүй, танин мэдэхүй, сэтгэхүй, хөгжил, сэтгэл зүйн онцлогт нийцсэн хэрэгцээ, шаардлагыг;

13.7.2.хүүхэд долоо, түүнээс дээш настай бол түүний саналыг;

13.7.3.хүүхдийн эцэг, эх, ах, эгч, дүү, эмээ, өвөө болон түүний амьдралд чухал нөлөө бүхий бусад хүнтэй тогтоосон харилцаа, ээнэгшсэн дассан байдал;

13.7.4.эцэг, эхийн хүүхдийг асран хамгаалж, хүмүүжүүлэхэд оролцож байсан оролцооны байдал, эцэг, эхийн халамж, ахуйн нөхцөл, чадавхыг;

13.7.5.хүүхдийг асран хамгаалах, хүмүүжүүлэх, хөгжүүлэх төлөвлөгөө, хүүхэдтэй харилцах чадвар, эцэг, эхийн амьдралын хэв маяг, эрүүл мэнд, эрхэлсэн ажил, ажлын цагийг;

13.7.6.гэрлэгчид хүүхдийн асрамжийн асуудлаар тохиролцсон эсэхийг;

13.7.7.эцэг, эхийн зан байдал, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн эсэх, хүүхдэд үзүүлэх нөлөөг.

13.8.Гэрлэгчид хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд нийцсэн байдлаар өөрөөр тохиролцоогүй бол шүүх энэ хуулийн 13.6.1-д заасан хүүхдийн асрамжийг хэрэгжүүлэхээр тогтоогдсон эцэг, эсхүл эхэд хүүхдийн асуудлаар шийдвэр гаргах эрхийг олгоно.

13.9.Шүүх энэ хуулийн 13.6.3-т заасан тэтгэлгийн хэмжээ, нэмэлт зардлыг энэ хуулийн долдугаар бүлэгт заасны дагуу шийдвэрлэнэ.

13.10.Эвлэрүүлэн зуучлагч эвлэрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагаас мэргэжил, арга зүйн дэмжлэг авч, хамтран ажиллаж болно.

13.11.Эхнэр нь жирэмсэн, эсхүл хүүхэд нь нэг нас хүрээгүй, эсхүл гэрлэгчдийн хэн нэг нь хүндээр өвчилсөн тохиолдолд гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг шүүх хүлээн авахаас татгалзана.

13.12.Гэрлэгчдийн хэн нэгний хүчирхийллээс болж, гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд аюул, хор уршиг учирч болзошгүйн улмаас гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг гаргахад энэ хуулийн 13.11-д заасан нь саад болохгүй.

13.13.Энэ хуулийн 13.11-д заасан нөхцөл байдал арилсан бол гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргаж болно.

Тайлбар:-Энэ хуулийн 13.6.1-д заасан “хүүхдийн асрамж” гэж хүүхдийг хэний асрамжид үлдээх буюу хүүхдийн амьдрах газрыг ойлгоно.

- Энэ хуулийн 13.8-д заасан “хүүхдийн асуудлаар шийдвэр гаргах эрх” гэж хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хүүхэд гадаад улсад зорчих, шашин шүтэх, эс шүтэх, хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх дугуйланд сургах зэрэг хүүхдийн хөгжил, хүүхдийн хуваарьт хөрөнгийг хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор захиран зарцуулах талаар шийдвэр гаргах эрхийг ойлгоно.

-Энэ хуулийн 13.11-д заасан “хүнд өвчтэй” гэж гэрлэгчдийн хэн нэг нь баривчлах шийтгэлээс чөлөөлөх өвчний жагсаалтад заасан өвчтэй бөгөөд шүүхэд гэрлэлт цуцлуулах асуудлыг хэлэлцэх үед өвчин нь хүндэрсэн шатандаа орсны улмаас өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах боломжгүй болох нь эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон байхыг ойлгоно гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	14
Татгалзсан:	6
Бүгд:	20

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15 дугаар зүйл.Шүүх гэр бүлийн нэг гишүүнд ногдох хөрөнгийг тодорхойлох

15.1.Гэрлэлт цуцалснаас гэр бүлийн дундаа хамтран өмчлөх хөрөнгөөс нэг гишүүнд ногдох хэсгийг тодорхойлоход гэрлэлтийн гэрээ, эсхүл гэрлэлтийн гэрээ байгуулаагүй бол Иргэний хуулийн 129, 130 дугаар зүйлд заасны дагуу шүүх шийдвэрлэнэ.

15.2.Гэрлэлтээс гадуурх харилцааны, эсхүл гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэрлэлт цуцалсан, эсхүл гэр бүлийн гишүүний эрүүл мэндийн байдал, хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлын үүднээс гэрлэлт цуцалсан, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон бол Иргэний хуулийн 129.3-т заасны дагуу гэр бүлийн дундаа хамтран өмчлөх хөрөнгөөс нэг гишүүнд ногдох хөрөнгийн хэсгийг тодорхойлохдоо шүүх өөрөөр тогтоож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	14
Татгалзсан:	6
Бүгд:	20

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 24 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24 дүгээр зүйл.Хүүхдэд нэр, эцэг/эх/-ийн нэр, овог өгөх

24.1.Эцэг, эх харилцан зөвшилцсөний үндсэн дээр хүүхдэдээ нэр өгнө.

24.2.Хуульд өөрөөр заагаагүй бол хүүхэд эцгийн овог, нэрийг авна.

24.3.Хүүхдийн эцэг, эх нь гэрлэлтээ бүртгүүлээгүй бөгөөд харилцан тохиролцоогүй, эсхүл хүүхдийн эцгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогоогүй, эсхүл эцэг, эхийн хэн нэгний өмнөх гэрлэлт дуусгавар болоогүй бол эх нь хүүхдэд нэр өгөх бөгөөд хүүхэд эхийн овог, нэрийг авна.

24.4.Хүүхдийн эцэг, эх нь хэн болох нь тогтоогдоогүй бол улсын бүртгэлийн байгууллага хүүхдэд нэр, овог, эцэг /эх/-ийн нэр өгч болно.

24.5.Дараах тохиолдолд хүүхдийн эцэг, эсхүл эхийг тогтоосон эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн хүүхдэд овог, эцэг /эх/-ийн нэр өгнө:

24.5.1.хүүхдийн эцгийг тогтоосон бол эцгийн овог, нэрийг;

24.5.2.эцэг нь тодорхойгүй бөгөөд хүүхдийн эхийг тогтоосон бол эхийн овог, нэрийг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 6

Бүгд: 20

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 32 дугаар зүйл болгох:

“32 дугаар зүйл.Хүүхдийн асрамж, хүүхдээс тусдаа амьдарч байгаа эцэг, эхийн эрх, үүрэг

32.1.Гэрлэлтээ цуцлуулсан, эсхүл бусад шалтгаанаар хүүхдийн оршин суугаа газраас өөр газарт оршин сууж байгаа нь хүүхдийн өмнө хүлээх эцэг, эхийн үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

32.2.Хүүхдийн асрамж, хүүхдийн талаар шийдвэр гаргах болон тусдаа амьдрах эцэг, эсхүл эхийн хүүхэдтэй уулзах хуваарьтай холбоотой гаргасан шүүхийн шийдвэрийг эцэг, эх биелүүлэх үүрэгтэй.

32.3.Хүүхдээс тусдаа амьдрах эцэг, эсхүл эх хүүхдийн талаар мэдээлэл авах эрхтэй.

32.4.Хүүхдийн талаар шийдвэр гаргах эрхтэй эцэг, эсхүл эх нь хүүхдийн асуудлаар гаргасан аливаа шийдвэрийн талаар тусдаа амьдарч байгаа эцэг, эсхүл эхэд мэдээлэл өгөх үүрэгтэй.

32.5.Эцэг, эхийн хэн нэг нь, эсхүл 14 насанд хүрсэн хүүхэд тухайн хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл хүүхдийн асрамж болон хүүхдээс тусдаа амьдарч байгаа эцэг, эсхүл эхийн хүүхэдтэй уулзах хуваарийн талаарх шүүхийн шийдвэрийг өөрчлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

32.6.Гэрлэлтээ цуцлуулсан, эсхүл бусад шалтгаанаар эцэг, эх тусдаа амьдарч байгаа бол энэ хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхэд хэн нэгэндээ саад учруулахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 5
Бүгд: 20
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 49 дүгээр зүйлийг 46 дугаар зүйл болгож, 49.4 дэх хэсгийн “49.1-д” гэснийг “46.1-д” гэж, 49.5 дахь хэсгийн “49.4-т” гэснийг “46.3-т” гэж, 49.8 дахь хэсгийн “хүүхдийн” гэснийг “түүний” гэж тус тус өөрчилж, 49.3 дахь хэсгийг хасаж, 49.1, 49.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 46.1, 46.2 дахь хэсэг болгох:

“46.1.Талууд энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасан тэжээн тэтгэх тухай гэрээ байгуулаагүй бол шүүх энэ хуулийн 46.2-т заасан тэтгэлэг тогтоох аргачлалын дагуу хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг харгалзан тэтгэлэг тогтооно.

46.2.Тэтгэлэг тогтоох аргачлалыг сар, улирал, хагас жил, эсхүл жилээр төлөх тэтгэлгийн хэмжээг тэтгэлэг төлөгчийн хөрөнгө, орлого, тэтгэлэг авагчийн хэрэгцээ, шаардлага, хүүхдийн нас, тоо, хүүхэдтэй уулзах хуваарь зэрэг нөхцөл байдлыг харгалзан хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 7
Бүгд: 20
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 54 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 53 дугаар зүйл болгох:

“53 дугаар зүйл.Шүүхийн шийдвэрээр тогтоосон тэтгэлгийн хэмжээг өөрчлөх, тэжээн тэтгэх үүргээс чөлөөлөх

53.1.Тэжээн тэтгэх тухай гэрээ байгуулаагүй бөгөөд шүүхийн шийдвэрээр тэтгэлгийн хэмжээг тогтоосны дараа энэ хуулийн 44, 45 дугаар зүйлд заасан тэтгэлэг төлөгчийн хөрөнгө, орлого, бусад нөхцөл байдал өөрчлөгдсөн бол тэтгэлэг авагчийн, эсхүл тэтгэлэг төлөгчийн нэхэмжлэлийн үндсэн дээр тэтгэлгийн хэмжээг өөрчлөх эсэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ.

53.2.Шүүх энэ хуулийн 53.1-д заасан асуудлыг шийдвэрлэхдээ энэ хуулийн 46.2-т заасан аргачлалын дагуу дахин тогтооно.

53.3.Эцэг, эх, эсхүл төрлийн хүн нь хүүхдийг энэ хуульд заасан хугацаанд тэжээн тэтгэх, өсгөн хүмүүжүүлэх үүргээ ноцтой зөрчсөн нь шүүхээр тогтоогдсон бол хүүхэд 18 насанд хүрснээс хойш эцэг, эх, эсхүл төрлийн хүнээ тэжээн тэтгэх үүргээс бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн чөлөөлөгдөж болно.

53.4.Тэжээн тэтгүүлэгчийн тэжээн тэтгүүлэх эрхийн үндэслэл арилсан бол энэ хуулийн 43.1-д заасан этгээдийн тэжээн тэтгэх үүрэг дуусгавар болно.

53.5.Тэжээн тэтгүүлэгч нь тэжээн тэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн, хүчирхийлсэн, дарамталсан, гэм хор учруулсан, эсхүл

учруулахаар завдсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон бол тэтгэлэг төлөгчийг тэжээн тэтгэх үүргээс шүүхийн шийдвэрээр чөлөөлнө гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 8
Бүгд: 20
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 66 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 65 дугаар зүйл болгох:

“65 дугаар зүйл.Үрчлэгчийн эрх, үүрэг, хориглох зүйл

65.1.Үрчлэгч нь эцэг, эхийн нэгэн адил энэ хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

65.2.Үрчлэгч нь насанд хүрсэн, иргэний эрх зүйн чадамжтай, эрүүл мэндийн болон эдийн засгийн бүрэн чадавхтай хүн байх бөгөөд ашиг олох зорилгоор хүүхэд үрчлэн авахыг хориглоно.

65.3.Хүүхдийг дараах хүнд үрчлүүлэхийг хориглоно:

65.3.1.бусдын асрамж, дэмжлэгт байгаа хүн;
65.3.2.ганц бие 65, түүнээс дээш настай хүн;
65.3.3.шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн чадамжгүй, эсхүл хязгаарлагдмал чадамжтай гэж тогтоогдсон хүн;

65.3.4.эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, эсхүл хасуулсан хүн;
65.3.5.үрчлэн авсан хүүхдээ өөрийн буруугаас буцаан өгсөн хүн;

65.3.6.согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай хүн;

65.3.7.эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар эцэг, эх байх эрх, үүргийг биелүүлж чадахгүй болох нь тогтоогдсон хүн;

65.3.8.хорих ял эдэлж байгаа, эсхүл Эрүүгийн хуульд заасан хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг болон хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэж, эсхүл Эрүүгийн хуульд заасан бусад гэмт хэрэгт удаа дараа ял шийтгүүлж байсан хүн;

65.3.9.бүртгэлтэй хаяг дээрээ амьдардаггүй, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангахгүй орчинд амьдардаг хүн.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 7
Бүгд: 20
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 68 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 67 дугаар зүйл болгох:

“67 дугаар зүйл.Хүүхэд үрчлэлтийн бүртгэл, хяналт

67.1.Хүүхэд үрчлүүлэх эсэх шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор тухайн шүүх шийдвэрийн хувийг улсын бүртгэлийн болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

67.2.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан нь үрчлэлтийн мэдээллийн сан /хүүхэд үрчлэх хүсэлтэй иргэн, үрчлүүлэх хүүхдийн болон үрчлэгдсэн хүүхэд, үрчилж авсан иргэний мэдээлэл/ бүрдүүлнэ.

67.3.Аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага үрчлэгдсэн хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол хангагдаж байгаа эсэхэд түүнийг 18 насанд хүртэл хагас жил тутамд хяналт тавьж, хүүхдийн хөгжлийн тайланг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

67.4.Энэ хуулийн 67.2-т заасан мэдээллийн сан бүрдүүлэх, энэ хуулийн 67.3-т заасан үрчлэгдсэн хүүхдэд хяналт тавих журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

67.5.Аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага үрчлэгдсэн хүүхдийн эрх зөрчигдсөн нөхцөл байдал бий болсныг тогтоовол хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх үүрэгтэй.

67.6.Сонирхогч тал үрчлэгдсэн хүүхдийн эрх зөрчигдсөн гэж үзвэл үрчлэлтийг хүчингүй болсонд тооцуулах нэхэмжлэлийг шүүхэд гаргах эрхтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	7
Бүгд:	20

65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Төслийн 83 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 82 дугаар зүйл болгох.

“82 дугаар зүйл.Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэх

82.1.Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэхэд Монгол Улсын олон улсын гэрээ, энэ хуулийг дагаж мөрдөнө.

82.2.Монгол Улсын харьяат хүүхдийг Монгол Улсын иргэн үрчлэн авах хүсэлт гаргаагүй бол хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд нийцүүлэн хүүхэд үрчлэн авахаар хүсэлт гаргасан гадаадын иргэн, гэр бүлд үрчлүүлнэ.

82.3.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэх талаар санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий гадаад үрчлэлтийн орон тооны бус зөвлөл /цаашид “Гадаад үрчлэлтийн зөвлөл” гэх/ ажиллана.

82.4.Гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтээ өөрийн орны эрх бүхий байгууллага, эсхүл зөвшөөрөлтэй итгэмжлэгдсэн байгууллагаар дамжуулан Гадаад үрчлэлтийн зөвлөлд гаргана.

82.5.Монгол Улсад 6 сараас доошгүй хугацаанд байнга оршин сууж байгаа гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэн авах хүсэлтээ энэ хуулийн 82.4-т заасан байгууллагаар дамжуулалгүйгээр Гадаад үрчлэлтийн зөвлөлд гаргана.

82.6.Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэн үрчлэн авахад энэ хуулийн 64, 65 дугаар зүйлд заасныг нотлох тайланг өөрийн улсын эрх бүхий байгууллагаас гаргуулж, энэ хуулийн 82.9-д заасан журмын дагуу ирүүлнэ.

82.7.Гадаад үрчлэлтийн зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн улс хооронд хүүхэд үрчлүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэх бөгөөд үрчлэгдсэн эсэх тухай шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш ажлын таван өдрийн дотор улсын бүртгэлийн болон гадаадын иргэний асуудал хариуцсан байгууллага, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

82.8.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол Улсын харьяат хүүхэд үрчлүүлэх тухай шүүхийн шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор үрчлэгчид мэдэгдэж, шийдвэрийн хувийг хүргүүлнэ.

82.9.Энэ хуулийн 82.3-т заасан Гадаад үрчлэлтийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн, гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

82.10.Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх асуудлыг энэ хуульд заасны дагуу шийдвэрлэнэ. Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын харьяат хүүхдийг тухайн улсын хуулийн дагуу үрчлүүлсэн нь Монгол Улсын олон улсын гэрээ, хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд харшлаагүй бол хүлээн зөвшөөрч болно.

82.11.Энэ хуулийн 65.3-т зааснаас гадна Монгол Улсаас албадан гаргасан, Монгол Улсын хилээр нэвтрүүлэхгүй байхаар тогтоосон хугацаа нь дуусаагүй байгаа гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэхийг хориглоно гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	9

Бүгд: 20
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 84 дүгээр зүйлийг 83 дугаар зүйл болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“83 дугаар зүйл.Гадаадын иргэнд үрчлэгдсэн хүүхдэд хяналт тавих

83.1.Гадаадын иргэнд үрчлэгдсэн хүүхдийн мэдээллийг энэ хуулийн 67.2-т заасан үрчлэлтийн мэдээллийн санд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтмол нийлүүлнэ.

83.2.Улс хооронд үрчлэгдсэн хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол хангагдаж байгаа эсэхэд тавих хяналтыг Дипломат төлөөлөгчийн газар хэрэгжүүлнэ. Дипломат төлөөлөгчийн газар байхгүй тохиолдолд Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавьж, мэдээлэл авна.

83.3.Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авсан гадаадын иргэн, гэр бүл нь хүүхдийн хөгжлийн тайланг 18 насанд хүртэл хагас жил тутамд энэ хуулийн 83.2-т заасан байгууллагаар дамжуулан хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад болон гадаадын иргэний харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

83.4.Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын харьяат үрчлэгдсэн хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол зөрчигдсөн байж болзошгүй нөхцөл байдал ажиглагдсан, эсхүл тогтоогдсон бол Дипломат төлөөлөгчийн газар, гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон гадаадын иргэний харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэх үүрэгтэй.

83.5.Гадаад улсад оршин суугаагаас бусад гадаадын иргэнд үрчлэгдсэн Монгол Улсын харьяат хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол хангагдаж байгаа эсэхэд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуульд заасан хяналт тавьж, хүүхэд хөгжлийн тайланг хагас жил тутамд гаргана.

83.6.Гадаад улсад оршин суугаагаас бусад гадаадын иргэнд үрчлэгдсэн Монгол Улсын харьяат хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол зөрчигдсөн байж болзошгүй нөхцөл байдал ажиглагдсан, эсхүл тогтоогдсон бол хүн, хуулийн этгээд нь хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэх үүрэгтэй.

83.7.Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлсний дараа хяналт тавих, үрчлэгч талтай гэрээ байгуулах журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн, гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

83.8.Сонирхогч тал улс хооронд үрчлэгдсэн хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл үрчлэлтийг хүчингүй болсонд тооцуулах нэхэмжлэлийг Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тухайн

хүүхдийг үрчлүүлэх шийдвэр гаргасан шүүхэд гаргаж, шийдвэрлүүлнэ гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 8
Бүгд: 19
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 8¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8¹.1.Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон тухай шүүхийн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүх иргэний улсын бүртгэлд бүртгүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 8
Бүгд: 19
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж 6.1.5, 6.1.6 дахь заалт болгох:

“6.1.5.донорын бэлгийн эс ашиглаж хүүхэд төрсөн бол түүнийг нотлох эмнэлгийн байгууллагын магадлагаа болон хоорондын байгуулсан гэрээ;

6.1.6.донорын бэлгийн эс ашиглан тээгч эхээс хүүхэд төрсөн бол түүнийг нотлох эмнэлгийн байгууллагын магадлагаа болон хоорондын байгуулсан гэрээ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 8
Бүгд: 19
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 5 дахь заалт буюу 6 дугаар зүйлийн 6.19, 6.20 дахь хэсэг нэмэх:

“6.19.донорын бэлгийн эс ашиглаж төрсөн хүүхдийн төрсний бүртгэлийг Гэр бүлийн тухай хуулийн 27.2-т заасан эцэг, эхийн овог, нэрээр бүртгэж төрсний гэрчилгээ олгоно.

6.20.донорын бэлгийн эс ашиглан тээгч эхээс төрсөн хүүхдийн төрсний бүртгэлийг Гэр бүлийн тухай хуулийн 27.2-т заасан эцэг, эхийн овог, нэрээр бүртгэж төрсний гэрчилгээ олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.3.Гэрлэлтийг шүүхийн журмаар цуцалсан бол гэрлэлт цуцалсан тухай шүүхийн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүх иргэний улсын бүртгэлд бүртгүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 9 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9 дүгээр зүйл.Гэрлэлт сэргээсний бүртгэл

9.1.Гэр бүлийн тухай хуулийн 18.1-д заасны дагуу иргэн гэрлэлт сэргээсний бүртгэлд бүртгүүлэх бол дараах баримт бичгийг бүрдүүлж, өөрийн биеэр бүртгүүлнэ:

9.1.1.тус тусдаа гаргасан өргөдөл;

9.1.2.иргэний үнэмлэх, эсхүл иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, эсхүл паспортыг орлох баримт бичиг.

9.2.Гэр бүлийн тухай хуулийн 18.2, 18.3-т заасны дагуу гэрлэлтийг сэргээсэн бол гэрлэлт сэргээсэн тухай шүүхийн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш ажлын гурван өдрийн дотор тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүх иргэний улсын бүртгэлд бүртгүүлнэ.

9.3.Иргэнийг нас барсан гэж зарласан, сураггүй алга болсонд тооцсон шүүхийн шийдвэрийг хүчингүй болсонд тооцох тухай шүүхийн шийдвэрийг энэ хуулийн 9.2-т заасан баримт бичигт хавсаргана.

9.4.Гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцсон бол гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус тооцсон тухай шүүхийн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүх иргэний улсын бүртгэлд бүртгүүлнэ.

9.5.Улсын бүртгэгч, бүртгэлийн ажилтан энэ хуулийн 9.1, 9.2, 9.3, 9.4-т заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор гэрлэлт сэргээсний бүртгэлийг хөтөлнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9

Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлд “Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн” гэсний дараа “7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “8 дугаар зүйлд” гэснийг “5.3-т” гэж, мөн зүйлийн 7.8 дахь заалтын “9 дүгээр” гэснийг “7 дугаар” гэж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн ““нас барсны бүртгэлд” гэснийг “Гэр бүлийн тухай хуулийн 10.1.1, 10.1.2, 10.1.4-т заасан тохиолдол бий болсон” гэж” гэснийг ““Гэрлэгч нас барсны бүртгэлд бүртгэгдсэн” гэснийг “Гэрлэгч нас барсны, эсхүл хүйс өөрчлөгдсөн бүртгэлд, эсхүл нас барсан гэж зарласан, эсхүл сураггүй алга болсонд тооцсон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон” гэж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Д.Цогтбаатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 127 дугаар зүйлийн 127.4, 127.5 дахь заалтыг хасаж, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 127 дугаар зүйлийн 127.7 дахь хэсгийг 127.5 дахь хэсэг болгох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт буюу 517 дугаар зүйлийн 517.3 дахь хэсэг нэмэх:

“517.3.Өвлүүлэгчийг 18 насанд хүртэл тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон бол өвлөх гэрээслэлд өөрөөр заагаагүй тохиолдолд уг этгээд хуульд заасан өвлөх эрхээ алдана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 129 дүгээр зүйлийн 129.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“129.3.Гэрлэлт дуусгавар болсонтой холбоотойгоор гэр бүлийн нэг гишүүнд ногдох эд хөрөнгийг тодорхойлохдоо хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол, гэрлэгчдийн эрүүл мэндийн байдал болон хуульд заасан бусад нөхцөлийг харгалзан шүүх өөрөөр тогтоож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 133 дугаар зүйлийн 133.2 дахь хэсгийн “энэ хууль болон” гэснийг, мөн зүйлийн 4 дэх заалт буюу 517 дугаар зүйлийн 517.1 дэх хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “”127.6”” гэснийг “”127.4”” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Д.Цогтбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “заалт,” гэснийг “заалтын” гэж өөрчилж, “мөн зүйлийн 7, 9 дэх хэсэг, 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 10
Бүгд: 19
47.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “заалт,” гэснийг “заалтын” гэж өөрчилж, “мөн зүйлийн 7, 9 дэх хэсэг, 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Тав.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Д.Цогтбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт буюу Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 1.1.4 дэх заалт нэмэх:

1/6.20 дугаар зүйлийн 1.1.4 дэх заалт:

“1.1.4.хүүхдээ үе тэнгийн дээрэлхэлт үйлдэхээс урьдчилан сэргийлэх үүргээ биелүүлээгүй;” саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн буюу Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 14 дэх хэсгийн “торгох, эсхүл албадан сургалтад хамруулж, долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.” гэснийг “торгоно.” гэж өөрчилж, мөн зүйлийн 14, 15 дахь хэсгийг төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт болгох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 8
Бүгд: 19
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 1.1.4 дэх заалтын дугаарыг “1.1.5” гэж өөрчлөх.” саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9

Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг 3 дугаар зүйл болгох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Зургаа.Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Д.Цогтбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “55.2.1-55.2.6, 55.3.1-55.3.6-д” гэснийг “54.1, 54.2-т” гэж өөрчлөх саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Долоо.Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Д.Цогтбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.7.“бүтэн өнчин хүүхэд” гэж Гэр бүлийн тухай хуулийн 4.1.2-т заасныг.” саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн

гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу санал хураалт явуулав.

Гэр бүлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийн талаар:

Д.Цогтбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 60 дугаар зүйлийг 59 дүгээр зүйл болгож, 60.1.1 дэх заалтын “сурч” гэсний өмнө “хөгжүүлэх,” гэж нэмж, 60.1.3 дахь заалтын “үл хөдлөх эд хөрөнгө, мал, банкинд хадгалуулсан мөнгөн хадгаламж, бусад үнэт зүйлийг” гэснийг “хөрөнгийг” гэж, “тухайн сум, баг, дүүрэг, хорооны” гэснийг “харьяа сум, дүүргийн” гэж, 60.1.4 дэх заалтын “тухайн сум, баг, дүүрэг, хорооны” гэснийг “харьяа сум, дүүргийн” гэж, 60.2.3 дахь заалтын “асрамж,” гэснийг “асран хамгаалалт, харгалзан” гэж, 60.2.4 дэх заалтын “эд хөрөнгийг” гэснийг “хөрөнгийг” гэж, 60.2.5 дахь заалтын “баг, дүүрэг, хорооны” гэснийг “дүүргийн” гэж, 60.3 дахь хэсгийн “бага насны” гэснийг “долоон насанд хүрээгүй” гэж тус тус өөрчилж, 60.2.4 дэх заалтын “, дэнчин тавих” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	4
Бүгд:	17

76.5 хувь буюу гуравны хоёроор дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 75 дугаар зүйлийг 74 дүгээр зүйл болгож, 75.1 дэх хэсгийн “хуулийн зарчимд харшлахгүй бол гэрлэлтийг Монгол Улсад хүчинтэйд тооцно.” гэснийг “хуульд заасан нөхцөлийг хангаж, гэрлэхэд харшлах шалтгаангүй бол Монгол Улсад гэрлэлтийг хүчин төгөлдөр гэж үзэж, хүлээн зөвшөөрнө.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	4
Бүгд:	17

76.5 хувь буюу гуравны хоёроор дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 82 дүгээр зүйлийг 81 дүгээр зүйл болгож, 82.2 дахь хэсгийн “хуулиар асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосон нь энэ хуульд харшлаагүй бол хүчинтэйд” гэснийг “хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий байгууллагын шийдвэрээр асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосон нь энэ хуульд харшлаагүй бол Монгол Улсад хүчин төгөлдөр гэж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	4
Бүгд:	17

76.5 хувь буюу гуравны хоёроор дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 20 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх асуудлын дарааллын 3 дугаарт оруулж хэлэлцүүлэе гэсэн горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 4

Бүгд: 17

76.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул уг хуулийн төслийг хэлэлцэх асуудлын дарааллын 3 дугаарт оруулж хэлэлцэхээр тогтов.

Гурав.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Дүүргийн Эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн шүүгч Н.Одонтуул, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга Д.Мөнгөнтуул, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Оюунзул, Цагдаагийн ерөнхий газрын хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, мөн газрын Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Э.Баярбаясгалан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Г.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Ж.Галбадрах нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал хариулж, тайлбар хийв.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-т нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгаагүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсний дагуу санал хураалт явуулав.

Нэг.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн талаар:

Д.Цогтбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, С.Одонтуяа, Г.Уянгахишиг, О.Алтангэрэл, А.Ариунзаяа, Д.Ганбат, Л.Мөнхбаатар, С.Зулпхар, Д.Пүрэвдаваа, П.Сайнзориг, О.Саранчулуун, Б.Тулга, С.Эрдэнэбат /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан,

“37 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлах багийн сэтгэл зүйч

37.1.Эвлэрүүлэн зуучлах багийн сэтгэл зүйчийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага томилох бөгөөд сэтгэл зүйч нь төрийн захиргааны албан хаагч байна.

37.2.Энэ хуулийн 37.1-д заасан сэтгэл зүйч нь шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагааны эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцож болох бөгөөд ажиллах журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 4

Бүгд: 17

76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал үг хэлэв.

Хоёр.“Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” улсын их хурлын тогтоолын төслийн талаар:

Д.Цогтбаатар:1.Ажлын хэсгийн гаргасан, 1.Төслийн нэрийг “Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” гэж өөрчилж, төслийн 1, 2, 3, 4, 5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

1.Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 1 дүгээр зүйлийн Гурав дахь хэсэг, 2 дугаар зүйлийн Дөрөв дэх хэсгийн хэрэгжилтийг хангуулах, Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасугай:

1/нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн онцлог, зориулалтад нийцсэн, стандартын шаардлага хангасан шүүхийн барилга байгууламж шинээр барих байршил, газрын асуудлыг судалж, шийдвэрлэх;

2/нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн барилга байгууламжийг барихад шаардагдах зардал болон гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх бусад шүүхийн барилгад зориулалтын шүүх хуралдааны танхим, хүүхдээс мэдүүлэг авах тусгай өрөө байгуулах асуудлыг судалж, Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд тусгаж, санхүүжүүлэх арга хэмжээг авах;

3/Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20.1-д заасан Хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн, гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх

ажиллагаан дахь эвлэрүүлэн зуучлах багийн сэтгэл зүйч, мэргэжилтэнд холбогдох зардлыг Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд тусгаж, санхүүжүүлэх;

4/гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах, шүүхийн цахим үйлчилгээний үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хэрэг, маргааныг шуурхай, үр дүнтэй шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэхэд шаардагдах зардлыг Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд тусгаж, санхүүжүүлэх.

2.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи /Д.Эрдэнэчимэг/-д даалгасугай:

1/гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийг мэргэшүүлэн шинээр батлагдсан хууль тогтоомж, хүүхэд, гэр бүлийн чиглэлээр сургаж, бэлтгэх;

2/нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны шүүх болон дүүргийн, сум, сум дундын анхан шатны шүүхийн эвлэрүүлэн зуучлалын багт ажиллах шүүгчийг сургах арга хэмжээ авах.

3.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Шүүхийн ерөнхий зөвлөл /П.Золзаяа/-д даалгасугай:

1/Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20.1-д заасан хүүхэд, гэр бүлийн мэргэжилтнийг сургах;

2/гэр бүлийн маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах эвлэрүүлэн зуучлагчийг мэргэшүүлэн сургах;

3/гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь эвлэрүүлэн зуучлах багийн сэтгэл зүйчийг мэргэшүүлэх, давтан сургах сургалтын хөтөлбөрийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага /Б.Баярсайхан/-тай хамтран баталж, хэрэгжүүлэх.

4.Өсвөр насны хүнд авсан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж, бэлтгэл ажил хангахыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага/ Б.Баярсайхан/, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар /А.Намсаманд/-т тус тус даалгасугай.

5.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуультай хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль батлагдсантай холбогдуулан хугацаанаас өмнө суллагдах сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял эдэлж байгаа өсвөр насны хүний талаар санал гаргаж, танилцуулахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар /А.Намсаманд/, суллагдсан өсвөр насны хүнд хяналт, тавьж холбон зуучлах үйлчилгээ үзүүлэхийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага/ Б.Баярсайхан/, хүүхдийн эрхийн хууль зүйн хороонд тус тус даалгасугай.

6.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэгт заасан хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн хэрэг, маргаанд шинжээчийн дүгнэлт гаргах мэргэжилтнийг бэлтгэх, сургах, гэрчилгээжүүлэх ажлыг 2026 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор хамтран хэрэгжүүлэхийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Шүүхийн ерөнхий зөвлөлд тус тус даалгасугай.

7.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсэгт заасан “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгааллын журам”-ыг 2026 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор баталж, хэрэгжүүлэхийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Улсын ерөнхий прокурор, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргад тус тус даалгасугай.

8.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 25.3 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу арван зургаан насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах ажиллагааг явуулахад шаардагдах дуу-дүрсний бичлэг хийх зориулалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг бэлтгэх, шинэчлэх асуудлыг судалж, Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд тусгаж, шийдвэрлэх арга хэмжээ авахыг холбогдох байгууллагын удирдлагуудад даалгасугай.

9.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 37 дугаар 37.2 дахь хэсэгт заасан эвлэрүүлэн зуучлах багийн сэтгэл зүйчийн ажиллах журмыг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор баталж, хэрэгжүүлэхийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд даалгасугай.

10.Гэрлэлт цуцлах, хүүхдийн асрамж, эцэг, эсхүл эх хүүхэдтэй уулзах хуваарь болон тэтгэлэг тогтоох, хөрөнгөтэй холбоотой болон бусад гэр бүл, хүүхдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох хуульч, өмгөөлөгчийг мэргэшүүлэн сургах арга хэмжээ авахыг Монголын хуульчдын холбооны ерөнхийлөгч /М.Мөнхбат/, Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч /Л.Данзанноров/-т зөвлөсүгэй.

10.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Д.Цогтбаатар/-нд даалгасугай.

11.Энэ тогтоолыг 2026 оны 07 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	4
Бүгд:	17
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.	

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу санал хураалт явуулав.

Гурав.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Д.Цогтбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, “3 дугаар зүйл” болгон өөрчлөх:

“3 дугаар зүйл.Эрүүгийн хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/8.6 дугаар зүйл:

“8.6 дугаар зүйл.Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах

1.Шүүх энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг арван хоёр жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно.

2.Өсвөр насны хүний шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан бол энэ хуулийн 7.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, 8.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үүрэг хүлээлгэж, хязгаарлалт тогтоох хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авна.

3.Өсвөр насны хүнд шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулж хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх байгууллага хамтран хэрэгжүүлэх талаар шүүхийн шийдвэрт тусгана.

4.Өсвөр насны хүний шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацааны 50 хувь өнгөрсөн, шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлж, эрхийн хязгаарлалтыг зөрчөөгүй бол цаашид хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх шаардлагагүй талаарх прокурорын дүгнэлтийг үндэслэн хугацаанаас өмнө эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно.

5.Өсвөр насны хүн шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

6.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүн шүүхээс тогтоосон хугацаанд хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, тогтоосон хязгаарлалтыг зөрчсөн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, ялыг биечлэн эдлүүлэх тухай шийдвэр гаргана.

7.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд өсвөр насны хүн санаатай гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд энэ хуулийн 6.9 дүгээр зүйлд заасныг баримтлан ял оногдуулна.

8.Шүүх прокурорын дүгнэлтийг үндэслэн өсвөр насны хүнд шүүхийн шийтгэх тогтоолыг хойшлуулсан хугацаанд хүлээлгэсэн энэ хуулийн 8.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үүрэг, хязгаарлалтыг өөрчилж болно.

2/8.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

2.Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг гэм бурууг нь ухамсарлуулах, хохирлыг нөхөн төлүүлэх, хөдөлмөрлөх, амьдрах зөв арга барилд сургах, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор энэ хуулийн 7.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан үүрэг, хязгаарлалтаас гадна дараах үүрэг, хязгаарлалтыг хүлээлгэнэ:

2.1.өсвөр насны хүнд болон түүний гэр бүлд сэтгэл зүйчээс зөвөлгөө, эмчилгээ авахыг даалгах;

2.2.нийгэмд чиглэсэн сайн дурын үйл ажиллагаанд хамруулах;

2.3.хичээлийн ирцээ тогтмол хүргүүлэхийг даалгах;

2.4.хохирогчоос уучлал хүсэхийг даалгах;

2.5.шөнийн цагаар гэртээ байхыг даалгах;

2.6.өсвөр насны хүнийг хүмүүжүүлэхэд шаардлагатай бусад.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 5

Бүгд: 17

70.6 хувь буюу гуравны хоёроор дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 20 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8
Бүгд: 17
52.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Тулга Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 20 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8

Бүгд: 17
52.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 20 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 20 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай төсөл /Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал

эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 21 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Найм.Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 7

Бүгд: 17

58.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 21 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Ес.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 2 дугаар зүйлтэй хобогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл үг хэлэв.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 8

Бүгд: 16

50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Тулгын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Тулгын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	7
Бүгд:	16

56.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: Байнгын хорооны дарга Д.Цогтбаатарын гаргасан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	7
Бүгд:	16

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 21 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Арав.Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, **анхны хэлэлцүүлэг**/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 21 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Арван нэг.Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн

Г.Уянгахишиг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 21 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Арван хоёр.Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах газрын дарга Б.Эрхэмбаяр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, мөн газрын Нийтийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Лхагвацэнд, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, мөн газрын Гэмт хэрэг, зөрчил шалгах албаны хэлтсийн дарга Б.Шинэбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Г.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-т нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгаагүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсний дагуу санал хураалт явуулав.

Нэг.Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Д.Цогтбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, М.Нарантуяа-Нара, О.Номинчимэг, П.Сайнзориг, Х.Тэмүүжин, Г.Уянгахишиг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 6 дугаар зүйлийн 6.5.10 дахь заалтыг хэвээр үлдээх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн

Х.Баасанжаргал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 20 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Арван гурав.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 37 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Г.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 20 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Арван дөрөв.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Н.Энхбаяр, Л.Гангэрэл, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга М.Санжаадорж, мөн газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төрийн сангийн газрын дарга О.Хуягцогт, мөн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Баяр-Эрдэнэ, М.Алтанхорол, Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Н.Отгонбаяр, мөн газрын ахлах шинжээч Б.Хатантуул, Б.Болормаа, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга П.Золзаяа, мөн зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтулга, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Наранбилэг, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг, ахлах нягтлан бодогч Д.Сүглэгмаа, Шүүхийн сахилгын хорооны дарга С.Энхтөр, мөн хорооны Ажлын албаны дарга Д.Мөнхзориг, Ерөнхий нягтлан бодогч Б.Ариунжаргал, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, мөн комиссын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Ихтамир, Санхүү, хөрөнгө оруулалтын тасгийн дарга, ерөнхий нягтлан бодогч Б.Бадамсэрээжид, Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга З.Баасанням, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын нарийн бичгийн дарга Ч.Цасчихэр, мөн комиссын Ажлын албаны дарга

Л.Очирсүрэн, Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албаны дарга Д.Батчулуун, мөн газрын Санхүүгийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч М.Ралдийжамц, Хил хамгаалах ерөнхий газрын дарга Ж.Бямбасүрэн, мөн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чойжилсүрэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга А.Намсаманд, мөн газрын Санхүү, үйлдвэр хөрөнгө оруулалтын газрын дарга Т.Өнөртуяа, Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Энх-Од, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Давааням, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга Д.Чулуунбат, мөн прокурорын Санхүү, аж ахуйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Энхнаран, Шүүх шинжилгээний ерөнхий газрын Санхүү, хангамжийн газрын дарга Н.Алтансүх, мөн газрын Санхүү, төлөвлөлт хангамжийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодлогч Т.Батцэцэг, Гадаадын иргэн, харьяатын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Энхсүх, мөн газрын Санхүү, хангалт үйлчилгээний газрын дарга Ж.Солонгоо, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Н.Жамъянхүү, мөн хүрээлэнгийн Захиргаа, удирдлагын хэлтсийн ахлах нягтлан бодогч Н.Уранчимэг, Архивын ерөнхий газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Лхамсүрэн, Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн дарга Т.Ганзориг, мөн төвийн Захиргаа удирдлагын газрын Санхүү, ар талын тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Н.Уянга, Дотоод хэргийн их сургуулийн захирал Т.Сүхбаолд, мөн сургуулийн Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга Т.Гантулга, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн Төлөвлөлт, үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал Д.Баярсайхан, мөн эмнэлгийн Санхүү, хангамжийн албаны дарга М.Мөнхбаяр, Хууль зүйн туслалцааны төвийн дарга Л.Уянга, мөн төвийн ахлах нягтлан бодогч Л.Болор-Эрдэнэ, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Н.Цэвэлмаа, мөн газрын аудитын менежер Б.Долорсүрэн, С.Нацагдорж, Нийцлийн аудитын газрын дарга Б.Баттуяа, Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан, мөн газрын аудитын менежер Д.Цэгмиддорж, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Ч.Цэвэгдорж, Гүйцэтгэлийн аудитын газрын ахлах аудитор У.Оюунхүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Г.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Гүйцэтгэлийн тайланг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч З.Цэдэнжав нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, Да.Цогтбаатар нарын тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын Санхүү, хөрөнгө оруулалтын тасгийн дарга, ерөнхий нягтлан бодогч Б.Бадамсэрээжид, Гадаадын иргэн, харьяатын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Энхсүх, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын нарийн бичгийн дарга Ч.Цасчихэр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Да.Цогтбаатар нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 21 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Арван тав.“Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Г.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 21 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Арван зургаа.Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо болон Хүний эрхийн Үндэсний Комиссын 2027 оны төсвийн төслийн талаар хэлэлцэх

16.1.Улсын дээд шүүхийн төсвийн төслийн талаар:

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг, ахлах нягтлан бодогч Д.Сүглэгмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Г.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Улсын дээд шүүхийн 2027 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: Улсын Дээд шүүхийн 2027 оны төсвийн төслийн Хууль зүйн байнгын хороогоор хянагдсан хувилбарыг хасагдуулахгүйгээр улсын төсөвт нэгтгүүлэхээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын дээд шүүхийн 2027 оны төсвийн төслийг хэлэлцэж дууслаа.

16.2.Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсвийн төслийн талаар:

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга П.Золзаяа, мөн зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтулга, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Наранбилэгнар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Г.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2027 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга П.Золзаяа танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, П.Сайнзориг, Б.Тулга нарын тавьсан асуултад Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга П.Золзаяа нар хариулж, тайлбар хийв.

Д.Цогтбаатар: Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2027 оны төсвийн төслийн Хууль зүйн байнгын хороогоор хянагдсан хувилбарыг хасагдуулахгүйгээр улсын төсөвт нэгтгүүлэхээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2027 оны төсвийн төслийг хэлэлцэж дууслаа.

16.3.Шүүхийн сахилгын хорооны төсвийн төслийн талаар:

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн сахилгын хорооны дарга С.Энхтөр, мөн хорооны Ажлын албаны дарга Д.Мөнхзориг, Ерөнхий нягтлан бодогч Б.Ариунжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Г.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Шүүхийн сахилгын хорооны 2027 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг Шүүхийн сахилгын хорооны дарга С.Энхтөр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: Шүүхийн сахилгын хорооны 2027 оны төсвийн төслийн Хууль зүйн байнгын хороогоор хянагдсан хувилбарыг хасагдуулахгүйгээр улсын төсөвт нэгтгүүлэхээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 6

Бүгд: 16

62.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Шүүхийн сахилгын хорооны 2027 оны төсвийн төслийг хэлэлцэж дууслаа.

16.4.Хүний эрхийн Үндэсний комиссын төсвийн төслийн талаар:

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, мөн комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Ш.Үнэнтөгс, Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Ихтамир, Санхүү, хөрөнгө оруулалтын тасгийн дарга, ерөнхий нягтлан бодогч Б.Бадамсэрээжид нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Г.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Хүний эрхийн Үндэсний комиссын 2027 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг Хүний эрхийн Үндэсний комиссын дарга Д.Сүнжид танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, С.Одонтуяа, М.Нарантуяа-Нара нарын тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний комиссын дарга Д.Сүнжид хариулж, тайлбар хийв.

Д.Цогтбаатар: Хүний эрхийн Үндэсний комиссын 2027 оны төсвийн төслийн Хууль зүйн байнгын хороогоор хянагдсан хувилбарыг хасагдуулахгүйгээр улсын төсөвт нэгтгүүлэхээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хүний эрхийн Үндэсний Комиссын 2027 оны төсвийн төслийг хэлэлцэж дууслаа.

Уг асуудлыг 23 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Арван долоо. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Х.Тэмүүжин нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: “Монгол Улсын шүүхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 8
Бүгд: 16
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: “Монгол Улсын шүүхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, Х.Баасанжаргал, П.Сайнзориг, Г.Уянгахишиг, Х.Тэмүүжин нар ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 23 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Арван найм. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: “Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, М.Нарантуяа-Нара, Д.Пүрэвдаваа, С.Эрдэнэболд нар ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 23 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Арван ес. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: “Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 6

Бүгд: 16

62.5 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Д.Ганбат, Г.Уянгахишиг, Д.Пүрэвдаваа нар ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 23 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 19 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 5 цаг 51 минут үргэлжилж, 28 гишүүнээс 21 гишүүн хүрэлцэн ирж, 75.0 хувийн ирцтэйгээр 23 цаг 46 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН

БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН

БАЙГУУЛАХ ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2026 оны 06 дугаар сарын 24-ний өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Үндсэн хууль” танхим 17 цаг 55 минут

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Д.Цогтбаатар: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2026 оны 6 дугаар сарын 24-ний хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя аа. Дамдины Цогтбаатар, Оюунсайханы Алтангэрэл, Хүрэлбаатарын Баасанжаргал, Жудгийн Баярмаа, Дашдондогийн Ганбат, Мөнхтөрийн Нарантуяа, Салдангийн Одонтуяа, Даваахүүгийн Пүрэвдаваа, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Буяагийн Тулга, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Даваагийн Цогтбаатар, Саруулсайханы Цэнгүүн гэсэн гишүүдийн ирцтэйгээр 53.6 хувийн ирцтэйгээр ирц бүрдсэн байна аа.

Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдөр гишүүд нэлээн идэвхтэй оролцох хэрэгтэй байгаа. Би сая нээрээ гишүүдийн ирцийг танилцуулсан дээр нэмээд Их Хурлын дарга Бямбацогт дарга өнөөдөр манай хуралдаан дээр эхний асуудлыг танилцуулахаар орж ирсэн байгаа. Энийг дурдахыг хүсэж байна.19 асуудал байгаа.

1 дүгээр асуудал ҮХЦ гишүүнээр томилуулах асуудал орж ирж байгаа.

2.Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд,

3.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл,

4.Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл анхны хэлэлцүүлэг байгаа. Түрүүн Нийгмийн даатгалын хууль бас анхны хэлэлцүүлэг байгаа.

5.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл *анхны хэлэлцүүлэг* байгаа.

6.Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, *анхны хэлэлцүүлэг*

7.Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, *анхны хэлэлцүүлэг*

8.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, *анхны хэлэлцүүлэг*,

9.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл энэ 2 дахь хэлэлцүүлэг байгаа.

10.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд, эцсийн хэлэлцүүлэг,

11.Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, анхны хэлэлцүүлэг/,

12.Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл анхны хэлэлцүүлэг,

13.Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, эцсийн хэлэлцүүлэг,

14.“Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

15.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, эцсийн хэлэлцүүлэг,

16.Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо болон Хүний эрхийн Үндэсний Комиссын 2027 оны төсвийн төслийн талаар хэлэлцэх,

17.Байнгын хорооны тогтоолын төсөл */Ажлын хэсэг байгуулах тухай/*;

18. Байнгын хорооны тогтоолын төсөл */Ажлын хэсэг байгуулах тухай/*;

19.Байнгын хорооны тогтоолын төсөл */Ажлын хэсэг байгуулах тухай/*;

20.Бусад асуудал гэсэн ийм юу асуудлууд хэлэлцэхээр байгаа.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байвал саналаа өгье. Алга байна аа.

Одоо 1 дүгээр асуудлаа хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлаас ирүүлсэн Монгол Улсын ҮХЦ-ийн гишүүнээр томилуулах саналыг хэлэлцэж эхэлье.

ҮХЦ-ийн гишүүнээр томилуулах тухай захирамжийг Улсын Их Хурлын дарга Сандагийн Бямбацогт танилцуулна аа.

Бямбацогт даргад микрофон өгье өө.

С.Бямбацогт: Хууль зүйн байнгын хорооны эрхэм гишүүдийн оройн амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын даргын захирамжийг танилцуулъя. ҮХЦ-ийн гишүүнээр томилуулах тухай. 2026 оны 6 дугаар сарын 24-ний өдөр.

Монгол Улсын үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2026 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн санал, дүгнэлт.

Мөн Байнгын хорооны 2026 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн Улсын Их Хурлын 06/7588 дугаартай албан бичгийг үндэслэн захирамжлах нь:

Жамьянхорлоогийн Сүхбаатар, Ганбатын Эрдэнэбат нарыг ҮХЦ-ийн гишүүнээр томилуулахаар Улсын Их Хуралд санал болгосугай.

Д.Цогтбаатар: Бямбацогт даргад баярлалаа.

Одоо нэр дэвшигч Жамьянхорлоогийн Сүхбаатарын танилцуулгыг Улсын Их Хурлын дарга Сандагийн Бямбацогт танилцуулна аа. Бямбацогт даргын микрофоныг өгье.

С.Бямбацогт: Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын ҮХЦ-ийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1. 2 дахь хэсэгт заасныг үндэслэн ҮХЦ-ийн гишүүнд Жамьянхорлоогийн Сүхбаатарын нэрийг дэвшүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд санал танилцуулж байна аа.

Жамьянхорлоогийн Сүхбаатар 1975 онд одоогийн Дархан-Уул аймгийн Дархан сум буюу Дархан хотод төрсөн. Ам бүл 2, Ж.Сүхбаатар 1993 онд Дархан хотын 3 дугаар дунд сургууль, 1997 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр, 1999 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг Хууль зүйн ухааны магистрын зэрэгтэй төгссөн. АНУ, Швед, Казахстан зэрэг улсад мэргэжлийн болон бусад сургалтад хамрагдсан. Нийтийн эрх зүйн буюу захиргааны эрх зүй, сонгуулийн эрх зүйгээр мэргэшсэн судалгаа хийдэг, докторант. Ж.Сүхбаатар 1997-2005 онд Улаанбаатар эрдэм дээд сургуульд Захиргааны эрх зүйн багш, ахлах багш, 1997-1999 онд Улсын Их Хурлын гишүүний орон тооны ажилтан, 1999-2001 онд Улсын Их Хурал дахь МАХН-ын бүлгийн ажлын албанд хуулийн бодлогын зөвлөх, 2001-2006 онд Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, нарийн бичгийн дарга, 2006-2008 онд ЗГХЭГ-ын Тэргүүн дэд дарга, 2008-2012 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, 2012-2013 онд МАН-ын удирдах зөвлөлийн гишүүн, намын нарийн бичгийн дарга, 2016 онд МАХН-ын ЕНБД, 2019-2020 онд Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх, 2020-2024 онд Улсын Их Хурлын гишүүн, 2020-2022 онд Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн бүлгийн дэд дарга, 2022-2023 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга, 2025 оны 12 дугаар сараас 2026 оны 4 дүгээр сар хүртэл Улсын Их Хурлын даргын Хууль зүйн бодлогын зөвлөх, 2026 оны 4 дүгээр сараас Ерөнхий сайдын Хууль зүйн бодлогын зөвлөхөөр тус тус ажиллаж байна аа. Ж.Сүхбаатар төрийн албанд 20 гаруй жил ажилласан бөгөөд төрийн, улс төрийн захиргааны тусгай албанд удирдах болон өндөр албан тушаалд удаа дараа

сонгогдох буюу томилогдон ажилласан, төрийн ажлын өргөн мэдлэг туршлагатай. Ж.Сүхбаатарыг төрийн ажлын эрх зүй, онол практик, өндөр мэдлэг чадварт бэлтгэгдсэн туршлагыг үндэслэн ҮХЦ-ийн гишүүнд нэр дэвшүүлж байна аа.

Д.Цогтбаатар: Одоо нэр дэвшигч Ганбатын Эрдэнэбатын танилцуулгыг Улсын Их Хурлын дарга Бямбацогт танилцуулна аа. Бямбацогт даргын микрофоныг өгье.

С.Бямбацогт: Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын ҮХЦ-ийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын ҮХЦ-ийн гишүүнд Ганбатын Эрдэнэбатыг нэр дэвшүүлэхээр ХЗБХ-оос санал танилцуулж байна аа.

Монгол Улсын ҮХЦ-ийн гишүүнд нэр дэвшигч Ганбатын Эрдэнэбат нь 1972 онд Улаанбаатар хотод төрсөн, 54 настай, эхнэр, 2 хүүхдийн хамт амьдардаг. Г.Эрдэнэбат нь 1990 онд ерөнхий боловсролын 31 дүгээр дунд сургууль, 1994 онд Цагдаагийн дээд сургуулийг Эрх зүйч мэргэжлээр, 1997 онд БХИС хууль зүйн магистр зэрэгтэй төгссөн, 1998-2000 онд ОХУ-ын Уралын Хуулийн академид Эрүүгийн эрх зүй криминологийн чиглэлээр аспирантурт суралцсан. Г.Эрдэнэбат 1994-1995 онд хилийн цэргийн ангид офицер, 1996-1998 онд БХИС-д багш, 1998-2000 онд ХХЕГ-т хуулийн зөвлөх, 2000-2005 онд МУИС-ийн Хууль зүйн сургуульд багш, 2005-2009 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийн сургалтын албаны дарга, 2009-2010 онд Ерөнхийлөгчийн Тамгын газарт Хуулийн асуудал хариуцсан туслах, 2010-2013 онд Ерөнхий прокурорын газарт хэлтсийн дарга, 2013-2019 онд Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогч, 2019-2022 онд Монголын Криминалистикийн холбооны ерөнхийлөгч, 2021-2023 онд Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн ажлын албанд ахлах референт, 2024-2025 онд Улсын Их Хурлын Тамгын газарт ажилтан, 2026 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс Улсын Их Хурлын Тамгын газрын дэд даргаар ажиллаж байна аа.

Г.Эрдэнэбатын төрийн алба болон эрдэм шинжилгээ, судалгаа боловсролын байгууллагад ажилласан туршлагыг үндэслэн ҮХЦ-ийн гишүүнээр нэр дэвшүүлж байна аа. Баярлалаа та бүхэндээ.

Д.Цогтбаатар: Их Хурлын даргад баярлалаа.

Танилцуулга болон нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүд байвал нэрсээ өгнө үү. Тулга гишүүнээр тасаллаа.

Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Баярлалаа. Тэгээд яваад л томилогдох байх. 2, 3 зүйл дээр байр суурь асууя гэж бодож байна. Үндсэн хуулийн хууль тогтоомжуудыг шинэчлэх асуудал яригдаж байгаа. Та бүгд мэдээлэлтэй байгаа байх аа. Хүний үндсэн эрхийн маргааныг ҮХЦ-ээр хянадаг болох энэ асуудал дээр нэр дэвшигчид маань ер нь ямар байр суурьтай байдаг юм бол оо?

Нэгдүгээрт энийг тодотгож хэлж өгөөч?

Хоёрдугаарт ҮХЦ-ээр хянагдах асуудлын хүрээ хязгаар болоод, эсвэл субъектийг тодорхой Үндсэн хуульд заачихсан байдаг. Ер нь зүгээр яах вэ өнөө

маргаашдаа биш ч гэсэн ер нь ямар субъектүүд энэ дээр хаягдчихсан гэж боддог эсвэл илүүдэж байна гэж боддог вэ? Ялангуяа ИТХ буюу иргэдийн Төлөөлөгчдийн Хурал аймаг нийслэлийн ИТХ-ийн шийдвэрүүдийг парламент хянахгүй гэдэг зүйлийг цэц шийдчихсэн. Дээд шатны байгууллага нь парламент биш ээ. Тийм учраас нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага бол түүндээ хууль тогтоомжийн дагуу шийдвэрээ гаргаж болно оо гэдэг. Гэтэл энийг Захиргааны ерөнхий хуулиар явахаар зарим улс төрийн гэдэг юм уу, зарим шийдвэрүүд нь хянагдахгүй. Тэгэхээр ийм зүйлүүдийг мухарлаж шийддэг нь Цэц л байх ёстой. Эсвэл бусад улс оронд нэгж хоорондын маргааныг 2 аймгийн хоорондох маргааныг Дээд шүүх нь шийддэг улсууд байна шүү дээ Америкт жишээ нь 2 мужийн хоорондох маргааныг.

Тэгэхээр ийм жишгүүдийг юу гэж боддог вэ? Тэгээд ер нь бас энэ дээр нэг тодорхой байр сууриа хэлээч?

Хоёрдугаарт ер нь та Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилогдвол илүү их үгчилж тайлбарлах асуудлыг та дэмждэг үү? Эсвэл утга агуулгыг дэлгэрүүлж тэр үзэл санааг ярьж тайлбарлах буюу оригинал болон аноригиналын алийг нь та барьдаг вэ? Үндсэн хуульд тайлбарлах арга зүй дээр. Илүү их алийг дэмжиж явдаг вэ? Ийм 3 асуулт дээр 2 нэр дэвшигч хариулж өгөөч ээ.

Д.Цогтбаатар: Нэр дэвшигч хоёулангаас нь асуулаа гэж ойлголоо. Зөв үү? Сүхбаатар гишүүнээс эхлэх үү?

Ж.Сүхбаатар: Эхний асуулт Сайнзориг гишүүний асуултад яг одоо бол хууль тогтоогч энэ асуудлыг ярьж байгаа ийм цаг үе. Тэгээд Цэцийн гишүүн би болоогүй байгаа учраас тодорхой хэмжээнд хэлж болох байх л даа. Тэрнээс дараа маргаан үүсэж магадгүй учраас Цэцийн хууль тогтоомжоор урьдчилаад Цэцийн гишүүн бол ямар нэгэн байр суурь хэлж болдоггүй. Тэгэхдээ яг ингээд нэр дэвшигчийн хувьд хэлэхэд бол энэ байж болно. Яагаад гэхээр үндсэн эрх эрх чөлөөг Германы тэр маягаар нэлээн тодорхой нөхцөлөө зөв тавиад тэр Германд чинь 3 нөхцөл байгаа байх. Тэр гипотизо сайн тавьж өгөөд ингээд эцсийн найдвар ҮХЦ дээр найдвар очдог энэ байх энэ зарчмыг тэр утгаараа би дэмждэг ээ. Тэгэхдээ энийг хууль тогтоогч их маш сайн нарийвчилж тооцохгүй бол Дээд шүүхийн дээд шүүх болчхож болохгүй.

2 дахь асуудал бол хянах хүрээ хязгаар хаягдсан илүүдсэн дээр таны хэлдэг үнэн бол яг энэн дээр тухайн үед 1992 онд батлагдсан учраас хэд хэдэн газруудыг миний бодлоор өнөөдрийн хуульч зүгээр биеэ даасан сүхбаатар гэдэг хүний бодлоор бол улс төрийн намыг юун түрүүн орхигдуулсан байдаг. Бусад улс орнуудын хамгийн гол юм бол Үндсэн хуулийн байгууллагыг Үндсэн хуулийн эсрэг улс төрийн бүлэглэлүүдээс хамгаалах ёстой байдаг. Тэр тусмаа Үндсэн хуулийн бус үйл ажиллагаа явуулж байгаа намуудыг бол Үндсэн хуулийн шүүх нь хязгаарлаж зогсоодог. Энэ нийтлэг зүйл бол орхигдсон байдаг. Ер нь бол улс төрийн нам цэцээс ч төдийгүй шүүхийн хяналтаас ч гараад удаан явсан байсан. Ийм байсан. Таны хэлж байгаатай санал нэг байгаа нь ИТХ, Засаг дарга нарын асуудал орхигдсон. Тэгээд ер нь яах вэ хууль тогтоогч байхад зарим хуульч нарын хэлж байснаар АТГ мэтийн ийм шинэ байгууллагууд бол ерөнхийдөө ҮХЦ-ийн гадуур хяналтгүй байгаа гэдэг асуудал яригддаг. Энэ бол хууль тогтоогч улсууд бол сайн бодож болох байх асуудал байх.

Миний хувьд бол хянах хүрээ хязгаар бол одоо илүүдээгүй харин орхигдсон гэж ингэж боддог. Тэр аймгуудын хоорондох маргаантай холбоотой асуудлууд гэж байна. Ер нь цаашдаа бол том аймгуудыг томсгох бодлого, сумдыг томсгох бодлогын хүрээнүүд гарахаар эрх мэдэл нэлээн том болоод ирэхээр нийслэлийн ч гэдэг юм уу Засгийн газартай харилцах харилцаа эд нар болоод ирэхээр энэ цэц бол хүлээн авч шийдэх тэр байдал байж болно оо. Энийг бол захиргааны шүүгч шийдэх боломжтой байгаа. Тэгээд энэ бол хууль тогтоогчийн эрх мэдлийн хүрээнд шийдэгдэх асуудал гэж бодож байна.

Гурав дахь асуудал дээр үгчилж тайлбарлах утгачлах гэж байна. Энийг бол ҮХЦ өөрөө хамтын удирдлагын байгууллага. Цаашдаа ямар шийдвэр гаргах юмыг мэдэхгүй учраас зүгээр аль аль нь бол сайн ч тал байна, муу ч тал байна. Тэгэхдээ мэдээж илүү онолын тайлбарыг илүү дэмждэг хүний хувьд бол илүү утгачлах тэр тал дээр шинжлэх ухааны тайлбар талдаа илүү гарах нь зөв байх аа. Үгчлэхэд бол их осолтой. Тэгэхдээ ҮХЦ-ийн тухайн үеийн улсууд юу гэж үзэхийг би хэлж мэдэхгүй.

Д.Цогтбаатар: Эрдэнэбат нэр дэвшигчийн микрофоныг өгье.

Г.Эрдэнэбат: Баярлалаа. Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Энэ аливаа улс орны нийгмийн хөгжлөө дагаад угаасаа хуулийн шинэчлэл бол байнга тасралтгүй явагдах ёстой. Монгол Улсын ҮХЦ-ийн тухай хууль, Цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль олон жил гар хүрэлгүй өнөөдрийг хүрлээ. Энэ цаг хугацааны шалгуураа ч бодсон тэр өнөөдөр нийгэмд тулгамдаж байгаа асуудлаа ч харсан тэр судлаачийн хувьд бол ҮХЦ-ийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага үүссэн байх аа. Энэ дээр яг таны хөндөөд байгаа хүний үндсэн эрхийн маргааны асуудал бол ҮХЦ-ийн хяналтад зайлшгүй орох ёстой гэж судлаачийн хувьд боддог. Яагаад гэвэл энэ өөрөө Монгол Улсын Үндсэн хуулийн нэг том бүлэг бүхэлдээ Үндсэн хуулийн хамгаалалтад байж чадахгүй байгаа ийм асуудал бий. Тэгэхдээ яг сая нэр дэвшигч Сүхбаатарын хэлсэнчлэн үндсэн эрхийн маргааныг ҮХЦ-ийн хяналтад оруулахдаа шүүхийн хяналтад байх ёстой асуудалтай нь харгалзуулаад энэ давхардал үүсгэх юм бол их том эрх мэдлийн зөрчилдөөн үүснэ.

Тийм учраас бид нар бол энэ дээр та бүхнийг бол илүү ухаалаг оновчтой зохицуулалт хийх байх гэж ингэж бодож байна. Энэ бол хууль тогтоогчийн бүрэн эрхийн асуудал. Хяналтын хүрээний хувьд бол би судлаачийн зүгээс ямар байр суурь хардаг вэ гэхээр яг нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагатай холбоотой асуудал дээр Монгол Улс нэгдмэл төвлөрсөн улс. Энэ нэгдмэл төвлөрсөн улс дээр бид нар нэлээд өвөрмөц онцгой захиргааны хэргийн шүүхийн тогтолцоо аваад ирчихсэн. Монгол Улс бол дэлхийд нэг 10 гаруй улсад байдаг захиргааны хэргийн шүүхтэй. Энэ 10 гэдэг бол тийм ч өргөн дэлгэр жишиг биш. Энэ дотроо Зүүн Европын 4 орныг нэлээд өвөрмөц ялгаатайг нь тооцох юм бол манай Монгол, Тайвань гэсэн Азийн 2 улс, Герман, Швейцар гэсэн Европын энэ нийт энэ 4 улсад л байдаг ийм Захиргааны хэргийн шүүхийн тогтолцоо дээр нь энэ Үндсэн хуулиараа тогтоосон нэгдмэл төвлөрсөн Улсын энэ системийнхээ онцлогийг харгалзаад ҮХЦ-ийн хяналтад ямар асуудал, ямар шийдвэр, маргаануудыг ҮХЦ-ийн хяналтад оруулах вэ гэдгийг мөн л хууль тогтоогчид маань одоо яг алтан дунджийг харгалзаж өөрийн орны Монгол орныхоо өнөөдрийг хүртэл 30 жилийн турш эрх зүйгээ хөгжүүлж ирсэн энэ бааз суурь дээрээ шийдэх ёстой гэж бодож байгаа.

ҮХЦ бол онолын шүүх. Үнэхээр энэ бол манай Монгол Улсад жилээс жилд ҮХЦ-ийн шийдвэр тайлбарлах арга зүйгээ сайжруулж төгөлдөржүүлж байгаа. Энд бол манай үе үеийн ҮХЦ-ийн гишүүдийн хувь нэмэр ингээд шат дараалан ингэж шинэ шинэ шатанд гаргаж байгаа гэж бодож байгаа.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: 2 нэр дэвшигчийн яах вэ зүгээр энэ хувийн байр суурийг нь л сонсож байгаа шүү. Тэрнээс биш албан ёсоор томилогдоогүй учраас ойлгож байгаад баярлалаа. Яах вэ би зүгээр ингээд үгчлээд Үндсэн хуулийн зарим заалтуудыг маш ийм агшаагаад ойлгочихсон зүйлүүд байгаа юм. Тэгээд Цэц ер нь зүгээр гаргасан шийдвэрээ эргэж харах боломжтой байхгүй юу. Тэгэхээр энэ олон шийдвэрүүдийг уг нь нэг үнэхээр нэг жоохон өөр нүдээр олж хараасай гэж хүсэж байгаа юм. Энийг харахгүй байх юм бол бид хэд Үндсэн хуульд л ойр ойрхон гар хүрэх зам руугаа явахаас өөр аргагүй болно.

Тийм учраас энэ үгчлэх гэдгээсээ илүүтэй анорижинал буюу илүү их утгажилт тайлбарлах тэр зүг рүү хандлагатай хүмүүс очоосой гэж би зүгээр хүсдэг.

Хоёрдугаарт энэ урьдчилсан маргаан хянадаг энэ үзэгдлүүд мэр сэр гарчих гээд байгаа. ... дээр хүртэл гарсан. Сая ч одоо яах вэ нэг үйл явдал дээр гарсан бүүр ингээд хийдлийг хянадаг болсон. Тэгээд энэ нь зөв үү үгүй юу ер нь зүгээр цаашдаа анхаараарай.

Дээд шүүхээр ер нь бүх шүүгчдийн хуралдаанаар орох эсэх асуудал чинь ер нь ... дээр хэрэггүй гэж байхад л хянаад шийдчихсэн шүү дээ.

Д.Цогтбаатар: Нарантуяа гишүүний микрофоныг өгье.

М.Нарантуяа-Нара: Өдрийн мэнд хүргэе ээ.

Д.Цогтбаатар: Би сая үг хэллээ гэж ойлголоо. Эрдэнэбат нэр дэвшигчийн микрофоныг өгье.

Г.Эрдэнэбат: Баярлалаа. Тэр түрүүний ярьснаа яг гүйцээгээд хэлэхэд энэ ҮХЦ бол онолын шүүх учраас энэ утга, зорилгын энэ тайлбарт бол илүү их ач холбогдол өгөх ёстой. Ингэж жилээс жилд Үндсэн хуулийг хөгжүүлэхэд Үндсэн хуулийн эрх зүйг хөгжүүлэхэд бол хувь нэмэр нь орох учраас улам бүүр үгчилсэн тайлбараасаа тэр агуулгын тайлбар тэгээд энэ бүүр нарийвчилбал орчин үеийн энэ хэллэгээрээ нөгөө утга зорилго анхнаасаа хууль батлахдаа ямар зорилго баталж баримталж гаргаж ирсэн, хуулийг баталсан, хууль тогтоогч ямар сайн сайхан зорилго тавиад хууль баталсныг хууль зүйн практикт яаж гуйвуулж байна вэ гэдэг дээр илүү дүн шинжилгээ хийдэг энэ Цэцийн Үндсэн хуулийн шүүхийн хяналтын хөгжил рүүгээ явах байх гэж ингэж би бодож байгаа.

Тэгэхээр би бол тэр үгжсэн тайлбараасаа цаашаа дараагийн шат руугаа явж байгаа гэж хараад байгаа.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүн тодруулъя. Одоо сүүлийнх шүү дээ энэ чинь.

П.Сайнзориг: Ойлголоо. Тэгээд мэдээж ямар хуулийн хүрээнд ажиллах вэ гэдгийг хууль тогтоогч шийдэж байгаа тэр хууль батлагдах байх. Өшөө нэг энэ Цэц дээр гараад байгаа нэг зүйл бий. Тэгэхдээ ойрын үед гараагүй. Энэ асуудлууд аж ахуйн маргаануудыг хянаж эхэлсэн. Би энэ дээр Пүрэвдорж дарга ч гэсэн нэг жишээг нь сануулж байна. Хуурамч шатахууны асуудлыг. Дээрээс нь Эрдэнэттэй холбоотой нэг Улсын Их Хурлын тогтоол гарч байсан юм. Энэ бол уг нь бусад зүйлээрээ л шийдэгдэх ёстой байсан. Тэгэхээр уг нь нөгөө нэг Цэц рүү аваачаад бүх зүйлийг наагаад энэ институцийнхээ мөн чанар зорилгыг нь ийм алдагдуулдаг юмнууд өнгөрсөн хугацаанд гарсан. Би яах вэ? Энэ цэцийн хууль гараасай шинэ бүрэлдэхүүн явбал энэ шийдвэрүүдийг нэг ер нь энэ бүрэлдэхүүнээрээ нэг үзэх ёстой юугаа бид хэд эргэж харах. Би заавал гэж байгаа юм биш. Тэгэхдээ маргаанууд тодорхой хэмжээнд гарлаа гэхэд өнгөрсөн хугацаанд гаргасан шийдвэрүүдийг эргэж харах нь Цэцэд л байгаа.

Тэгэхээр олон шийдвэрүүд байгаа энэ утга найруулгыг агшаагаад хумиад ингээд тавьчихсан. Нараа гишүүний микрофоныг өгье.

М.Нарантуяа-Нара: Өдрийн мэнд хүргэе тэгээд мэдээж 2 орон тоо байгаа. Хоёр орон тоонд 2 хүн дэвшиж байгаа юм чинь хоёуланг нь дэмжинэ. Тэр дундаа Ганбатын Эрдэнэбат гуайг олон жил уг үзэл бодлыг нь дагаж байсан хүний хувьд харж үлгэр дуурайлал авах ийм байсны хувьд дэмжинэ ээ. Би 2 нэр дэвшигчээс тодруулах зүйл байна. Монгол Улс ардчилсан улс. Тэгэхээр шүүхийн шийдвэр ч гэсэн аливаа шүүхийн шийдвэр ч гэсэн ардчиллыг бэхжүүлсэн, ардчиллын тогтолцоог хамгаалсан, ардчиллыг хамгаалсан шийдвэртэй байх нь зөв байх гэж би хувьдаа бодоод байгаа юм. Би бол та нар шиг мундаг хуульч биш шүү дээ.

Тийм учраас сайн мэдэхгүй байна. Гэхдээ энэ талаар та 2 юу гэж бодож байна аа? Хариулж өгөөрэй, 1 дүгээрт.

Хоёрдугаарт Жамьянхорлоогийн Сүхбаатарыг би хувь хүний талаас нь мэдэхгүй. Өмнө нь ингээд олон нийтээр л ингээд Улсын Их Хурлын гишүүн байхаас нь ингэж мэднэ. Танд хувийн өс хонзон ямар нэгэн тийм асуудал байхгүй. Гэхдээ би олон нийтийн санаа бодлыг энд дамжуулах үүрэг хүлээдгийнхээ хувьд танаас ганц хоёр асуулт асуумаар байна. Та өмнө нь Улсын Их Хурлын гишүүн байхдаа ногоон автобусны хэрэгт холбогдож байсан. Энэ хэрэг бол ингэж яваад ер нь бол Төрийн тендерийг тендер шалгаруулалтыг төр өөрөө хийдэг. Гэтэл энэ тендерт шалгарсан хүмүүс хувийн хэвшил нь хууль шүүхийн өмнө хэрэг хүлээгээд явсан байгаа тийм ээ.

Тэгэхээр энэ хэрэг өөрөө хэр зөв зохистой шийдэгдсэнийг бол би сайн мэдэхгүй байна. Энэ асуудал дээр та бас нэг байр сууриа илэрхийлээд өгөөрэй.

Хоёрдугаар асуудал энэ цэцийн өмнө нь явагдсан хурлуудыг ялангуяа нийтэд олны анхаарал татсан хурлуудыг харахад бол энэ Цэцийн хурал нэлээн коммунист дарангуйллын шинэ чанартай ингэж явагдаж байгаа харагдаж байсан.

Тэгэхээр та 2 энэ цэцийн хурал энэ ардчилсан байдлаар явагдах, мөн түүнчлэн аль нэгэн дарга эрх мэдэлтний талд аливаа хэргийг нийцүүлэхгүй байх ийм зүйлийг та 2 яаж хувь доор бүрнээ шийднэ гэж бодож байна аа? Миний хамгийн эмзэглэж айж байгаа зүйл бол ялангуяа хамгийн дээд шатын энэ шүүхийн шүүгчид хэнээс ч хараат бус бус байх ёстой. Энэ үүднээсээ орж ирж байгаа аливаа хэрэгт

гагцхүү тэр хэргийн үнэн мөний талд зогсдог ийм л хуулийг хамгаалагчид байх ёстой гэж би хувьдаа бодож байгаа.

Харамсалтай нь Монгол Улсад одоо сүүлийн үед хууль шүүхийн байдал иргэдийн хувьд зөндөө их эргэлзээ төрүүлж байгаа. Ийм байдлыг та бүхэн яаж хангаж ажиллах вэ гэж асуумаар байна.

Д.Цогтбаатар: Сүхбаатар нэр дэвшигчийн микрофоныг өгье.

Ж.Сүхбаатар: Баярлалаа. Нарантуяа гишүүний асуултын эхний асуулт үнэхээр чухал асуулт. Ер нь шүүхийн эрхэм зорилго бол яг таны хэлдэгтэй ер нь ойролцоо. Өөрөөр хэлбэл ер нь ҮХЦ ч бай, бусад шүүх ч бай тухайн улсынхаа эрх зүйн тогтолцооны тогтвортой байдлыг хамгаалдаг, Үндсэн хуулиа хамгаалдаг. Тэгэхээр яг Үндсэн хууль гэдэг бол өөрөө Монголын төр, ард түмэн, нутаг дэвсгэр, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бэхжүүлснийхээ хувьд бол яг үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал дээр заасанчлан манай Улсын гол юм бол нийгмийн тогтвортой байдлыг хангасан ардчилсан төрийн тогтолцоо байгаа.

Тэгэхээр яг таны хэлдгээр энэ шүүх энэнээс гадуур байхгүй. Тэр тусмаа ҮХЦ бол яг чухамхүү яг ардчиллыг бэхжүүлж хамгаалах тэр зорилгод үйлчлэх ёстой байгаа шууд утгаараа бол.

Хоёр дахь нь бол хэрэгт бол холбогдсон. Манай Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн ингээд олон үе үе дээр тодорхой ажлуудыг хашдаг. Ингээд асуудлууд үүсдэг, яллагдагчаар татагддаг, шүүгддэг. Одоо ч гэсэн энд яригдаад л улсууд явж байгаа. Тэгэхээр яах вэ ингээд энэ асуудал дээр ингээд ярихаар би өөрийгөө бол өмөөрмөөргүй байгаа юм. Хүн болгон өөр өөрийнхөөрөө буруутгана. Гэхдээ уулзах газар, шийдэх газар, ярилцах газар шүүх дээр байдаг. Өөр газар бол хувь хүмүүсийн дандаа үзэл бодол явдаг, ашиг сонирхол явдаг. Тэр бол ардчилсан нийгмийн эрүүл зарчим. Яах вэ анхнаасаа сайд болохоос авхуулаад тэр хөрөнгө мөнгө нь над дээр тавигдсан асуудлууд бол энэ миний хүсэл зоригоор шийдэгдээгүй асуудлууд. Тэгээд энийг бол өөрийгөө өмөөрөхийн тулд төрийн бусад албан хаагчдаа гэдэг юм уу өөрийнхөө албан тушаалтнууд руу хандсан юм шиг болчих гээд байдаг юм.

Ер нь ийм зовлон байдаг юм байна лээ улс төрч хүнд. Яримгүй гэдэг шиг өөрийгөө хамгаалж болохгүй үе гэж байдаг юм. Тэгэхээр шүүх шийдсэн. Ер нь бол зүгээр манайд мега төсөл ч байна уу том төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хяналт хариуцлагын тогтолцоо бол яг үнэндээ муу сул. Хэн ч хэрэгтэй орж болохоор ийм л байгаа бодит байдал.

Тэгэхээр хууль тогтоогч нар би ч гэсэн цаашдаа зүгээр энэ тал дээр бол зүгээр хуульч хүнийхээ хувьд бусад хүнд ч гэсэн энэ процедураа их нарийсгаж явах нь зүйтэй юм байна аа. Тэгэхгүй бол төрийн албан хаагчдаа албан тушаалтнуудаа хамгаалж чадахгүй, туг тахидаг. Нэг хүнд бүх бурууг тохдог. Тэгээд тэр систем нь бол яг хэвээрээ дараагийн хүн нь үргэлжлүүлдэг.

Тэгээд энэ сонсголууд ч гэсэн ер нь уг нь системийн алдааг залруулах зорилготой л ийм парламентын сонсголууд явж байгаа. Тэгээд дараа дараачийн сонсголууд дээр суурилад парламент энэ тал дээр анхаарах байх гэж боддог. Хуулийг ч гэсэн анх хийхдээ бид нар тэгж хийсэн юм Хяналт шалгалтын хуулийг.

Гурав дахь нь Цэцийн хуралдааны дарангуйлал дээр явагддаг ч ер нь бол Цэц өөрөө нэг талаар шүүх, тэгэхдээ аль болохоор ардчилсан байх ёстой. Бид нар Шүүхийн хуулийг өмнөх парламентын нөхдүүд маань хийхдээ 100 хувь нэвтэрч байгаа шүү дээ бүүр ингээд шүүхийн А, Б-гүй бүх юмыг нь. Бид нарын ч гэсэн та миний тухай ингээд яригдвал миний хувийн мэдээллээс авхуулаад зарим нь сүүлийн үед дургүйцээд байгаа. 100 хувь зурагт юугаар нөгөө онлайнаар нэвтэрч байгаа. Тэгэхээр Цэц ч гэсэн өөрөө ойлгомжтой, ил тод, ойлгомжтой байх шаардлага.

Д.Цогтбаатар: Тулга гишүүний микрофон өгье. Эрдэнэбат нэр дэвшигчийн микрофоныг өгье.

Г.Эрдэнэбат: Нарантуяа гишүүндээ баярлалаа. Тэгэхээр яг энэ ханан дээр байгаачлан Монгол Улс бол хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцлоон хөгжүүлэх зорилготой. Өөрөөр хэлбэл ардчилал гэдэг бол Монгол Улсын нийгмийн улс төрийн эрх зүйн дэглэм. Энд Монгол Улсын бүх төрлийн үйл ажиллагаа ардчилсан зарчимд тулгуурлах ёстой.

Тийм учраас бол би таны хэлж байгаачлан Цэцийн болон ҮХЦ-ийн хяналтын үйл ажиллагаа ардчилсан зарчмаар хэрэгжих ёстой гэдгийг би 100 хувь ойлгож байгаа. Цэцийн хурал коммунист арга барилаар явагдсан гэдгийг би харин юу гэж бодож байна вэ гэхээр энэ ер нь бол Үндсэн хуулийн цэцийн тухай хууль ҮХЦ-д маргаан шийдвэрлэх тухай хуулиараа дэгтэй. Тэгээд миний ажиглаж байснаар бол судлаачийн хувьд, шинжээчийн хувьд цэцийн маргаан шийдвэрлэх үйл ажиллагаанд оруулж байхад дандаа л дэгээрээ л явж байсан.

Тэнд хүмүүсийн харилцаа хандлагын хувьд тийм байдал ажиглагдсан юм болов уу даа. Цаашдаа бол тэр хурал дэглэж удирдаж байгаа хүмүүсийн энэ харилцаа хандлагад байгаа болов уу? Тэрнээс эрх зүйн зохицуулалтын хувьд тийм коммунист арга барил би байхгүй болов уу гэж л бодож байна.

Нара гишүүний микрофоныг өгье.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр өнгөрсөн хугацаанд Цэц дээр болсон хуралдаан дээр жишээлбэл Улсын Их Хурлын гишүүн Булгантуяаг өөрийгөө өмгөөлөх өмгөөлөгчгүй, өмгөөлөгчөө аваагүй байхад нь өмгөөлөгчтэй орж ирэх боломжоор хаасан ийм үйлдлүүд гарсан шүү дээ. Тэгэхээр та 2 тэр энэ тал дээр яг ямар байр суурьтай байна? Хэрвээ та 2-т яг ийм нөхцөл байдал үүсвэл яах вэ?

Д.Цогтбаатар: Сүхбаатар нэр дэвшигчид микрофоныг өгье.

Тэгэхээр яг тодорхой нөгөө кэйс дээр асууж байгаагаар яг бид нар нөгөө хичээл зааж байгаа багш нарт яг тавьдаг шигээ яг хувийн байр сууриа цэцтэй холбогдуулаад хэлэхээр маш зохимжгүй болчих гээд байна л даа.

Зүгээр би нэг жишээ тодорхой юм хэлж чадах юм нь өөрөө Их Хурлын гишүүний хувьд олон удаа цэц дээр итгэмжилсэн төлөөлөгчөөр очиж байсан. Яг тэр үед Их Хурлын гишүүдийн авдаг мэдрэмж шиг дургүйцэл гэдэг юм уу тийм юмнууд төрж байсан. Тийм тэгэхдээ тэр илүү би сая Эрдэнэбат нэр дэвшигчийг хэлэхээр бодож байна. Ер нь тэр аливаа хуралдаан даргалж байгаа тэр даргалагчтай холбоотой, тухайн үеийн хандлага, хүмүүсийн харилцааны асуудал нөлөөлдөг илүү

байж магадгүй гэж бодож байна. Яг одоо нарийвчилж Цэцийн дэгийг би өөрөө харж үзээгүй байна. Яг одоо л нэг сонирхол төрж байна л даа. Яг энэн дээр асуудал яг хуульдаа байна уу үгүй юу гэж.

Д.Цогтбаатар: Эрдэнэбат нэр дэвшигчийн микрофоныг өгье.

Г.Эрдэнэбат: Тийм энэ шийдвэрлэсэн хэрэг маргааны хувьд одоо дүгнэлт хийж ярих эрх байхгүй байна, уучлаарай.

Д.Цогтбаатар: Үг хэлэх дээрээ та хэлчихгүй юм уу? Тэгэх үү? Тулга гишүүнд микрофон өгье.

Б.Тулга: Та бүгдийн энэ өдрийн амар амгаланг эрье ээ. Ингээд хоёулаа төрд тодорхой хугацаагаар ажилласан, туршлагатай ийм 2 хүн орж ирж байгаа юм байна. Тэгээд хууль хүчний байгууллага ч гэсэн тодорхой хэмжээгээр орсон түүхтэй намтартай. Энийгээ ч өөрсдөө ярьж байх шиг байна аа. Тэгээд Цэц маань бол та бүгд бүгдээрээ мэдэж байгаа шүүх гэж байгаа. Тэгээд шүүхийн шийдвэр бол нэг гарсан бол яг тэр шийдвэр бол байнга л хүчин төгөлдөр байж байх ёстой. Харамсалтай нь манай Цэцийн туршлагаар ингээд харах юм бол сая ч гэсэн гишүүдийн үгэнд гарч байна.

Маш олон шийдвэрүүд нэг гараад өөрчлөгдөөд өөрчлөгдөөд ингээд хүнээсээ хамаараад өөрөөр хэлбэл тухайн шүүх ч гэдэг юм уу тухайн цэцийн бүрэлдэхүүнээс хамаараад өөрчлөгдөөд байдаг. Тэгээд энэтэй холбоотойгоор нөгөө нэг нэр дэвшигчийн үгэнд ч гарч байна. Нөгөө улс төрийн бүлэглэл, улс төрийн нам ийм нөхдүүдээс хол байлгах энэ тэр гэдэг. Харамсалтай нь өнөөдөр томилогдож байгаа нэр дэвшээд орж ирж байгаа 2 маань ямар нэгэн өрсөлдөөнгүй орж ирж байна гэж би харж байна л даа.

Тэгэхээр та 2-ыг хаанаас ямар зар гэдэг юм уу, хэн санал болгож өнөөдөр та бүхэн Цэцийн гишүүнээр ажиллая гэдэг шийдвэрийг гаргаад орж ирж байгаа вэ? Ямар байгууллагаас санал болгосон бэ? Яагаад гэвэл энэ Цэц маань нөгөө бие даасан ямар нэгэн байдлаараа хэн нэгний захиалга биелүүлдэггүй байхын тулд шилэн ил тод байх ёстой.

Тийм учраас та 2 бас тэр талаасаа хэлээч ээ. Өөрөөр хэлбэл дахиж цаашид ямар нэгэн байгууллага, бүлэглэл, улс төрийн намын юу гэдэг юм тийм ээ захиалга шахалтад орох ийм эрсдэл байна уу? Байхгүй юу?

Тэгэхээр энийгээ бас та 2 маань эхлээд нэг хэлээч 1 дүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт 2 нэр дэвшигч хоёулангаас нь асуумаар байна. Сая энэ зунжингаа хаваржингаа л юм болсон. Энэ Их Хурлын гишүүдийн ёс зүйг хуульчлаад Цэцээ шүүлгэх тухай асуудал бас зарим хуулийн төслөөр орж ирсэн ийм байж байгаа. Тэгэхээр хувь хуульчийн хувьд та бүхэн ер нь юу гэж боддог юм? Ёс зүйг хуульчилж болно гэж боддог уу? Болохгүй гэж боддог уу? Энэ дээр хуульчийнхаа зүгээс бас нэг байр сууриа илэрхийлээч гэдэг ийм 2 асуултыг тавих гэсэн юм.

Д.Цогтбаатар: Сүхбаатар нэр дэвшигчийн микрофоныг өгье.

Ж.Сүхбаатар: Тулга гишүүний асуултад хариулъя.

Тэгээд жоохон ганц нэг онолын юм хэлчих ёстой болж байна. Яах вэ цэцийн шийдвэр өөр өөр гарч байна л гэж байна. Тэр бол шүүмжлэлтэй асуудал мөн үү мөн. Тэгэхдээ шийдвэрээ залруулах тэр боломж хууль зүйн хувьд заавал байх ёстой. Тэгэхдээ таны саяын хэлдгээр нөхцөл байдалд тааруулаад гараад яваад байгаа асуудлууд эд нар бол энэ парламент хууль тогтоох байгууллага өөрөө эрх мэдлийн харилцаа хяналтыг хэрэгжүүлдгийн хувьд бол энэ асуудлыг ярьж анхааралдаа авч ярилцах нь би бол буруу биш гэж боддог.

Хоёр дахь өрсөлдөөний тухай асуудал ярьж байгаа. Энэ бол томилгоо. Ер нь бол захиргааны эрх зүйн хичээл заадаг хүний хувьд хэлэхэд, томилох, сонгох гэсэн 2 аргаар Монгол Улс албан тушаалтнуудыг сонгодог томилдог. Томилгоо гэдэг бодлогын буюу тодорхой эрх бүхий албан тушаалтан байгууллага, өрсөлдөөн гэхээс илүүтэй тодорхой бодлогоор гаргаж ирж ингэж хүний нэр дэвшүүлдэг. Одоо жишээлбэл Ерөнхий сайд томилгооны зарчмаар байдаг. Ерөнхий сайд дээр бол яг улс төрийн соёл зарчим жишгээрээ явдаг. Аливаад бүх юм хуульчлагддаггүй. Тэрэн дээр өрсөлдөөний арга явдаггүй. Тэгэхээр томилолт гэдэг бол илүү бодлогын шинжтэй сонголт байдаг. Сонгуульд өрсөлдөөн бол өөрөө заавал байхыг шаарддаг. Саяын энэ явж байгаа жишгээр ер нь Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлаас санал болгох асуудлууд дээр Улсын Их Хурлын дарга манай спикер чинь Улсын Их Хурлын дарга гэсэн статусаар олон хүний томилгоог санал болгодог. Монгол Улсын хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн байдаг, ингээд явдаг. Тэгэхээр энэ соёл жишгээрээ явдаг ийм юм байгаа.

Тэгэхээр энэ байдал яг энүүгээрээ явж байгаа гэж ойлгож байгаа. Ер нь энэ парламентын олон зүйл бол хуулиар зохицуулагдахгүй парламентын бүлгүүдийн ойлголцол улс төрийн соёлоор, даргын дэргэдэх зөвлөлөөр, уулзалтаар дэлхийн аль ч улсууд тэгээд явдаг юм бий. Зүгээр энийг хуульчилна гэвэл тусдаа асуудал байх аа. Захиалга шахалтын асуудал дээр та өөрөө намайг мэдэж байгаа байх аа. Би улс төрийн намуудад хэн нэгэн дарга даамал, нэг нам, хүчинд харьяалагддаггүй, биеэ тоосон гэдэг юм уу биеэ даасан байр суурьтай гэдгээрээ магадгүй зарим тохиолдолд адлагдаж явсан болохоос хүнээс хамаарч шахалтад өртөж явсан түүх байхгүй.

Дараагийнх нь ёс зүйг хуульчлах тухай асуудал дээр одоо бид чинь Төрийн албан хаагчийн ёс зүйн байдлын тухай хуультай байгаа шүү дээ. Их Хурлын дарга Занданшатар даргын үед өмнөх парламент энэ хуулийг баталчихсан. Би 1997 онд төрийн албан хаагчийн ёс зүйн хэмжээний төслийг Монголд анх хуулийн төслийг нь боловсруулж, Төмөр багш, Оюун, Шаравдорж нар 1999 онд анх өргөн барьж байсан түүхтэй. Ёс зүйг хуульчлах, хуульчлахгүй тухай маргаан байдаг боловч хуульчлах гэдэг юм уу, код гэдэг юм уу акт гэдэг юм уу янз бүрийн хэлбэрээр бол явж байгаа. Энэ хууль тогтоогчийн сонголтын асуудал. Гэхдээ одоо бол хуульчлагдсан байдлаар Монгол Улсын хууль үйлчилж байгаа.

Тийм учраас Ёс зүйн хороо зөвлөлүүд төрийн бүх байгууллагууд дээр байж байгаа юм. Тэгэхээр энэ асуудал бол яригдаж байгаа бол энэ хуулиудыг хүчингүй болгож болно. Тэгэхдээ ёс зүйн дүрэм код бол дэлхийн улс орнуудад яваад л байгаа л даа. Бизнесийн хувьд ч тэр хамгийн ач холбогдолтой, бизнесийн ёс зүй гэхэд л хамгийн чухал хичээл. Хуулийн сургуулиудын хичээлд ордог шүү дээ.

Д.Цогтбаатар: Эрдэнэбат нэр дэвшигчийн микрофоныг өгье.

Г.Эрдэнэбат: Баярлалаа. ҮХЦ-ээр маргаан хянан шийдвэрлэгдэж тэр шийдвэрүүд түүхэн цаг үеийн нөхцөл байдалдаа үндэслэж гарсан байдаг. Тэгээд хожим нь улс төр нийгмийн нөхцөл байдал өөрчлөгдсөнөөс тухайн асуудлаарх шийдэл өөрчлөгдсөн тохиолдлууд гардаг. Таны хэлсэнчлэн улс төрийн нөлөө, бусад нөлөөнөөс хамааралтайгаар шийдвэр гарсан байх магадлалтай. Тэрийг үгүйсгэхгүй. Тэгэхдээ би өнөөдөр баримтаар яг үйл баримтаар эсвэл нотлох баримтаар ийм шийдвэрийг Цэц захиалгаар гаргаад тэгээд энэ шийдвэр нь дараа нь мөн захиалгаар өөрчлөгдөөд энэ тэр гэж хэлэх ямар ч уучлаарай боломж алга.

Тэгэхээр мэдээж хэрэг ямарваа нэгэн шийдвэр гаргаж байгаа тохиолдолд бол тэр шийдвэрийн үндэслэл тийм шийдвэр гаргах болсон үндэслэл тэр баримтуудад ямар байгааг бол харах ёстой ҮХЦ-ийн аливаа шийдвэр үндэслэл хэсгээ улам бүр их сайн тайлбарлаж бичдэг болсон.

Тийм учраас энэ цэцийн шийдвэрийн хүчин төгөлдөр байдал хараат бус байдал жилээс дээш сайжрах байх гэж бодож байна. Судлаачийн хувьд харж байгаа хэрэг шүү дээ.

Томилгооны асуудлаар сая Сүхбаатар нэр дэвшигч маань туйлын тодорхой хэлсэн учраас надад нэмэлт тайлбар алга. Бид 2 яг ижил зарчмаар энэ өнөөдөр ингээд та бүхнийхээ өмнө шийдвэр гаргуулах гээд сууж байгаа. Энэ 2 нэр дэвшиж буй этгээд ҮХЦ-д ажиллах нь зөв өө гээд болох юм байна гээд ингээд шийдвэл энэ ажил хариуцлагыг хүлээнэ. Тэгээд энэ бол цэвэр ингээд та бүхний эрх мэдэл шийдлийн хүрээнд гарах томилгооны зүйл болно.

Цэцийн гишүүн ер нь ямарваа нэгэн хууль зүйн ажил хийж байгаа хүн хараат бус байх эсэх тухай асуудал тухайн хүний өөрөөс нь хамааралтай зүйл байдаг. Ямар ч ажил дээр хүн янз бүрийн арга замаар гэх юм уу янз бүрийн замналаар очиж болно. Үгүй энэ болгондоо ач тус санаад эсвэл нутаг орон бодоод ер нь бол хүнийг ингээд хараат бус болгоё гэвэл маш олон хүчин зүйл нөлөөлдөг боловч тэр хүн өөрийнхөө мэргэжлийн үүрэг хариуцлагыг ойлгоод түүн дээрээ хараат бусаар ажиллах эсэх нь бол тухайн хүний тэр ажил үүргээ яаж ойлгож тэр ажил үүргээ яаж гүйцэтгэж байгаагаас хамаардаг.

Тэгэхээр энэ хараат байдлыг бол би юу юунаас илүүтэй ямар замаар томилогдов, хаанаас томилогдов, аль нутаг вэ, хэний хамаарал юм бэ гэдэг зүйлээсээ илүү мэргэжлийн өөрөө хариуцлага ёс зүйтэй холбоотой асуудал гэж бодож байна. Энэ ёс зүйн асуудлыг мөн сая их тодорхой хэлчихлээ.

Тэгэхээр Улсын Их Хурлаар Улсын Их Хурлын гишүүний ёс зүйтэй холбоотой хууль батлах эсэх нь бол бодлогын асуудал. Дэлхийн аль ч улсад.

Д.Цогтбаатар: Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Би нэг нөгөө ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой л асуулт асууя. Илүү тэрэн дээр төвлөрнө гэсэн үг. Таны өмнө та 2 маань хоёулаа аль аль нь улс төрийн намын өндөр албан тушаалтнуудтай хамтарч ажиллаж байсан өөрсдөө ч улс төрийн шийдвэр гаргалтад нөлөө бүхий ажил албан тушаал хашиж байсан хүмүүс.

Тэгэхээр урьд өмнө хамтарч ажиллаж байсан улс төрийн намын албан тушаалтнуудтай холбоотой маргаан ҮХЦ дээр ирвэл та 2 татгалзан гарах уу? Ямар арга хэмжээ авах вэ? Ашиг сонирхлын зөрчлөөс хамгаалахын тулд гэсэн үг нэг дэх асуулт.

Хоёрдугаарт ҮХЦ-ийн гишүүн зөвхөн хууль зүйн шаардлага хангасан байхаас гадна хамгийн гол нэг шаардлага бол олон нийтийн итгэлийг хүлээсэн байх ёстой ийм шаардлага байгаа.

Тэгэхээр таны буюу та 2-ын энэ томилгоо олон нийтийн итгэлд хэрхэн нөлөө үзүүлнэ гэж харж байгаа вэ? 2 дахь асуулт.

Гурав дахь нь сая хэн аль нь хэлж байна? Томилгооны процесс юм гээд. Энэ нэр дэвшүүлж байгаа процесс, энэ томилгооны процесс өнөөдрийг энэ Хууль зүйн байнгын хороонд орж ирэх хүртэлх процесс хэр шударга байна гэж бодож байна вэ? Та 2 энэ процессыг сайжруулах ёстой гэж үзэж байгаа юу гэсэн ийм 3 асуулт хэлээд байсан.

Д.Цогтбаатар: Эрдэнэбат нэр дэвшигчийн микрофоныг өгье.

Г.Эрдэнэбат: Энэ ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой зүйл дээр бол угаасаа Монгол Улсад дагаж мөрдөж байгаа хуулиуд байгаа. Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах урьдчилан сэргийлэхтэй холбоотой хууль байна. Цэцийн тухай хууль байна, цэцэд маргаан шийдвэрлэх тухай хууль байна. Тэгээд энэ хуулиудаа баримтлаад ажиллахад бол асуудал үүсэхгүй байх гэж бодож байна. Энэ ашиг сонирхлын зөрчил болон саяын таны хэлж байгаа томилгоотой холбоотойгоор олон нийтийн итгэлийг хүлээж чадах уу, томилогдвол олон нийтийн итгэлийг хүлээж чадах уу гэдэгт хэрхэн нөлөөлөх вэ гэдэг асуудал бол цэвэр миний зүгээр бодлоор бол, миний байр сууриар бол үнэхээр энэ ажлыг хариуцаад ажилла гэвэл хэрхэн ажиллахаас л хамаарна. Өнөөдөр юу юуны духандгүй энэ асуудлыг ингэж нөлөөлнө би өөртөө итгэлтэй байна гэж хэлэх бололцоогүй. Ер нь энэ орчлон хорвоо дээр хүн өөрөө өөрийгөө дүгнэж ярих бол өөрөө зүй бус асуудал. Аливаа ажил хэргийг гүйцэтгээд тэгээд хүн чадаж байна уу, чадахгүй байна уу гэдгийг бусдаар дүгнүүлдэг болохоос биш өөрөө дүгнэдэггүй.

Тийм учраас би юу гэдэг юм энэ асуудлыг Улсын Их Хурал шийдээд ёстой энэ томилгоог хийхдээ ч тэр, дараа нь томилгооны дараа энэ шударга зөв шийдвэр болсон байна гэж дүгнэгдэхэд ч тэр тухайн хүмүүсийн өөрсдийнх нь ажлын гүйцэтгэл тухайн ажлыг хийж чадвал энэ зүйл үнэлгээ нь гарч ирэх байх гэж бодож байна.

Д.Цогтбаатар: Сүхбаатар нэр дэвшигчийн микрофоныг.

Ж.Сүхбаатар: Ашиг сонирхлын асуудлыг та хөндөж байна. Энэ сууж байгаа Тэмүүжин гишүүн бид 2 Монголд хамгийн анх Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг урьдчилан сэргийлэх зохицуулах тухай хуулийн төслийг хоёулаа санаачилж тэр үед амаргүй үед анх батлуулж байсан 2.

Энэ дээр Тэмүүжин маань ч гэсэн нийтийн ашиг сонирхлыг олон нийтийн итгэлийг гэж хэлнэ гэж ингэж томъёолсон байдаг. Би бол ашиг сонирхлын зөрчлийн асуудлаар хуулийг нь хийж байсан учраас энийгээ маш сайн хувийн амьдралдаа ч

барьдаг байсан. Та одоо яг энэ хэр шударга вэ олон нийтийн итгэл хүлээсэн гэдэг дээр би танаас эргүүлж бодоосой гэж би тантай тодорхой хугацаанд ажиллаж байсан. Надтай ажиллаж байсан олон байгууллага албан тушаалтнууд байгаа. Тэр дотор хувийн талаар ч хүн хулхидаж байсан юм уу ажлын алдаа эндэгдэл гаргаж байсан юм уу итгэлийг нь хөсөрдүүлж байсан нэг ч тохиолдол байхгүй. Зүгээр даалгавар намынхаа дарга, Ерөнхий сайдын үүрэг даалгаврыг хүлээгээд би нэг өөрөө ярилцаагүй, уулзаагүй, зөвшөөрөөгүй ажилдаа очсон.

Тэгээд тэр асуудалтай холбоотойгоор асуудлууд гарсан. Цаашаа үргэлжлүүлээд. Тэгэхээр энэ дээр сэвтсэн юман дээр би зүгээр хэлэх юм нь бол мэдээж та хэр шударга вэ гээд философийн асуулт маягийн юм асуусан учраас энэ дээр хүн хэлэхэд хэцүү. Тэгэхдээ хүнийг амьдралынх нь нэг бүлгээр нь үнэлж болохгүй гэж хэлдэг шиг хувь хүн болгон миний сүүлд сайд байх үеийн юмаар насан турш би ямар хүн бэ гэдгээ тодорхойлуулна гэж үзэж байгаа бол тэр хүмүүсийн асуудал байх аа.

Түүнээс би хамтран ажиллаж байсан олон газар, байгууллага, олон хүний дунд ажиллаж байсан учраас тэр хэд маань юун түрүүн надад итгэдэг үү гэдэг л миний хувьд бол илүү чухал асуудал. Тэгээд цаашдаа гол асуудал нь Цэцэд очоод Сүхбаатар, Эрдэнэбат гэдэг нэр дэвшигч нар очоод тодорхой хэмжээнд өөрчлөлт гарах уу үгүй юу. Гарч байгаа бол би зөв байсан гэдгээ батална. Гарахгүй байгаа бол тэр нь таны болон бусад хүмүүст харагдах байх аа. Тэгээд ч олон түмний итгэл бол хөсөрдүүлж болохгүй үед би сонгогчдын мандатыг урьд нь удаа дараа авч байсан.

Тийм болохоор таны энэ асуултыг тавьж байгаа асуулт дээр мэдээж бид итгэлийг зүтгэлээр л хариулна гэдэг шүү дээ. Тэгэхээр итгэлийг зүтгэлээр хариулахыг л хичээнэ. Бусад нь хүмүүс ардчилсан нийгэм учраас хэн ч янз янзын санал бодол байна. Тэрийг би хүндэтгэнэ.

Д.Цогтбаатар: Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Яах вэ бид нар ингэж асууж асуулт асуугаад хариулт аваад байгаагийн гол ач холбогдлыг бол та 2 надаар хэлүүлэлтгүй мэдэж байгаа. Олон нийтийн өмнө өгч байгаа нэг ёсондоо амлалт гэж би энэ асуултыг асууж байгаа.

Хоёр дахь гол том сэдэв бол энэ үндсэн эрхийн маргааныг ҮХЦ шийдвэрлэдэг болох эсэх асуудал байгаа. Яг үүнтэй холбоотой гарч ирэх нэг зүйл юу вэ гэвэл Улсын дээд шүүх болоод ҮХЦ 2-ын хоорондын эрх мэдэл харилцан тэнцлийн асуудал байгаа. Энэ хил хязгаар энэ заагийг ер нь ямар хүрээ хязгаар дотор баримтална гэж бодож байгаа вэ? Энэ дээр бас яг мэргэжлийн хүмүүсийн хувьд байр сууриа илэрхийлэх нь зөв байх гэж бодож байна.

Д.Цогтбаатар: Сүхбаатар нэр дэвшигчийн микрофоныг өгье.

Ж.Сүхбаатар: Баярлалаа. Тийм ер нь парламентын гишүүний асууж байгаа асуултыг би ойлгож байгаа. Дандаа иргэдийн мэдэх эрхийг хангахтай холбоотой асуулт учраас би ч гэсэн тодруулж байгаа юуг нэлээн тайлбарлаж байгаа шүү. Үндсэн эрх эрх чөлөөний тухайд бол харин яг гол асуудал манай Тэмүүжин нарын гишүүд та бүхэн маань яг ярьж байгаа асуудал байх. Зүгээр би урьдчилаад ийм байвал зүгээр гэж хэлэхгүй. Гэхдээ нэг 3, 4 нөхцөлөөс л тэр давдаггүй юм байна

лээ. Тэгээд би энд яг тоочиж тийм нөхцөлд л энийг байж болно оо гэж хэлэх нь юм бол өөрөө тэр байгууллагад томилогдож магадгүй хүний хувьд эрх мэдэл авах гэж байгаа юм шиг ашиг сонирхлын хувьд ч гэсэн нэг тийм зохистой би биш байх гэж бодож байна л даа. Зарим тохиолдолд магадгүй олон хүн ийм юмыг Цэц хянаж болохгүй ч гэж үзэх юм билүү? Энэ Их Хурал дээр. Тэгэхээр чинь зэрэг энэ асуудал дээр би яг шууд байр сууриа хэлж чадахгүй байна.

Д.Цогтбаатар: Эрдэнэбат нэр дэвшигчийн микрофон.

Г.Эрдэнэбат: Баярлалаа. Тэгээд түрүүн яг байр сууриа хэлсэнтэйгээ адилаар би дэлгэрүүлээд сайхан боломж гарлаа. Тэгэхээр Сайнзориг гишүүний асуултад хариулсантайгаа адилхнаар ер нь бол Монгол Улсын Үндсэн хууль үндсэн эрхийн маргааныг хянаж хэлэлцдэг энэ шатандаа дэвшлийн шатандаа орох ёстой. Тэгээд яг Сүхбаатар нэр дэвшигчийн хэлж байгаа шиг харин үндсэн эрхийн маргааныг хянан хэлэлцэх эрхийн хүрээ хязгаар нь ямар байх вэ? Яг та хэд үргэлжлүүлэн асуусан дээд шүүх ер нь шүүхийн харьяалалтай яаж харгалдахгүй харшилдахгүй байх вэ гэдгийг бол хууль тогтоох байгууллага маань их ухаалгаар тогтоож өгөх ёстой байх. Энийг тогтоосны дараа бол ҮХЦ, Улсын дээд шүүх ер нь шүүх эрх мэдлийн байгууллагын хоорондын хяналт тэнцвэрийн харьцаа бол тодорхой болно. Үндсэн эрхийн маргаан бол Монгол Улсын Үндсэн хуульд дотор байж байгаа үндсэн.

Ингээд гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Алтангэрэл гишүүнээр. Номинчимэг гишүүн үг хэлнэ гээд байсан. Баасанжаргал гишүүнээр тасаллаа. Нарантуяа гишүүн.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр хүний ер нь эзэмшсэн ажил мэргэжил ер нь бүх зүйл нь хүний төлөө цохилдог хамгийн том энэ бүх ажил мэргэжлийн суурь нь бол хүнлэг сэтгэл байх ёстой байх гэж би хувьдаа боддог юм. Тэгэхээр та 2 бол маш том чухал албан тушаалд очих хүмүүс. Аливаа шийдвэрийг хүнлэг сэтгэлийг сууриа болгож гагцхүү үүссэн нөхцөл байдал хэрэг явдалд гагцхүү хуулийн хүрээнд шийдвэрийг гаргадаг байгаасай гэж чин сэтгэлээсээ хүснэ. Энд хэн ч ямар ч асуудлыг асууж юу яасан байж цаашдаа болзошгүй. Тийм учраас өс хонзон зангидаж, өс зангидаж дараа дараагийн тийм үү ямар нэгэн асуудалд магадгүй би ч гэсэн Цэцээр орж магадгүй. Ер нь хамгийн магадлалтай гишүүн байгаа.

Тэгэхээр тэр үед намайг ингээд шүүгч болоход энэ тэгж байсан гэдэг байдлаар хандахгүй гэдэгт найдаж байна. Тэр нь зөвхөн надад биш ер нь хэнд ч тэр. Тэгэхээр хамгийн гол нь хүнлэг сэтгэл хүн чанар юм тэгээд гагцхүү хуулийн хүрээнд асуудлыг шийддэг байгаасай гэж хүсэж байна аа.

Тэгээд та 2-т хоёуланд нь амжилт хүсье ээ.

Д.Цогтбаатар: Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: ҮХЦ-д нэр дэвшиж байгаа 2 хүн хоёулаа миний эртнээс таньдаг 2 хүн. Тэгээд би та 2-т захиж үг хэлэх гэж байгаа юм. Сүхбаатар гишүүн анх залуухан гишүүд байхдаа бид хэд Улсын Их Хурал дээр авлигын албан бус бүлэг байгуулаад энэ нийтийн албанд ашиг сонирхлын зөрчлийг яаж хязгаарлах вэ гэдэг дээр санаа оноогоо хуваалцаж бид шийдлээ Улсын Их Хурлаар баталж гаргуулж байсан тийм туршлагатай. Та залуу байхаасаа эхлээд энэ дэвшилтэт үзэл санааг дэмждэг нэг ч

гэсэн санал байхыг эрмэлзэж байна гэдэг үгийг эзэн байсан. Пропорционал сонгуулийн тогтолцоог Монгол Улсад оруулж ирэхэд маш том хувь нэмэр оруулж байсан. Дэвшилтэт үзэл санааныхаа эзэн байх гэдэг энэ үгэн дээрээ сууж ҮХЦ-д очсон ч гэсэн Үндсэн хуулийн түрүүн Сайнзоригийн үгэнд ч гэсэн гараад байсан либерал тайлбар гэж. Юмсын хэлбэр дүрсээр биш утга агуулгаар нь асуудлыг нэвт харах тийм хэмжээний мэргэжилтэн байгаасай гэж хүсэж байна.

Захиргааны эрх зүйгээр мэргэшсэн. Иргэний үндсэн эрхийн маргаан ҮХЦ-д очих юм бол хамгийн түрүүнд ер нь бол захиргаа, нийтийн эрх зүйн асуудлууд хөндөгддөг. Тэр мэргэжилтнийхээ зүгээс том хараарай. Мэргэжилтнийхээ хувьд, улс төрчийнхөө хувьд зоригтой байгаарай. Ямар нэгэн хонгил угсрах хонгилын үзүүрт хаалгач хийх тийм захиа даалгавраас хол яваарай гэж хүсэж байна.

Эрдэнэбатад бас мөн адил энэ эрх зүйн салбарт маш олон дэвшилттэй үзэл санааны санаачлагч нь, эзэн нь, судлаачийнхаа хувьд, хуульчийнхаа хувьд та байсан. Эрүүл саруул оюун ухааны тухай байнга магтан дуулж эрүүл логик сэтгэлгээний алдаагүй дүгнэлт гаргах тэр тархины төлөө ажилладаг. ҮХЦ-д гишүүн болоод очвол Монгол Улсад нэг эрүүл оюун ухаан бас энэ хууль зүйн шийдлийн чинь ард байдаг юм гэдгийг нотолж харуулах үйл хэргийг манлайлж яваарай гэж хүсэж байна.

Эрүүгийн эрх зүйн том мэргэжилтэн. Хоёулаа захиргаа, эрүүгийн нийтийн эрх зүйн салбарын 2 том мэргэжилтэн тийшээ явж байна. Хоёулаа хат суусан хувь хүнийхээ хувьд. Хоёулаа хонгилоор чирүүлж үзсэн. Хэлмэгдэнэ гэж ямар байдаг юм, хуулийг хувийн ашиг сонирхолтой ашиглавал юу болж хувирдгийг арьс махан дээрээ мэдэрсэн 2 хүн.

Тийм учраас Монгол Улсын Үндсэн хуулийг иргэний үндсэн эрхийнх нь манаач байхынхаа хувьд бас энэ хэлмэгдүүлдэггүй хуулийн тогтолцоо бий болоход хувь нэмрээ оруулна гэж итгэж байгаа.

Гуравт нь дахиад хоёуланд нь хандаж хэлж байна. ҮХЦ-ийн шийдвэрүүд Үндсэн хуулийг өөрийг нь хөгжүүлдэг байх ёстой. Монгол Улсад ҮХЦ дээр 2 сонголт байгаа. Улс төрийн шүүх байх уу, Үндсэн хуулийн шүүх байх уу гэдэг. Үндсэн хуулийн шүүх байх чиглэл рүү нь мэргэжилтнийхээ хувьд хатуу зогсоорой гэж би хүсэж байна. Үндсэн хуулийн шүүх байхын тулд ҮХЦ дээр 3 эрх мэдэл хатуу хэрэгжих ёстой иргэний үндсэн эрхийн хяналт. Эрх мэдэл хуваарилалтын маргаан, норматив хяналт 3. Энэ 3 бодитойгоор хэрэгжсэн цагт тэнд Үндсэн хуулийн шүүх ажиллаж эхэлнэ.

Тэгээд 1992 оны Үндсэн хуулийг баталж байх хуулийн явцад Очирбат гуайн нэг илтгэл дотор үг байна лээ. Үндсэн хуулийн шүүхийг ҮХЦ гэдэг нэртэйгээр шүүхээс тусгайлан байгуулж байгаа нь зөв байна гэдэг энэ үг байна лээ. 1992 оны энэ сонголтыг баталгаажуулаарай гэж л.

Д.Цогтбаатар: Алтангэрэл гишүүний микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Монгол Улсын ҮХЦ-д МУИС-ийн багш нар байна аа. Миний багш Жужагийн Эрдэнэбулган багш маань байна. Мөн багшилж байсан манай их сургуулийн хуулийн багш нар Мөнхсайхан, Гангабаатар гээд багш нар байна. Тэгээд хуульч мэргэжилтэй хүний хувьд ҮХЦ-ээс нэг ийм сэтгэл гонсойлгосон шийдвэр

гарах болгонд нэг тийм горьдлого байдаг юм. Энэ шийдвэрийг гарч байхад манай МУИС-ийн хуулийн багш нар манай эрдэмтэд тэнд нэг цөөнх болоод ганцаардаад байсан байх даа гэж, тэгж бодож төсөөлж горьддог юм. Одоо ингээд яг үнэндээ манай салбарын 2 их сайн мэргэжилтэн өнөөдөр орж ирж байна.

Аль аль нь багшилж байсан. МУИС-ийн Хууль зүйн сургуулийн бүтээгдэхүүнүүд байна. Та бүхэн бол тэгээд ингээд тооны хувьд олонх боллоо. Ингээд томилогдвол тэгээд энэ хууль эрх зүйн системдээ итгэдэг хүний эрх чөлөө 1-т гэж үздэг. Үндсэн хуульдаа итгэдэг хуульчид цаашилбал энэ хууль тогтоогчид бүх олон нийтээрээ та бүхэнд ингээд итгэлээ тавьж суух нь ээ. Бүх шийдвэрийг гаргахдаа энэ олон түмний итгэлийг мөн хуульч мэргэжлийн ёс зүй болоод хуульч мэргэжлийн бахархлыг бодож шийдвэр гаргахад оролцож цаашдаа энэ өнгөрсөн жилүүдэд хэдийгээр ийм шинэчлэх шаардлагатай хууль тогтоомжтой гар хүрч чадахгүй байгаа процесс нь тодорхойгүй ийм боловч Монгол Улсын ҮХЦ ингэж шударга сайн ажиллаж болох юм байна гэдгийг жишгийг тогтоохын төлөө хичээж ажиллаарай гэж захъя аа. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: 2 нэр дэвшигч хоёулаа миний нэг асуултад хариулаагүй. Та 2 бодож байгаад чуулган дээр ч юм уу ямар нэгэн байдлаар нэг хариулт өгөхийг бодоорой. Өнөөдрийн ХЗБХ-н дээр эрх хүртэлх процесс хэр шударга байсан бэ гэдэг дээр хэн аль нь хариулаагүй байгаа. Тэгээд ҮХЦ бол үндсэндээ улс төрийн карьераа төгсгөж байгаа хүмүүсийн очдог газар байх ёсгүй гэж боддог. Нэгэн цагт 2 нэр дэвшигчийн нэг нь улс төрийн өндөр мэргэшилтэй хүн байх гэдэг энэ шаардлагыг авч оёх ёстой ч гэдэг байр суурь илэрхийлж байсан. Бас тэрэндээ хэвээрээ байгаа болов уу гэж найдаж байна.

Тэгээд та 2-ыг нэр төртэйгөөр хуульчийн карьераа үргэлжлүүлээрэй. Бас нэр төртэйгөөр хуульчийн карьерыг төгсгөөрэй гэж чин сэтгэлээсээ хүсье. Зарим нэг манай хуульчид шиг ямар нөхцөл байдалд байгааг та бүхэн надаар хэлүүлэлтгүй мэдэж байгаа. Бүгд гадарлаж байгаа. Тэгээд хувь хүн дээр суурилсан институц биш, институцийн хэмжээнд Үндсэн хуулийн цэцийг аваачих маш том үүрэг хариуцлага та бүхэнд очиж байгаа.

Маш олон хуульчдын маш олон иргэдийн итгэл найдварыг бас тээж байгаа. Тэгэхээр зөвхөн хувь хүний асуудал бол ерөөсөө энэ чинь биш гэдгийг бол та бүхэн маань аль нь бол мэдэж байгаа байх гэж бодож байна. Тэгээд амжилт хүсье.

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

О.Номинчимэг: 2 нэр дэвшигч маань салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн хүн мэргэшсэн ийм хуульч нар байгаа. Тэгээд ҮХЦ-д нэр дэвшиж байгаа хүмүүс бол мэргэшсэн мэргэжлийн хуульчаас гадна Үндсэн хуулийн үнэт зүйлийг хамгаалах итгэл үнэмшил дээрээ бат зогсох улс төрийн нөлөөллөөс ангид байх энэ чадвар маш өндөр байх ёстой гэж сүүлийн би энэ парламентад орж ирснээсээ хойш ажиглаж байгаа зүйл дээр харагдаж байгаа.

Тэгээд түрүүн үгэнд дурдагдаж байна. Энэ 2 хүн бол хат суусан хүмүүс гээд. Тэгэхээр та бүхэн маань энэ хат суусан туршлагаа өөрсдийнхөө эзэмшсэн өндөр хууль зүйн мэргэшилтэйгээ хавсаргаад хэн нэгэн найз нөхдийн нөлөөллөөс ангид

Монгол Улсад Үндсэн хуульт ёс журам хууль дээдлэх ёс үйлчлэхийн төлөө хувь нэмрээ оруулна гэдэгт би хувьдаа итгэж байна. Тэгээд өнөөдөр мэдээж бид нар бүгдээрээ ингээд үгээ дайж байгаа. Та бүхэн маань ч гэсэн энэ чиглэлээр үүрэг амлалтаа өгнө. Гэхдээ үүрэг амлалтаас илүү үйлдэл маш чухал байдаг. Цаг хугацаа үүнийг харуулдаг.

Найз нөхөд хэн нэгэн нам эсвэл тэр бүлэглэлийн нөлөөлөлд оролгүйгээр эзэмшсэн мэргэжилдээ өргөсөн тангарагтаа үнэнч Монгол Улсад энэ хуульт ёсыг дээдлэх энэ асуудлыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулаасай гэж бодож байна. Тэгэхгүй бол яг үнэнийг хэлэхэд бид бүгд аман дээрээ хууль дээдлэх ёстой, хуулиа дээдлэх ёстой гэж байгаа боловчиг энэ бүүр лоозон шиг болоод байгаа асуудал дээр бол хуульч хүний хувьд ч гэсэн Улсын Их Хурлын гишүүний хувьд ч гэсэн эмзэглэж явдаг. Тэгээд энийг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулаасай гэж бодож байна аа. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Би нэг товчхон 2 үг хэлчихье гэж бодож байна. Энэ улсад миний хүндэтгэж явдаг яг хуульч талаас нь хүндэтгэж явдаг ийм 2 хүн нэр дэвшигч орж ирж байна. Тэгээд 1 зүйлийг хэлмээр байна. Та нар хэнд ч талархах тийм өргүй хүмүүс шүү. Энд шийдвэр гаргаж байгаа олонхоороо санал өгч гаргаж байгаа. Хэн нэгний хувьд та нар өргүй гэдгээ 1 дүгээрт сайн санах хэрэгтэй.

2.Энэ улсад хүн даргалдаггүй, хууль даргалдаг. Хууль гэж ганцхан л дарга байгаа гэдгийг бүгдэд нь мэдрүүлж ажиллаарай. Тэр хууль засаглана гэдэг чинь хоосон үг биш. Энэ бол энэ Улсын хамгийн суурь зарчим. Энийгээ сайн барьж ажиллаарай. Ямар ч тохиолдолд энэ ажлаа ав гээд аливаа нэгэн шахалт байгаа бол ажлаа өгөөд, хаалгаа саваад, хуулийнхаа талд зогсох ийм бэлэн байдалтай ажиллаарай гэж би та 2-оос хүсмээр байна.

Тэгээд гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалтдаа бэлдье гишүүд ээ.

Монгол Улсын Их Хурлаас ҮХЦ-ийн гишүүнд санал болгосон нэр дэвшигч Жамьянхорлоогийн Сүхбаатарыг ҮХЦ-ийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

75 хувиар санал дэмжигдлээ.

Пүрэвдорж гишүүнийг дэмжсэнд тооцож оруулаарай. Тэгвэл санал 75 хувь биш тэрийгээ засаж оруулаарай. Нэмэгдэх нь байна шүү. Монгол Улсын Их Хурлаас ҮХЦ-ийн гишүүнд санал болгосон нэр дэвшигч Ганбатын Эрдэнэбатыг ҮХЦ-ийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

75 хувиар санал дэмжигдлээ.

Пүрэвдорж гишүүнийг дэмжсэнд тооцоод энэ санал хураалтын дүн тэгвэл 75-аас дээш гарах нь байна шүү.

Ингээд санал дэмжигдлээ. Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд танилцуулна аа.

19.00 цаг

Дараагийн асуудалдаа оръё. Манайхан гишүүд байж байгаарай тэгвэл.

Хоёр.Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг Байнгын хорооны гишүүдэд тараасан байгаа.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Алтангэрэл танилцуулна аа. Алтангэрэл гишүүний микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурал 2026 оны 06 дугаар сарын 18, 19-ний өдрүүдэд чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу зарчмын зөрүүтэй 29 санал дээр гүйцээн боловсруулах чиглэл өгсөн тул Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй 32 саналыг гүйцээн боловсрууллаа.

Түүнчлэн ажлын хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 60, 75, 82 дугаар зүйлийн талаар дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн тул 3 саналыг боловсруулсан болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Алтангэрэл гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсгээ оруулаарай манайхан.

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт ирж оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя аа.

Пунцагийн Золзаяа ШЕЗ-ийн дарга, Доржсүрэнгийн Мөнгөнтуул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга, Дондогийн Давааням УБЕГ-ын дарга, Оюунбаатарын Оюунзул ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Няндагийн Наранцэцэг УБЕГ-ын Иргэний бүртгэлийн газрын дарга, Эрдэнэбаярын Баярбаясгалан ЦЕГ-ын Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, Батсайханы Тэнүүн Шүүх шинжилгээний ерөнхий газрын Байгалийн ухааны шинжилгээний хэлтсийн ДНХ шинжилгээний лабораторийн эрхлэгч, Зоригийн Түвшинжаргал Гэр бүлийн бодлого судлаач, Сөртөөний Пүрэвсайхан Боловсролын яамны Бодлого төлөвлөлтийн газрын шинжээч, Мангалсүрэнгийн Цогтбаатар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын Хүн ам, гэр бүлийн хөгжлийн бодлого төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч, Батсуурийн Нарангэрэл УБЕГ-ын Иргэний бүртгэлийн газрын Улсын ахлах бүртгэгч, Бямбаа-Юугийн Отгон УБЕГ-ын Иргэний бүртгэлийн газрын Улсын ахлах бүртгэгч, Сэргэлэнгийн Солонго Гадаадын иргэн харьяатын газрын Иргэний харьяаллын газрын харьяат хариуцсан ахлах мэргэжилтэн, Жавзандоржийн Азжаргал Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүүхдийн эрхийн хууль тогтоомж, бодлого төлөвлөлт хариуцсан шинжээч, Дамдинчойжилын Ундраа Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн гишүүн, Хүчирхийллийн эсрэг үндэсний хорооны гишүүн гэсэн ийм ажлын хэсэг хуралдаанд оролцож байна аа.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэгдсэн төсөл болон хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна аа. Эцсийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан гишүүд асуулт асууна. Асуух гишүүн байхгүй байгаа. Манайхан санал санал хураалтдаа бэлдье.

Уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгах санал.

Нэг.Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Нэг.Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар:

Д.Цогтбаатар: 1.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2.7 дахь заалтын “дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөө” гэснийг “хамтран өмчлөх дундын хөрөнгөө” гэж, 9.1 дэх хэсэг, 9.2.8 дахь заалтын “эд” гэснийг тус тус хасаж, 9.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 9.2 дахь хэсэг болгох:

“9.2.Гэрлэгчид гэр бүлийн харилцаанд дараах үүрэг хүлээнэ:

9.2.1.бие биеэ тэжээн тэтгэх, асран халамжлах;

9.2.2.бие биеийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, зөрчихгүй байх;

9.2.3.гэр бүлийн угийн бичиг хөтлөх;

9.2.4.гэр бүлийн үнэт зүйл, үндэсний соёл, уламжлал, зан заншлыг эрхэмлэх;

9.2.5.хамтын үүрэг, хариуцлагаа ухамсарлан бие биедээ үнэнч байх, гэр бүлийн хамтын амьдралаа тогтвортой байлгах, гэр бүлийн амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх.” Санал гаргасан ажлын хэсэг. Манайхан санал хураалтдаа бэлдсэн байгаа. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураая.

Санал хураалт.

55 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 10 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10 дугаар зүйл.Гэрлэлт дуусгавар болох

10.1.Гэрлэлтийг дараах тохиолдолд дуусгавар болсонд тооцно:

10.1.1.гэрлэгчдийн хэн нэг нь нас барсан;

10.1.2.гэрлэгчдийн хэн нэгнийг нас барсан гэж зарласан, эсхүл сураггүй алга болсон гэж тооцсон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;

10.1.3.Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу гэрлэгчдийн хэн нэг нь хүйсийн өөрчлөлтөө улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн.

10.2.Гэрлэлт дараах тохиолдолд дуусгавар болно:

10.2.1.захиргааны, эсхүл шүүхийн журмаар гэрлэлтээ цуцлуулсан;

10.2.2.гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон.

10.3.Энэ зүйлийн 10.1.3-т заасан хүйсийн өөрчлөлт тухайн хүний хөрөнгийн эрх болон эцэг, эхийн эрхийг хязгаарлах, үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.” Санал гаргасан ажлын хэсэг.

Дэмжье гэсэн томьёоллоор санал хураая.

Санал хураалт.

70 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 13 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13 дугаар зүйл.Гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлах

13.1.Энэ хуулийн 12.1-д зааснаас бусад тохиолдолд гэрлэлт цуцлуулах асуудлыг гэрлэгчдийн хэн нэгний, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүйд тооцогдсон эхнэр, нөхрийн асран хамгаалагчийн гаргасан нэхэмжлэлийн үндсэн дээр шүүх шийдвэрлэнэ.

13.2.Энэ хуулийн 10.1.3-т заасны дагуу гэрлэгчдийн хэн нэг нь хүйсийн өөрчлөлтөө иргэний улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, гэрлэлт дуусгавар болсон бол гэрлэлт цуцлахаас бусад хүүхдийн асрамж, тусдаа амьдрах эцэг, эсхүл эхийн хүүхэдтэй уулзах хуваарь, тэтгэлэг, хамтран өмчлөх дундын хөрөнгө хуваах асуудлаар гэрлэгчид нэхэмжлэл гаргах үүрэгтэй бөгөөд эдгээр асуудлыг уг нэхэмжлэлийн үндсэн дээр шүүх шийдвэрлэнэ.

13.3.Гэрлэгчид гэрлэлтийн гэрээнд хөрөнгийн эрх, үүргийг тусгасан эсэхээс үл хамаарч, гэрлэлт цуцлуулах үед хөрөнгийн эрх, үүргийн талаар харилцан тохиролцож болно.

13.4.Гэрлэгчид гэрлэлт цуцлах үед хүүхдийн асрамж, тусдаа амьдрах эцэг, эсхүл эхийн хүүхэдтэй уулзах хуваарь, тэтгэлэг болон хөдөлмөрийн чадваргүй эхнэр, нөхрөө тэжээн тэтгэх, хамтран өмчлөх дундын хөрөнгө хуваах асуудлыг бие даан, эсхүл эвлэрүүлэн зуучлалын журмаар харилцан тохиролцож болно.

13.5.Шүүх гэрлэлт цуцлах шийдвэр гаргахдаа хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаалах бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настан, хөдөлмөрийн чадваргүй, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэр бүлийн гишүүний эрүүл мэндийн байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг харгалзан үзнэ.

13.6.Шүүх гэрлэлт цуцлахдаа нэхэмжлэлийн шаардлагаас үл хамааран дараах асуудлыг шийдвэрлэнэ:

13.6.1.хүүхдийн асрамж;

13.6.2.хүүхдээс тусдаа амьдрах эцэг, эсхүл эхийн хүүхэдтэй уулзах хуваарь /нөхцөл, хэлбэр, байршил, хугацаа/;

13.6.3.тэтгэлгийн хэмжээ, нэмэлт зардал.

13.7.Шүүх энэ хуулийн 13.6.1, 13.6.2-т заасан асуудлыг шийдвэрлэхдээ хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хангаж, дараах нөхцөлийг харгалзан үзнэ:

13.7.1.хүүхдийн нас, бие махбод, оюун санаа, нийгэмшихүй, танин мэдэхүй, сэтгэхүй, хөгжил, сэтгэл зүйн онцлогт нийцсэн хэрэгцээ, шаардлагыг;

13.7.2.хүүхэд долоо, түүнээс дээш настай бол түүний саналыг;

13.7.3.хүүхдийн эцэг, эх, ах, эгч, дүү, эмээ, өвөө болон түүний амьдралд чухал нөлөө бүхий бусад хүнтэй тогтоосон харилцаа, ээнэгшсэн дассан байдал;

13.7.4.эцэг, эхийн хүүхдийг асран хамгаалж, хүмүүжүүлэхэд оролцож байсан оролцооны байдал, эцэг, эхийн халамж, ахуйн нөхцөл, чадавхыг;

13.7.5.хүүхдийг асран хамгаалах, хүмүүжүүлэх, хөгжүүлэх төлөвлөгөө, хүүхэдтэй харилцах чадвар, эцэг, эхийн амьдралын хэв маяг, эрүүл мэнд, эрхэлсэн ажил, ажлын цагийг;

13.7.6.гэрлэгчид хүүхдийн асрамжийн асуудлаар тохиролцсон эсэхийг;

13.7.7.эцэг, эхийн зан байдал, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн эсэх, хүүхдэд үзүүлэх нөлөөг.

13.8.Гэрлэгчид хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд нийцсэн байдлаар өөрөөр тохиролцоогүй бол шүүх энэ хуулийн 13.6.1-д заасан хүүхдийн асрамжийг хэрэгжүүлэхээр тогтоогдсон эцэг, эсхүл эхэд хүүхдийн асуудлаар шийдвэр гаргах эрхийг олгоно.

13.9.Шүүх энэ хуулийн 13.6.3-т заасан тэтгэлгийн хэмжээ, нэмэлт зардлыг энэ хуулийн долдугаар бүлэгт заасны дагуу шийдвэрлэнэ.

13.10.Эвлэрүүлэн зуучлагч эвлэрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагаас мэргэжил, арга зүйн дэмжлэг авч, хамтран ажиллаж болно.

13.11.Эхнэр нь жирэмсэн, эсхүл хүүхэд нь нэг нас хүрээгүй, эсхүл гэрлэгчдийн хэн нэг нь хүндээр өвчилсөн тохиолдолд гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг шүүх хүлээн авахаас татгалзана.

13.12.Гэрлэгчдийн хэн нэгний хүчирхийллээс болж, гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд аюул, хор уршиг учирч болзошгүйн улмаас гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг гаргахад энэ хуулийн 13.11-д заасан нь саад болохгүй.

13.13.Энэ хуулийн 13.11-д заасан нөхцөл байдал арилсан бол гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргаж болно.

Тайлбар:-Энэ хуулийн 13.6.1-д заасан “хүүхдийн асрамж” гэж хүүхдийг хэний асрамжид үлдээх буюу хүүхдийн амьдрах газрыг ойлгоно.

- Энэ хуулийн 13.8-д заасан “хүүхдийн асуудлаар шийдвэр гаргах эрх” гэж хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хүүхэд гадаад улсад зорчих, шашин шүтэх, эс шүтэх, хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх дугуйланд сургах зэрэг хүүхдийн хөгжил, хүүхдийн хуваарьт хөрөнгийг хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор захиран зарцуулах талаар шийдвэр гаргах эрхийг ойлгоно.

-Энэ хуулийн 13.11-д заасан “хүнд өвчтэй” гэж гэрлэгчдийн хэн нэг нь баривчлах шийтгэлээс чөлөөлөх өвчний жагсаалтад заасан өвчтэй бөгөөд шүүхэд гэрлэлт цуцлуулах асуудлыг хэлэлцэх үед өвчин нь хүндэрсэн шатандаа орсны улмаас өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах боломжгүй болох нь эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон байхыг ойлгоно. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураая.

Санал хураалт.

70 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 15 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15 дугаар зүйл.Шүүх гэр бүлийн нэг гишүүнд ногдох хөрөнгийг тодорхойлох

15.1.Гэрлэлт цуцалснаас гэр бүлийн дундаа хамтран өмчлөх хөрөнгөөс нэг гишүүнд ногдох хэсгийг тодорхойлоход гэрлэлтийн гэрээ, эсхүл гэрлэлтийн гэрээ байгуулаагүй бол Иргэний хуулийн 129, 130 дугаар зүйлд заасны дагуу шүүх шийдвэрлэнэ.

15.2.Гэрлэлтээс гадуурх харилцааны, эсхүл гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэрлэлт цуцалсан, эсхүл гэр бүлийн гишүүний эрүүл мэндийн байдал, хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлын үүднээс гэрлэлт цуцалсан, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон бол Иргэний хуулийн 129.3-т заасны дагуу гэр бүлийн дундаа хамтран өмчлөх хөрөнгөөс нэг гишүүнд ногдох хөрөнгийн хэсгийг тодорхойлохдоо шүүх өөрөөр тогтоож болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураая.

Санал хураалт.

70 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 24 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24 дүгээр зүйл.Хүүхдэд нэр, эцэг/эх/-ийн нэр, овог өгөх

24.1.Эцэг, эх харилцан зөвшилцсөний үндсэн дээр хүүхдэдээ нэр өгнө.

24.2.Хуульд өөрөөр заагаагүй бол хүүхэд эцгийн овог, нэрийг авна.

24.3.Хүүхдийн эцэг, эх нь гэрлэлтээ бүртгүүлээгүй бөгөөд харилцан тохиролцоогүй, эсхүл хүүхдийн эцгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогоогүй, эсхүл эцэг, эхийн хэн нэгний өмнөх гэрлэлт дуусгавар болоогүй бол эх нь хүүхдэд нэр өгөх бөгөөд хүүхэд эхийн овог, нэрийг авна.

24.4.Хүүхдийн эцэг, эх нь хэн болох нь тогтоогдоогүй бол улсын бүртгэлийн байгууллага хүүхдэд нэр, овог, эцэг /эх/-ийн нэр өгч болно.

24.5.Дараах тохиолдолд хүүхдийн эцэг, эсхүл эхийг тогтоосон эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн хүүхдэд овог, эцэг /эх/-ийн нэр өгнө:

24.5.1.хүүхдийн эцгийг тогтоосон бол эцгийн овог, нэрийг;
24.5.2.эцэг нь тодорхойгүй бөгөөд хүүхдийн эхийг тогтоосон бол эхийн овог, нэрийг.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураая.

Санал хураалт.

75 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 33 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 32 дугаар зүйл болгох:

“32 дугаар зүйл.Хүүхдийн асрамж, хүүхдээс тусдаа амьдарч байгаа эцэг, эхийн эрх, үүрэг

32.1.Гэрлэлтээ цуцлуулсан, эсхүл бусад шалтгаанаар хүүхдийн оршин суугаа газраас өөр газарт оршин сууж байгаа нь хүүхдийн өмнө хүлээх эцэг, эхийн үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

32.2.Хүүхдийн асрамж, хүүхдийн талаар шийдвэр гаргах болон тусдаа амьдрах эцэг, эсхүл эхийн хүүхэдтэй уулзах хуваарьтай холбоотой гаргасан шүүхийн шийдвэрийг эцэг, эх биелүүлэх үүрэгтэй.

32.3.Хүүхдээс тусдаа амьдрах эцэг, эсхүл эх хүүхдийн талаар мэдээлэл авах эрхтэй.

32.4.Хүүхдийн талаар шийдвэр гаргах эрхтэй эцэг, эсхүл эх нь хүүхдийн асуудлаар гаргасан аливаа шийдвэрийн талаар тусдаа амьдарч байгаа эцэг, эсхүл эхэд мэдээлэл өгөх үүрэгтэй.

32.5.Эцэг, эхийн хэн нэг нь, эсхүл 14 насанд хүрсэн хүүхэд тухайн хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл хүүхдийн асрамж болон хүүхдээс тусдаа амьдарч байгаа эцэг, эсхүл эхийн хүүхэдтэй уулзах хуваарийн талаарх шүүхийн шийдвэрийг өөрчлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

32.6.Гэрлэлтээ цуцлуулсан, эсхүл бусад шалтгаанаар эцэг, эх тусдаа амьдарч байгаа бол энэ хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхэд хэн нэгэндээ саад учруулахыг хориглоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураая.

Санал хураалт.

75 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 49 дүгээр зүйлийг 46 дугаар зүйл болгож, 49.4 дэх хэсгийн “49.1-д” гэснийг “46.1-д” гэж, 49.5 дахь хэсгийн “49.4-т” гэснийг “46.3-т” гэж, 49.8 дахь хэсгийн “хүүхдийн” гэснийг “түүний” гэж тус тус өөрчилж, 49.3 дахь хэсгийг хасаж, 49.1, 49.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 46.1, 46.2 дахь хэсэг болгох:

“46.1.Талууд энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасан тэжээн тэтгэх тухай гэрээ байгуулаагүй бол шүүх энэ хуулийн 46.2-т заасан тэтгэлэг тогтоох аргачлалын дагуу хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг харгалзан тэтгэлэг тогтооно.

46.2.Тэтгэлэг тогтоох аргачлалыг сар, улирал, хагас жил, эсхүл жилээр төлөх тэтгэлгийн хэмжээг тэтгэлэг төлөгчийн хөрөнгө, орлого, тэтгэлэг авагчийн хэрэгцээ, шаардлага, хүүхдийн нас, тоо, хүүхэдтэй уулзах хуваарь зэрэг нөхцөл байдлыг харгалзан хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураая.

Санал хураалт.

65 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 54 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 53 дугаар зүйл болгох:

“53 дугаар зүйл.Шүүхийн шийдвэрээр тогтоосон тэтгэлгийн хэмжээг өөрчлөх, тэжээн тэтгэх үүргээс чөлөөлөх

53.1.Тэжээн тэтгэх тухай гэрээ байгуулаагүй бөгөөд шүүхийн шийдвэрээр тэтгэлгийн хэмжээг тогтоосны дараа энэ хуулийн 44, 45 дугаар зүйлд заасан тэтгэлэг төлөгчийн хөрөнгө, орлого, бусад нөхцөл байдал өөрчлөгдсөн бол тэтгэлэг авагчийн, эсхүл тэтгэлэг төлөгчийн нэхэмжлэлийн үндсэн дээр тэтгэлгийн хэмжээг өөрчлөх эсэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ.

53.2.Шүүх энэ хуулийн 53.1-д заасан асуудлыг шийдвэрлэхдээ энэ хуулийн 46.2-т заасан аргачлалын дагуу дахин тогтооно.

53.3.Эцэг, эх, эсхүл төрлийн хүн нь хүүхдийг энэ хуульд заасан хугацаанд тэжээн тэтгэх, өсгөн хүмүүжүүлэх үүргээ ноцтой зөрчсөн нь шүүхээр тогтоогдсон бол хүүхэд 18 насанд хүрснээс хойш эцэг, эх, эсхүл төрлийн хүнээ тэжээн тэтгэх үүргээс бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн чөлөөлөгдөж болно.

53.4.Тэжээн тэтгүүлэгчийн тэжээн тэтгүүлэх эрхийн үндэслэл арилсан бол энэ хуулийн 43.1-д заасан этгээдийн тэжээн тэтгэх үүрэг дуусгавар болно.

53.5.Тэжээн тэтгүүлэгч нь тэжээн тэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн, хүчирхийлсэн, дарамталсан, гэм хор учруулсан, эсхүл учруулахаар завдсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон бол тэтгэлэг төлөгчийг тэжээн тэтгэх үүргээс шүүхийн шийдвэрээр чөлөөлнө. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураая.

Санал хураалт.

60 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 66 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 65 дугаар зүйл болгох:

“65 дугаар зүйл.Үрчлэгчийн эрх, үүрэг, хориглох зүйл

65.1.Үрчлэгч нь эцэг, эхийн нэгэн адил энэ хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

65.2.Үрчлэгч нь насанд хүрсэн, иргэний эрх зүйн чадамжтай, эрүүл мэндийн болон эдийн засгийн бүрэн чадавхтай хүн байх бөгөөд ашиг олох зорилгоор хүүхэд үрчлэн авахыг хориглоно.

65.3.Хүүхдийг дараах хүнд үрчлүүлэхийг хориглоно:

65.3.1.бусдын асрамж, дэмжлэгт байгаа хүн;

65.3.2.ганц бие 65, түүнээс дээш настай хүн;

65.3.3.шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн чадамжгүй, эсхүл хязгаарлагдмал чадамжтай гэж тогтоогдсон хүн;

65.3.4.эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, эсхүл хасуулсан хүн;

65.3.5.үрчлэн авсан хүүхдээ өөрийн буруугаас буцаан өгсөн хүн;

65.3.6.согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай хүн;

65.3.7.эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар эцэг, эх байх эрх, үүргийг биелүүлж чадахгүй болох нь тогтоогдсон хүн;

65.3.8.хорих ял эдэлж байгаа, эсхүл Эрүүгийн хуульд заасан хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг болон хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэж, эсхүл Эрүүгийн хуульд заасан бусад гэмт хэрэгт удаа дараа ял шийтгүүлж байсан хүн;

65.3.9.бүртгэлтэй хаяг дээрээ амьдардаггүй, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангахгүй орчинд амьдардаг хүн.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураая.

Санал хураалт.

65 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 68 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 67 дугаар зүйл болгох:

“67 дугаар зүйл.Хүүхэд үрчлэлтийн бүртгэл, хяналт

67.1.Хүүхэд үрчлүүлэх эсэх шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор тухайн шүүх шийдвэрийн хувийг улсын бүртгэлийн болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

67.2.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан нь үрчлэлтийн мэдээллийн сан /хүүхэд үрчлэх

хүсэлтэй иргэн, үрчлүүлэх хүүхдийн болон үрчлэгдсэн хүүхэд, үрчилж авсан иргэний мэдээлэл/ бүрдүүлнэ.

67.3.Аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага үрчлэгдсэн хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол хангагдаж байгаа эсэхэд түүнийг 18 насанд хүртэл хагас жил тутамд хяналт тавьж, хүүхдийн хөгжлийн тайланг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

67.4.Энэ хуулийн 67.2-т заасан мэдээллийн сан бүрдүүлэх, энэ хуулийн 67.3-т заасан үрчлэгдсэн хүүхдэд хяналт тавих журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

67.5.Аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага үрчлэгдсэн хүүхдийн эрх зөрчигдсөн нөхцөл байдал бий болсныг тогтоовол хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх үүрэгтэй.

67.6.Сонирхогч тал үрчлэгдсэн хүүхдийн эрх зөрчигдсөн гэж үзвэл үрчлэлтийг хүчингүй болсонд тооцуулах нэхэмжлэлийг шүүхэд гаргах эрхтэй. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураая.

Санал хураалт.

65 хувиар санал дэмжигдлээ.

11.Төслийн 83 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 82 дугаар зүйл болгох.

“82 дугаар зүйл.Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэх

82.1.Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэхэд Монгол Улсын олон улсын гэрээ, энэ хуулийг дагаж мөрдөнө.

82.2.Монгол Улсын харьяат хүүхдийг Монгол Улсын иргэн үрчлэн авах хүсэлт гаргаагүй бол хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд нийцүүлэн хүүхэд үрчлэн авахаар хүсэлт гаргасан гадаадын иргэн, гэр бүлд үрчлүүлнэ.

82.3.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэх талаар санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий гадаад үрчлэлтийн орон тооны бус зөвлөл /цаашид “Гадаад үрчлэлтийн зөвлөл” гэх/ ажиллана.

82.4.Гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтээ өөрийн орны эрх бүхий байгууллага, эсхүл зөвшөөрөлтэй итгэмжлэгдсэн байгууллагаар дамжуулан Гадаад үрчлэлтийн зөвлөлд гаргана.

82.5.Монгол Улсад 6 сараас доошгүй хугацаанд байнга оршин сууж байгаа гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэн авах хүсэлтээ энэ хуулийн

82.4-т заасан байгууллагаар дамжуулалгүйгээр Гадаад үрчлэлтийн зөвлөлд гаргана.

82.6.Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэн үрчлэн авахад энэ хуулийн 64, 65 дугаар зүйлд заасныг нотлох тайланг өөрийн улсын эрх бүхий байгууллагаас гаргуулж, энэ хуулийн 82.9-д заасан журмын дагуу ирүүлнэ.

82.7.Гадаад үрчлэлтийн зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн улс хооронд хүүхэд үрчлүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэх бөгөөд үрчлэгдсэн эсэх тухай шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш ажлын таван өдрийн дотор улсын бүртгэлийн болон гадаадын иргэний асуудал хариуцсан байгууллага, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

82.8.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол Улсын харьяат хүүхэд үрчлүүлэх тухай шүүхийн шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор үрчлэгчид мэдэгдэж, шийдвэрийн хувийг хүргүүлнэ.

82.9.Энэ хуулийн 82.3-т заасан Гадаад үрчлэлтийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн, гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

82.10.Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх асуудлыг энэ хуульд заасны дагуу шийдвэрлэнэ. Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын харьяат хүүхдийг тухайн улсын хуулийн дагуу үрчлүүлсэн нь Монгол Улсын олон улсын гэрээ, хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд харшлаагүй бол хүлээн зөвшөөрч болно.

82.11.Энэ хуулийн 65.3-т зааснаас гадна Монгол Улсаас албадан гаргасан, Монгол Улсын хилээр нэвтрүүлэхгүй байхаар тогтоосон хугацаа нь дуусаагүй байгаа гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэхийг хориглоно. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураая.

Санал хураалт.

55 хувиар санал дэмжигдлээ.

12.Төслийн 84 дүгээр зүйлийг 83 дугаар зүйл болгож, 84.5 дахь хэсгийн хууль ёсны гэснийг дээд гэж өөрчилж, 84.3, 84.4, 84.7, 84.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“83 дугаар зүйл.Гадаадын иргэнд үрчлэгдсэн хүүхдэд хяналт тавих

83.1.Гадаадын иргэнд үрчлэгдсэн хүүхдийн мэдээллийг энэ хуулийн 67.2-т заасан үрчлэлтийн мэдээллийн санд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтмол нийлүүлнэ.

83.2.Улс хооронд үрчлэгдсэн хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол хангагдаж байгаа эсэхэд тавих хяналтыг Дипломат төлөөлөгчийн газар хэрэгжүүлнэ.

Дипломат төлөөлөгчийн газар байхгүй тохиолдолд Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавьж, мэдээлэл авна.

83.3.Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авсан гадаадын иргэн, гэр бүл нь хүүхдийн хөгжлийн тайланг 18 насанд хүртэл хагас жил тутамд энэ хуулийн 83.2-т заасан байгууллагаар дамжуулан хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад болон гадаадын иргэний харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

83.4.Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын харьяат үрчлэгдсэн хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол зөрчигдсөн байж болзошгүй нөхцөл байдал ажиглагдсан, эсхүл тогтоогдсон бол Дипломат төлөөлөгчийн газар, гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон гадаадын иргэний харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэх үүрэгтэй.

83.5.Гадаад улсад оршин суугаагаас бусад гадаадын иргэнд үрчлэгдсэн Монгол Улсын харьяат хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол хангагдаж байгаа эсэхэд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуульд заасан хяналт тавьж, хүүхэд хөгжлийн тайланг хагас жил тутамд гаргана.

83.6.Гадаад улсад оршин суугаагаас бусад гадаадын иргэнд үрчлэгдсэн Монгол Улсын харьяат хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол зөрчигдсөн байж болзошгүй нөхцөл байдал ажиглагдсан, эсхүл тогтоогдсон бол хүн, хуулийн этгээд нь хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэх үүрэгтэй.

83.7.Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлсний дараа хяналт тавих, үрчлэгч талтай гэрээ байгуулах журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн, гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

83.8.Сонирхогч тал улс хооронд үрчлэгдсэн хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл үрчлэлтийг хүчингүй болсонд тооцуулах нэхэмжлэлийг Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тухайн хүүхдийг үрчлүүлэх шийдвэр гаргасан шүүхэд гаргаж, шийдвэрлүүлнэ. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураая. Түрүүн энэ 13 дугаар саналыг уншихад малгай нь дараах хэлбэртэй байсан байна шүү. Одоо энэ засвар орж байна. Одоо би уншлаа.

12.Төслийн 84 дүгээр зүйлийг 83 дугаар зүйл болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах:

Санал хураалт.

Саяын санал хураалтын дүн 57.9 хувиар санал дэмжигдлээ.

Хоёр.Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 8¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8¹.1.Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон тухай шүүхийн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүх иргэний улсын бүртгэлд бүртгүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Саяын санал хураалтын дүн 57.9 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж 6.1.5, 6.1.6 дахь заалт болгох:

“6.1.5.донорын бэлгийн эс ашиглаж хүүхэд төрсөн бол түүнийг нотлох эмнэлгийн байгууллагын магадлагаа болон хоорондын байгуулсан гэрээ;

6.1.6.донорын бэлгийн эс ашиглан тээгч эхээс хүүхэд төрсөн бол түүнийг нотлох эмнэлгийн байгууллагын магадлагаа болон хоорондын байгуулсан гэрээ.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Саяын санал хураалтын дүн 57.9 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 5 дахь заалт буюу 6 дугаар зүйлийн 6.19, 6.20 дахь хэсэг нэмэх:

“6.19.донорын бэлгийн эс ашиглаж төрсөн хүүхдийн төрсний бүртгэлийг Гэр бүлийн тухай хуулийн 27.2-т заасан эцэг, эхийн овог, нэрээр бүртгэж төрсний гэрчилгээ олгоно.

6.20.донорын бэлгийн эс ашиглан тээгч эхээс төрсөн хүүхдийн төрсний бүртгэлийг Гэр бүлийн тухай хуулийн 27.2-т заасан эцэг, эхийн овог, нэрээр бүртгэж төрсний гэрчилгээ олгоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Саяын санал хураалтын дүн 52.6 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.3.Гэрлэлтийг шүүхийн журмаар цуцалсан бол гэрлэлт цуцалсан тухай шүүхийн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүх иргэний улсын бүртгэлд бүртгүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Саяын санал хураалтын дүн 52.6 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 9 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9 дүгээр зүйл.Гэрлэлт сэргээсний бүртгэл

9.1.Гэр бүлийн тухай хуулийн 18.1-д заасны дагуу иргэн гэрлэлт сэргээсний бүртгэлд бүртгүүлэх бол дараах баримт бичгийг бүрдүүлж, өөрийн биеэр бүртгүүлнэ:

9.1.1.тус тусдаа гаргасан өргөдөл;

9.1.2.иргэний үнэмлэх, эсхүл иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, эсхүл паспортыг орлох баримт бичиг.

9.2.Гэр бүлийн тухай хуулийн 18.2, 18.3-т заасны дагуу гэрлэлтийг сэргээсэн бол гэрлэлт сэргээсэн тухай шүүхийн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш ажлын гурван өдрийн дотор тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүх иргэний улсын бүртгэлд бүртгүүлнэ.

9.3.Иргэнийг нас барсан гэж зарласан, сураггүй алга болсонд тооцсон шүүхийн шийдвэрийг хүчингүй болсонд тооцох тухай шүүхийн шийдвэрийг энэ хуулийн 9.2-т заасан баримт бичигт хавсаргана.

9.4.Гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцсон бол гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус тооцсон тухай шүүхийн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүх иргэний улсын бүртгэлд бүртгүүлнэ.

9.5.Улсын бүртгэгч, бүртгэлийн ажилтан энэ хуулийн 9.1, 9.2, 9.3, 9.4-т заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор гэрлэлт сэргээсний бүртгэлийг хөтөлнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Саяын санал хураалтын дүн 52.6 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 3 дугаар зүйлд “Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн” гэсний дараа “7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “8 дугаар зүйлд” гэснийг “5.3-т” гэж, мөн зүйлийн 7.8 дахь заалтын “9 дүгээр” гэснийг “7 дугаар” гэж” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Саяын санал хураалтын дүн 52.6 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 3 дугаар зүйлийн ““нас барсны бүртгэлд” гэснийг “Гэр бүлийн тухай хуулийн 10.1.1, 10.1.2, 10.1.4-т заасан тохиолдол бий болсон” гэж” гэснийг ““Гэрлэгч нас барсны бүртгэлд бүртгэгдсэн” гэснийг “Гэрлэгч нас барсны, эсхүл хүйс

өөрчлөгдсөн бүртгэлд, эсхүл нас барсан гэж зарласан, эсхүл сураггүй алга болсонд тооцсон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон” гэж” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Саяын санал хураалтын дүн 52.6 хувиар санал дэмжигдлээ.

Гурав.Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 127 дугаар зүйлийн 127.4, 127.5 дахь заалтыг хасаж, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 127 дугаар зүйлийн 127.7 дахь хэсгийг 127.5 дахь хэсэг болгох. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Саяын санал хураалтын дүн 52.6 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт буюу 517 дугаар зүйлийн 517.3 дахь хэсэг нэмэх:

“517.3.Өвлүүлэгчийг 18 насанд хүртэл тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон бол өвлөх гэрээслэлд өөрөөр заагаагүй тохиолдолд уг этгээд хуульд заасан өвлөх эрхээ алдана.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Саяын санал хураалтын дүн 52.6 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 129 дүгээр зүйлийн 129.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“129.3.Гэрлэлт дуусгавар болсонтой холбоотойгоор гэр бүлийн нэг гишүүнд ногдох эд хөрөнгийг тодорхойлохдоо хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол, гэрлэгчдийн эрүүл мэндийн байдал болон хуульд заасан бусад нөхцөлийг харгалзан шүүх өөрөөр тогтоож болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Саяын санал хураалтын дүн 52.6 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 133 дугаар зүйлийн 133.2 дахь хэсгийн “энэ хууль болон” гэснийг, мөн зүйлийн 4 дэх заалт буюу 517 дугаар зүйлийн 517.1 дэх хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Саяын санал хураалтын дүн 52.6 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 4 дүгээр зүйлийн “”127.6”” гэснийг “”127.4”” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Саяын санал хураалтын дүн 52.6 хувиар санал дэмжигдлээ.

Дөрөв.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “заалт,” гэснийг “заалтын” гэж өөрчилж, “мөн зүйлийн 7, 9 дэх хэсэг, 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Саяын санал хураалтын дүн 47.4 хувиар санал дэмжигдсэнгүй
Одонтуяа гишүүний микрофоныг өгье.

С.Одонтуяа: Энэ төхөөрөмж ажилласангүй. Энэ дээр горимын санал гаргаж байна. Хүчингүй болгож өгнө үү.

Д.Цогтбаатар: Саяын горимын саналаар энэ саналыг хүчингүй болгох санал хураалт явуулъя.

Санал хураалт.

52.6 хувиар санал дэмжигдлээ.

Түрүүний уншиж танилцуулсан томъёоллоор санал хураалт явуулъя.

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Санал хураалт.

52.6 хувиар санал дэмжигдлээ.

Тав.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт буюу Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 1.1.4 дэх заалт нэмэх:

1/6.20 дугаар зүйлийн 1.1.4 дэх заалт:

“1.1.4.хүүхдээ үе тэнгийн дээрэлхэлт үйлдэхээс урьдчилан сэргийлэх үүргээ биелүүлээгүй;”

2.Төслийн 1 дүгээр зүйлийн буюу Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 14 дэх хэсгийн “торгох, эсхүл албадан сургалтад хамруулж, долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.” гэснийг “торгоно.” гэж өөрчилж, мөн зүйлийн 14, 15 дахь хэсгийг төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт болгох.

3.Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 1.1.4 дэх заалтын дугаарыг “1.1.5” гэж өөрчлөх.”

4.Төслийн 2 дугаар зүйлийг 3 дугаар зүйл болгох. Яаж байна, аан за.

Дахиад уншъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт буюу Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 1.1.4 дэх заалт нэмэх:

1/6.20 дугаар зүйлийн 1.1.4 дэх заалт:

“1.1.4.хүүхдээ үе тэнгийн дээрэлхэлт үйлдэхээс урьдчилан сэргийлэх үүргээ биелүүлээгүй;” Энийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

52.6 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн буюу Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 14 дэх хэсгийн “торгох, эсхүл албадан сургалтад хамруулж, долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.” гэснийг “торгоно.” гэж өөрчилж, мөн зүйлийн 14, 15 дахь хэсгийг төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт болгох. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

57.9 хувиар санал дэмжигдлээ.

3.Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 1.1.4 дэх заалтын дугаарыг “1.1.5” гэж өөрчлөх.” Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Тулга гишүүний микрофоныг өгье.

Б.Тулга: Уучлаарай. Төхөөрөмжтэйгөө буруу харьцаад дэмжих гэж байгаад буруу өгчихлөө. Хүчингүй болгож өгнө үү.

Д.Цогтбаатар: Саяын саналыг хүчингүй болгох горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Санал хураалт.

52.6 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар зүйлийг 3 дугаар зүйл болгох. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

52.6 хувиар санал дэмжигдлээ.

Зургаа.Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “55.2.1-55.2.6, 55.3.1-55.3.6-д” гэснийг “54.1, 54.2-т” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

52.6 хувиар санал дэмжигдлээ.

Долоо.Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол:

1.Төслийн 1 дүгээр зүйл буюу Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.7.“бүтэн өнчин хүүхэд” гэж Гэр бүлийн тухай хуулийн 4.1.2-т заасныг.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

52.6 хувиар санал дэмжигдлээ.

1. Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

52.6 хувиар санал дэмжигдлээ.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасны дагуу хураалгах санал.

Гэр бүлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн 60 дугаар зүйлийг 59 дүгээр зүйл болгож, 60.1.1 дэх заалтын “сурч” гэсний өмнө “хөгжүүлэх,” гэж нэмж, 60.1.3 дахь заалтын “үл хөдлөх эд хөрөнгө, мал, банкинд хадгалуулсан мөнгөн хадгаламж, бусад үнэт зүйлийг” гэснийг “хөрөнгийг” гэж, “тухайн сум, баг, дүүрэг, хорооны” гэснийг “харьяа сум, дүүргийн” гэж, 60.1.4 дэх заалтын “тухайн сум, баг, дүүрэг, хорооны” гэснийг “харьяа сум, дүүргийн” гэж, 60.2.3 дахь заалтын “асрамж,” гэснийг “асран хамгаалалт, харгалзан” гэж, 60.2.4 дэх заалтын “эд хөрөнгийг” гэснийг “хөрөнгийг” гэж, 60.2.5 дахь заалтын “баг, дүүрэг, хорооны” гэснийг “дүүргийн” гэж, 60.3 дахь хэсгийн “бага насны” гэснийг “долоон насанд хүрээгүй” гэж тус тус өөрчилж, 60.2.4 дэх заалтын “, дэнчин тавих” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

76.5 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 75 дугаар зүйлийг 74 дүгээр зүйл болгож, 75.1 дэх хэсгийн “хуулийн зарчимд харшлахгүй бол гэрлэлтийг Монгол Улсад хүчинтэйд тооцно.” гэснийг “хуульд заасан нөхцөлийг хангаж, гэрлэхэд харшлах шалтгаангүй бол Монгол Улсад гэрлэлтийг хүчин төгөлдөр гэж үзэж, хүлээн зөвшөөрнө.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

52.6 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 82 дүгээр зүйлийг 81 дүгээр зүйл болгож, 82.2 дахь хэсгийн “хуулиар асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосон нь энэ хуульд харшлаагүй бол хүчинтэйд” гэснийг “хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий байгууллагын шийдвэрээр асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосон нь энэ хуульд харшлаагүй бол Монгол Улсад хүчин төгөлдөр гэж” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

76.5 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Саяынх тэгвэл томьёолол зөв байгаа юм байна аа. Хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжин танилцуулна аа.

20.08 цаг

Дараагийн асуудалдаа орёе. Энэ дээр би нэг горимын санал гаргамаар байна. Эндээсээ шууд залгуулаад нөгөө гэр бүлийн юу процессын тухай хуулиа явуулчихъя гэж бодож байна. 10 дээр юу уншигдсан байгаа юм. Тэгэхээр горимын санал гаргаж байна. Энийг тэр чинь 10 биш 11 дэх болчихсон байгаа. Ингээд сая миний гаргасан саналаар Гэр бүлийн процессын хуулийг 3 дахь асуудал болгохыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

76.5 хувиар санал дэмжигдлээ.

Гурав.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Ингээд Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг Байнгын хорооны гишүүдэд тараасан байгаа.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал танилцуулна аа.

Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 3Г-аас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурал 2026 оны 6 сарын 18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчдаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хурал хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн талаар нэг санал хамт өргөн мэдүүлсэн хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар нэг зарчмын зөрүүтэй саналыг гүйцээн боловсрууллаа.

Түүнчлэн ажлын хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу ЭХХШТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах 8.6 дугаар зүйлийн талаар дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн тул зарчмын зөрүүтэй нэг саналыг боловсруулсан болно оо. Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг та бүхэнд хүргүүлсэн болно оо.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөлд зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Баасанжаргал гишүүнд баярлалаа. Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулахтай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Эцсийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан гишүүд асуулт асууж хариулт авах хүн байхгүй байна.

Нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг гүйцээн боловсруулж хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Улсын Их Хурлын даргаас чиглэл өгсөн бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1, 42.2.3 дахь заалтад заасны дагуу хураалгах зарчмын зөрүүтэй 3 саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Ажлын хэсгээ би танилцуулаадахъя.

Энэ процессын хууль хэлэлцүүлэхтэй холбогдуулан дараах ажлын хэсэг өнөөдрийн хуралдаанд оролцож байна.

Нямдоржийн Одонтуул Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн шүүгч, Доржсүрэнгийн Мөнгөнтуул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга, Оюунбаатарын Оюунзул ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын үүргийг түр ор хурлан гүйцэтгэгч, Баатарсүрэнгийн Батзориг ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн дарга, Эрдэнэбаярын Баярбаясгалан ЦЕГ-ын Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байна аа.

Ингээд санал хураалтаа явуулна.

3 томъёоллоор санал хураалт явуулъя гэж байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгах санал.

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол

“37 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлах багийн сэтгэл зүйч

37.1.Эвлэрүүлэн зуучлах багийн сэтгэл зүйчийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага томилох бөгөөд сэтгэл зүйч нь төрийн захиргааны албан хаагч байна.

37.2.Энэ хуулийн 37.1-д заасан сэтгэл зүйч нь шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагааны эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцож болох бөгөөд ажиллах журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” Саяын ингэж уншиж танилцуулснаар санал хураалт явуулъя. Дэмжье гэж санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Уучлаарай санал хураалтдаа бэлдье.

Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Энийг Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам 1 дүгээрт өөрсдөө яг энэ саналыг гаргасан.

Хоёрдугаарт энд үндэслэл нь 2 үндэслэл байгаа.

Нэгдүгээрт яг энэ шүүх анх удаагаа байгуулагдаж байгаа бөгөөд яг энэ сэтгэл зүйчийн орон тоог нь тогтвортой байлгах нь хамгийн чухал байгаа юм гэдэг нэг үндсэн тайлбар байгаа.

Хоёрдугаарт яалт ч үгүй яг энэ нөгөө төсөвтэй холбоотой байгаад байгаа яг нөгөө сэтгэл зүйч дээр гарах яг энэ зардал, цалин хөлсний асуудлыг яг энэ ганцхан энэ процесс хуулийн ганцхан энэ заалт л энэнтэй холбоотой гарч байгаа зардлыг л Хүүхэд гэр бүлийн яамны төсөвт орж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ төсөвт нь орж байгаа учраас энэ утгаараа яамны зүгээс гаргасан санал.

Д.Цогтбаатар: Саяын уншиж танилцуулсан томьёоллоор дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

76.5 хувиар санал дэмжигдлээ.

“Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн нэрийг “Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” гэж өөрчилж, төслийн 1, 2, 3, 4, 5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 1 дүгээр зүйлийн Гурав дахь хэсэг, 2 дугаар зүйлийн Дөрөв дэх хэсгийн хэрэгжилтийг хангуулах, Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасугай:

1/нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн онцлог, зориулалтад нийцсэн, стандартын шаардлага хангасан шүүхийн барилга байгууламж шинээр барих байршил, газрын асуудлыг судалж, шийдвэрлэх;

2/нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн барилга байгууламжийг барихад шаардагдах зардал болон гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх бусад шүүхийн барилгад зориулалтын шүүх хуралдааны танхим, хүүхдээс мэдүүлэг авах тусгай өрөө байгуулах асуудлыг судалж, Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд тусгаж, санхүүжүүлэх арга хэмжээг авах;

3/Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20.1-д заасан Хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн, гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь эвлэрүүлэн зуучлах багийн сэтгэл зүйч, мэргэжилтэнд холбогдох зардлыг Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд тусгаж, санхүүжүүлэх;

4/гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах, шүүхийн цахим үйлчилгээний үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хэрэг, маргааныг шуурхай, үр дүнтэй шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэхэд шаардагдах зардлыг Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд тусгаж, санхүүжүүлэх.

2.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи /Д.Эрдэнэчимэг/-д даалгасугай:

1/гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийг мэргэшүүлэн шинээр батлагдсан хууль тогтоомж, хүүхэд, гэр бүлийн чиглэлээр сургаж, бэлтгэх;

2/нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны шүүх болон дүүргийн, сум, сум дундын анхан шатны шүүхийн эвлэрүүлэн зуучлалын багт ажиллах шүүгчийг сургах арга хэмжээ авах.

3.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Шүүхийн ерөнхий зөвлөл /П.Золзаяа/-д даалгасугай:

1/Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20.1-д заасан хүүхэд, гэр бүлийн мэргэжилтнийг сургах;

2/гэр бүлийн маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах эвлэрүүлэн зуучлагчийг мэргэшүүлэн сургах;

3/гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь эвлэрүүлэн зуучлах багийн сэтгэл зүйчийг мэргэшүүлэх, давтан сургах сургалтын хөтөлбөрийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага /Б.Баярсайхан/-тай хамтран баталж, хэрэгжүүлэх.

4.Өсвөр насны хүнд авсан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж, бэлтгэл ажил хангахыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага/ Б.Баярсайхан/, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар /А.Намсаманд/-т тус тус даалгасугай.

5.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуультай хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль батлагдсантай холбогдуулан хугацаанаас өмнө суллагдах сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял эдэлж байгаа өсвөр насны хүний талаар санал гаргаж, танилцуулахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар /А.Намсаманд/, суллагдсан өсвөр насны хүнд хяналт, тавьж холбон зуучлах үйлчилгээ үзүүлэхийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага/ Б.Баярсайхан/, хүүхдийн эрхийн хууль зүйн хороонд тус тус даалгасугай.

6.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэгт заасан хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн хэрэг, маргаанд шинжээчийн дүгнэлт гаргах мэргэжилтнийг бэлтгэх, сургах, гэрчилгээжүүлэх ажлыг 2026 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор хамтран хэрэгжүүлэхийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Шүүхийн ерөнхий зөвлөлд тус тус даалгасугай.

7.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсэгт заасан “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгааллын журам”-ыг 2026 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор баталж, хэрэгжүүлэхийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Улсын ерөнхий прокурор, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргад тус тус даалгасугай.

8.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 25.3 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу арван зургаан насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах ажиллагааг явуулахад шаардагдах дуу-дүрсний бичлэг хийх зориулалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг бэлтгэх, шинэчлэх асуудлыг судалж, Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд тусгаж, шийдвэрлэх арга хэмжээ авахыг холбогдох байгууллагын удирдлагуудад даалгасугай.

9.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 37 дугаар 37.2 дахь хэсэгт заасан эвлэрүүлэн зуучлах багийн сэтгэл зүйчийн ажиллах журмыг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор баталж, хэрэгжүүлэхийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд даалгасугай.

10.Гэрлэлт цуцлах, хүүхдийн асрамж, эцэг, эсхүл эх хүүхэдтэй уулзах хуваарь болон тэтгэлэг тогтоох, хөрөнгөтэй холбоотой болон бусад гэр бүл, хүүхдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох хуульч, өмгөөлөгчийг мэргэшүүлэн сургах арга хэмжээ авахыг Монголын хуульчдын холбооны ерөнхийлөгч /М.Мөнхбат/, Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч /Л.Данзанноров/-т зөвлөсүгэй.

10.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Д.Цогтбаатар/-нд даалгасугай.

11.Энэ тогтоолыг 2026 оны 07 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Ер нь тогтоолын төслийн яах вэ? Агуулгыг ойлгож дэмжиж байна. Тэгэхдээ энэ техникийн юун дээр жишээ нь ийм байгаа байхгүй юу. 3 дахь заалтын 3 буюу ингээд сэтгэл зүйчийг мэргэшүүлэх давтан сургах сургалтын хөтөлбөрийг Агентлаг ШЕЗ 2 хамтрахаар байгаа. Бид хэд уг нь яг тодорхой түвшинд ЗГ-ын гишүүнд нь л үүрэг өгмөөр байна. Ингэж доошоо ингээд явуулах ерөөсөө шаардлага байхгүй, 1 дүгээрт.

Хоёрдугаарт бүүр сүүлдээ ингээд Хууль зүйн сайдгүй болчихсон юм шиг Намсамандад нь үүрэг өгдөг, Баярсайханд нь үүрэг өгчихсөн. Энэ чинь яг нарийн яривал ЗГ-ыг ерөнхийд нь өгөх ёстой. Эсвэл Аубакир, Амарсайхан гэж өгмөөр байна. Ийм 4 дүгээр зүйл дээр байна. Та мөн яг ялгаа байхгүй. Ийм зүйлүүдийг байхгүй ингээд хууль зүйн бодлогыг Засгийн газар дээр хариуцдаг сайдад нь биш ингээд доод талынх нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн дарга нь Улсын Их Хуралд юм тайлагнана гээд орж ирэх энэ буруу жишиг шүү. Аймаар буруу жишиг рүү явж байна.

Тэгээд энийгээ нэг засаад техникийн хувьд агуулгын хувьд оруулчхаач тэгээд дэмжээд явчихмаар.

Д.Цогтбаатар: Сая Сайнзориг гишүүний санал яах аргагүй зөв санал байна шүү.

Тийм учраас Их Хурал бол засагтай сайд нартай л харьцана шүү дээ.

Тэгэхээр энэ саяын оруулсан санаануудыг энэ бол техникийн жижиг өөрчлөлт оруулах санал учраас тэр юу агентлагийн дарга нарыг биш ЗГ-ын асуудал эрхэлсэн сайд нарыг энэнд нь тусгаж оруулъя. Тэгээд тогтоолыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт 76.5 хувиар санал дэмжигдлээ.

Би энэ өнөөдөр хуралдаа идэвхтэй орж байгаа гишүүддээ нээрээ талархал илэрхийлмээр байна аа. Шөнө оройгоор суугаад л манай гишүүд ажиллаж байгаа шүү. Энэ чинь зурагтаар бүгд харагдаж байгаа харагдаж байгаа.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу хураалгах санал.

Гурав.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, “3 дугаар зүйл” болгон өөрчлөх:

“3 дугаар зүйл.Эрүүгийн хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/8.6 дугаар зүйл:

“8.6 дугаар зүйл.Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах

1.Шүүх энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг арван хоёр жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно.

2.Өсвөр насны хүний шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан бол энэ хуулийн 7.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, 8.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үүрэг хүлээлгэж, хязгаарлалт тогтоох хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авна.

3.Өсвөр насны хүнд шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулж хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх байгууллага хамтран хэрэгжүүлэх талаар шүүхийн шийдвэрт тусгана.

4.Өсвөр насны хүний шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацааны 50 хувь өнгөрсөн, шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлж, эрхийн хязгаарлалтыг зөрчөөгүй бол цаашид хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх шаардлагагүй талаарх прокурорын дүгнэлтийг үндэслэн хугацаанаас өмнө эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно.

5.Өсвөр насны хүн шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

6.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүн шүүхээс тогтоосон хугацаанд хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, тогтоосон хязгаарлалтыг зөрчсөн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, ялыг биечлэн эдлүүлэх тухай шийдвэр гаргана.

7.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд өсвөр насны хүн санаатай гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд энэ хуулийн 6.9 дүгээр зүйлд заасныг баримтлан ял оногдуулна.

8.Шүүх прокурорын дүгнэлтийг үндэслэн өсвөр насны хүнд шүүхийн шийтгэх тогтоолыг хойшлуулсан хугацаанд хүлээлгэсэн энэ хуулийн 8.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үүрэг, хязгаарлалтыг өөрчилж болно.

2/8.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

2.Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг гэм бурууг нь ухамсарлуулах, хохирлыг нөхөн төлүүлэх, хөдөлмөрлөх, амьдрах зөв арга барилд сургах, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор энэ хуулийн 7.3 дугаар зүйлийн 2,

3 дахь хэсэгт заасан үүрэг, хязгаарлалтаас гадна дараах үүрэг, хязгаарлалтыг хүлээлгэнэ:

2.1.өсвөр насны хүнд болон түүний гэр бүлд сэтгэл зүйчээс зөвөлгөө, эмчилгээ авахыг даалгах;

2.2.нийгэмд чиглэсэн сайн дурын үйл ажиллагаанд хамруулах;

2.3.хичээлийн ирцээ тогтмол хүргүүлэхийг даалгах;

2.4.хохирогчоос уучлал хүсэхийг даалгах;

2.5.шөнийн цагаар гэртээ байхыг даалгах;

2.6.өсвөр насны хүнийг хүмүүжүүлэхэд шаардлагатай бусад.” Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

70.6 хувиар санал дэмжигдлээ. 3-ны 2-оор дэмжигдлээ.

Хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал танилцуулна аа.

20.32 цаг

Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа. Завсарлаад манайхан завсарлаад гялс түр завсарлаад хоолоо идчихээд орж ирье хэдүүлээ.

Сая түр завсарлалаа.

Дараагийн асуудалдаа оръё.

Дөрөв.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан анхны хэлэлцүүлгийг явуулъя аа.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай Хуулийн 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсэгт заасны дагуу боловсруулсан талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Алтангэрэл хийнэ ээ. Алтангэрэл гишүүний микрофоныг өгье өө.

О.Алтангэрэл: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурал 2026 оны 6 дугаар сарын 18 19-ний өдрүүдэд чуулганы нэгдсэн хуралдаанд ярилцаж эцсийн хэлэлцүүлэг бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл тус хуулийн зүйл, болон хэсэг заалтын дугаар өөрчлөгдөж байгаа болно оо.

Нийгмийн даатгалын сангаас олгуулах Тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтад Гэр бүлийн тухай хуулийн 7.1-д зааснаар бүртгүүлсэн гэж, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтад Хууль ёсны төлөөлөгч, эцэг, эх, асран хамгаалагчийн тогтоогддог иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай сэтгэцийн эмэгтэй хүнийг асран хан халамжлах асуудлыг Гэр бүлийн тухай хуулийн 63, 64 дүгээр заалтын тухай шийдвэрлэх гэж, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.6 дахь заалтад Гэр бүлийн тухай хуулийн 3.1.4 дахь заалтаас хоорондоо газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ үнэ төлбөр рүү шилжүүлэх замаар олсон орлого гэж Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.4 дэх заалтад Гэр бүлийн гишүүн Гэр бүлийн тухай хуулийн 3.1.4-д заасныг гэж, мөн зүйлийн 1.19 дэх заалтыг садангийн хүн гэж, Гэр бүлийн тухай хуулийн 3.1.6-д заасныг гэж, мөн зүйлийн 1.22 дахь заалт нь төрлийн хүн гэж Гэр бүлийн тухай хуулийн 3.1.5-д заасныг гэж Эцэг, эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтад асран хамгаалагч харгалзан дэмжигчийг Гэр бүлийн тухай хуулийн 67.1.1-д заасны дагуу хууль, ёсны, асран хамгаалагч, харгалзан дэмжихээр тогтоогдсон хүнийг гэж, мөн зүйлийн 3.1.2 дахь заалтад хүүхэд үрчлэн авах гэж, Гэр бүлийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу хүүхэд үрчлэн авахыг тус тус заасан.

Дээрх хуулиудад өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Монгол Улсын Засгийн газраас Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлээгүй тул Ажлын хэсэг, хууль хоорондын нийцлийг хангах үүднээс нийгмийн даатгалын сангаас олгох Тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулсан болно оо.

Түүнчлэн Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хүүхдийн тэтгэлэгтэй холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгосонтой холбогдуулан хүүхдийн тэтгэлэг төлөх үүргээ биелүүлээгүй төлбөр төлөгчид авах арга хэмжээг боловсронгуй болгож хүүхдийн тэтгэлэг төлөхтэй холбоотой шүүхийн шийдвэрийн бэлтгэлийг хангах эрх зүйн зохицуулалтыг сайжруулах тухай хуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулсан болно оо.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт

оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Алтангэрэл гишүүнд баярлалаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье ээ.

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү? Алга байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

2 дугаар зүйл. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй тул хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргаж байна аа.

Энэ горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хурааа. Гишүүд хураалтдаа бэлдээрэй. Саяын горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

52.6 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Тулга танилцуулна аа.

20.54 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Тав.Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

1 дүгээр зүйл. Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

2 дугаар зүйл. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгье. Алга байна. Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй тул хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргаж байна аа.

Энэ горимын саналыг дэмжиж өгөхийг хүсье. Санал хураалтад бэлэн байгаа.

Горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

52.9 хувиар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар танилцуулна аа.

20.57 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Зургаа.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

1 дүгээр зүйл. Хувь хүний орлогын албан татварын хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Алга байна.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

2 дугаар зүйл. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Байхгүй байна.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй тул хуулийн төслийн анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргаж байна аа.

Энэ саналыг дэмжиж өгөхийг хүсье.

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя санал хураалт явуулъя.

Санал хураалтдаа бэлдье гишүүд ээ. Саяын санал хураалтыг хүчингүй болгоё. Бэлдсэн байгаа юу манай гишүүд.

Санал хураалт.

Горимын санал 58.8 хувиар дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар танилцуулна аа.

21.00 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Долоо.Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай төсөл /Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан анхны хэлэлцүүлгийг явуулъя аа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэг хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

1 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг шүү шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй тул хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргаж байна.

Горимын саналыг дэмжиж өгөхийг хүсье.

Санал хураалт.

Санал хураалтдаа бэлдье.

Саяын горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явууллаа.

Санал хураалт.

58.8 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг танилцуулна аа.

21.03 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Найм.Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан анхны хэлэлцүүлгийг явуулъя аа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

1 дүгээр зүйл. Эх, эцэг олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Эцэг эх олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

2 дугаар зүйл. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Эх эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй тул хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргаж байна. Дэмжиж өгөхийг хүсье.

Манайхан санал хураалтдаа бэлдье. Саяын горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

58.8 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Нарантуяа танилцуулна аа.

21.05 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Ес.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

1 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

2 дугаар зүйл. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Алтангэрэл гишүүний микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Энэ гишүүд ээ. Нөгөө хүүхдийн тэтгэлэг төлөх үүргээ хугацаанд нь биелүүлээгүй бол зээлийн мэдээллийн санд оруулна гээд энд өөрчлөлт орж байгаа юм. Тэгээд тэр нөгөө мэдээллийг нь нээлттэй байя гээд тэгээд ер нь энэ хүүхдийн тэтгэлэгтэй холбоотой бид нар яг өнөөдөр шийдэж болох түвшиндээ тэрний биелэлтийг сайжруулах чиглэлээр өөрчлөлт оруулж байгаа шүү. Гишүүдээс маань асуулт асуувал мэдээлэлтэй байх үүднээс хэллээ. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Сая 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууссан.

2 дугаар зүйл. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү? Алга байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

3 дугаар зүйл. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй тул хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргаж байна.

Санал хураалтыг дэмжихийг хүсэж байна.

Санал хураалтдаа бэлдье манайхан.

Горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Тулга гишүүний микрофоныг өгье.

Б.Тулга: Уучлаарай. Төхөөрөмжтэйгөө ажиллаж чадсангүй. Энэ саналыг дахиж санал хураалгаж өгөөч ээ.

Д.Цогтбаатар: Горимын санал. Санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

56.3 хувиар санал дэмжигдлээ. Түрүүний уншиж танилцуулсан горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг дахиад явуулъя.

Санал хураалт.

56.3 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа танилцуулна аа.

21.08 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Арав.Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсэгт заасны дагуу боловсруулсан талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал хийнэ ээ.

Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурал 2026 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн чуулганаар нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд болон гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхэд эрх дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих зарчмын дагуу хүүхэд хамгааллын удирдлага зохион байгуулалтад Улсын дээд Шүүх Нийслэл дэх гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатын шүүх Нийслэл дэх гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх болон Эрүү, иргэний анхан болон давж заалдах шатын шүүхийг нэмэхээр Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Мөн Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн ЭХХШТХ-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч гэсэн нэр томьёог өсвөр насны хүн гэж өөрчлөхтэй холбогдуулан Хүүхэд хамгааллын тухай хуулийн холбогдох заалтыг нийцүүлж өөрчлөх өөрчлөлтийг тусгасан болно оо.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Баасанжаргал гишүүнд баярлалаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

1 дүгээр зүйл. Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Алга байна.

Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

2 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Алга байна.

Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

3 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Алга байна.

Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй тул хуулийн төслийн анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргаж байна аа. Саналыг дэмжиж өгөхийг хүсье.

Манайхан санал хураалтдаа бэлдээрэй.

Саяын горимын саналыг дэмжье гэж санал хураалт явуулъя.

Санал хураалт.

56.3 хувиар санал дэмжигдлээ

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг танилцуулна аа.

21.09 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Арван нэг.Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлгийг явуулъя аа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

1 дүгээр зүйл. Энэ хуультай холбогдуулан юу бэлтгэл ажлыг хангасан тухай танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал танилцуулна аа. Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 3Г-аас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурал 2026 оны 6 сарын 18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэгт шүүх холбогдох нэхэмжлэлийг хариуцагчид хүргүүлсэн боловч тухай хаягт оршин суудаг оршин суудаггүй оршин суудаггүй Цагдаагийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан эрэн сурвалжлагдаж байгаа хүний талаарх мэдээллийн сүлжээ сангаар дамжуулан хариуцагчийг эрэн сурвалжлах арга хэмжээ авхуулахаар заасан.

Иймд дээрх зохицуулалтын хүрээнд цагдаагийн байгууллага хүүхдийн эрх дээд ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хариуцагчийг эрэн сурвалжлах

ажиллагааг дараалал харгалзахгүй шуурхай эхлүүлж 30 хоногийн дотор гүйцэтгэх зохицуулалтыг нэмэхээр Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Түүнчлэн Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн ЭХХШТХ-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн өсвөрийн тухай хуулийн төслийн өсвөр насны хүнд холбогдох хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах нийтлэг шаардлага гэсэн 18.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт, өсвөр насны хүний эрх, эрх, дээд ашиг сонирхол, түүнд учирч болох бусад хор уршгийг харгалзан ял шийтгэлийн талаарх лавлагаа мэдээллийг хуульд тусгайлан заасан үндэслэл журмаас гадуур задруулахгүй байх нөхцөлийг шүүх, прокурор, мөрдөн шалгах байгууллага, хуулиар үүрэг хүлээсэн бусад этгээд хангаж ажиллана гэж заасны дагуу өсвөр насны хүний ял шийтгүүлсэн, ял хойшлуулсан, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөн, өршөөл уучлалд хамрагдсан талаарх лавлагааг ЭХХШТХ-д тусгайлан заасан үндэслэл журмаас гадуур өөрт нь болон бусад хүн хуулийн этгээдэд олгохгүй байх. Төрийн цахим мэдээллийн нэгдсэн санд харагдахгүй байх технологийн боломжийг цагдаагийн байгууллага хариуцахаар 61 дүгээр зүйлийн 61.11-ээс 61.13 дахь хэсгийг нэмэхээр хуулийн төсөлд тусгасан болно оо.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Баасанжаргал гишүүнд баярлалаа.

Ингээд хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

1 дүгээр зүйл. Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

2 дугаар зүйл. Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

3 дугаар зүйл. Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү?

3 дугаар зүйл гэж байхгүй юм байна.

Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй тул хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргаж байна.

Саналыг дэмжиж өгөхийг хүсье. Манайхан санал хураалтдаа бэлдээрэй.

Саяын гаргасан горимын саналыг дэмжье гэж санал хураалт явуулъя.

Санал хураалт.

56.3 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг танилцуулна аа.

20.13 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Арван хоёр. Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн ажлын хэсгийн ахлагч, Баасанжаргал танилцуулна аа. Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 3Г-аас 2025 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүний эрх эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурал 2026 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан дарлагчаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42-ын 2.1-д заасны дагуу зарчмын зөрүүтэй нэг санал дээр гүйцээн боловсруулах чиглэл өгсөн тул Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх уг зарчмын зөрүүтэй саналыг гүйцээн боловсрууллаа.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг та бүхэнд хүргүүлсэн болно оо.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүл хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхээс өгөхийг та бүхнээсээ хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Баасанжаргал гишүүнд баярлалаа. Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Эцсийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан гишүүд асуулт асууж хариулт авах гишүүд байхгүй байна.

Нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг гүйцээн боловсруулж хуулийн төслийг холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Улсын Их Хурлын даргаас чиглэл өгсний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтад заасны дагуу хураалгах 1 зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулъя.

Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарчмын зөрүүтэй саналын томьёолол

Нэг. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгах санал.

Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 6 дугаар зүйлийн 6.5.10 дахь заалтыг хэвээр үлдээх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал, Нарантуяа, Номинчимэг, Сайнзориг, Тэмүүжин, Уянгахишиг Цаашид ажлын хэсэг гэнэ.

Саяын уншиж танилцуулсан томьёоллоор санал хураалтдаа бэлдэх үү? Манайхан санал хураалтдаа бэлдье. Саяын уншиж танилцуулсан саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

56.3 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал танилцуулна аа.

20.15 цаг

Дараагийн асуудалдаа орёё

Арван гурав.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 37 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

ХЭҮК-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Эцсийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан гишүүд асуулт асууж хариулт авах боломжийг олголоо. Байхгүй байна.

Хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Нарантуяа-Нара танилцуулна аа.

20.17 цаг

Дараагийн асуудалдаа орёё

Арван дөрөв.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

Монгол. Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд гүйцэтгэл ЗГ-ын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлэг санал, дүгнэлт ээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ ээ.

2025 оны төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх танилцуулгыг Сандаг-Очир сайд танилцуулна. Сандаг-Очир сайдын микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, ЗГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн боловсруулж Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын чуулганы 6 дугаар сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэгт танилцуулсан билээ.

Нэгдсэн төсвийн 2025 оны гүйцэтгэлээр тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 30 их наяд 303.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 33.7 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 31 их наяд буюу 31 их наяд 331 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 34.8 хувьд тус тус хүрч нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 27.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь ДНБ нь 1.1 хувьтай тэнцэж байна аа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл 3Г-ын санхүүгийн нэгтгэсэн тайлан тус Байнгын хороонд харьяалагдах АТГ, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, УЕП, ХЭҮК-ын дарга, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын дарга, ШЕЗ-ийн дарга, Шүүхийн сахилгын хорооны дарга, ХЗДХ-ийн сайдын багцын 283 төсөвт байгууллага, 4 төсөл, сан, төрийн өмчийн 10 ААН нийтдээ 297 байгууллагын төсвийн гүйцэтгэл санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан болно оо.

Тайлан тоот тус Байнгын хорооны 8 төсвийн ерөнхийлөн захирагчдын тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2 их наяд 46.7 тэрбум төгрөгт хүрч 95.1 хувийн биелэлттэй.

Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2 их наяд 19.9 тэрбум төгрөг буюу 94.8 хувийн гүйцэтгэлтэй гарлаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд тус Байнгын хороонд харьяалагдах 7 төсвийн ерөнхийлөн захирагчийн 37 төсөл арга хэмжээнд 177.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, гүйцэтгэл 96.1 хувийн биелэлттэй байна аа.

Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Та бүхэн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан танилцуулга, аудитын дүгнэлтүүдтэй танилцаж төсвийн тухай хуулийн дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж өгнө үү.

Д.Цогтбаатар: Сандаг-Очир сайдад баярлалаа.

2025 оны төсвийн гүйцэтгэл, 3Г-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг дүгнэлтийг Монгол Улсын ерөнхий аудитор Магнайсүрэн дарга байна уу? Аудитын газрын орлогч дарга Цэдэнжав Танилцуулна аа.

Индэр дээрээс та танилцуулчих.

3.Цэдэнжав: Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай хууль болон Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус байнгын хорооны харьяалах 8 төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын талаар тоймлон танилцуулъя аа.

1.ХЗДХ-ийн сайд Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгдсэн тайланд харьяа 235 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 141 байгууллагад дүгнэлт гаргаж, 94 байгууллагыг түүвэрт хамруулсан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт, харьяа 135 байгууллагад өөрчлөлтгүй, 6 байгууллагад хязгаартай дүгнэлтийг өгсөн.

Аудитаар нийт 12.9 тэрбум төгрөгийн 335 санхүүгийн зөрчил илэрснээс 0.2 тэрбум төгрөгийн 30 төлбөрийн акт тогтоож 5.9 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 104 албан шаардлага хүргүүлсэн. 6.5 тэрбум төгрөгийн 195 зөвлөмж 0.3 тэрбум төгрөгийн зөрчилд 4 албан хаагчид хариуцлага тооцуулах 5 албан шаардлагыг хүргүүлж ажиллалаа.

ХЗДХ-ийн сайдын төсвийн багцад Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 96 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 96 төсөл арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөснөөс 90.9 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 94 төсөл арга хэмжээ буюу 97.9 хувийн гүйцэтгэлтэй бүрэн хэрэгжжээ.

Өмнөх оны аудитаар нийт 2.4 тэрбум төгрөгийг 7 зөрчил илрүүлснээс 1.3 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах, 2 хариуцлага тооцуулахаар нэг албан шаардлага хүргүүлж 1.4 тэрбум төгрөгийн 4 зөвлөмжийн биелэлт 91.6 хувьтай байна.

2.ШЕЗ-ийн дарга.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 төгрөгийн санхүүгийн нэгдсэн тайланд харьяа 42 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 25 байгууллагад дүгнэлт гаргаж 17 байгууллагыг түүвэрт хамруулсан.

Тус тайлангаар төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаар өөрчлөлтгүй дүгнэлт харьяа 24 байгууллагад өөрчлөлтгүй, 1 байгууллагад хязгаартай дүгнэлтийг өгсөн.

Аудитаар нийт 939.6 сая төгрөгийн 47 зөрчил илэрснээс 12.6 сая төгрөгийн зөрчил, 7 төлбөрийн акт тогтоож 574.6 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 19 албан шаардлага хүргүүлж, 352.4 сая төгрөгийн зөрчилд 21 зөвлөмж өгч ажиллалаа.

ШЕЗ-ийн даргын төсвийн багцад Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 6 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 3 төсөл арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн нь бүрэн хэрэгжсэн.

Өмнөх аудитаар нийслэлийн асуудлаар нэг зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

3.Монгол Улсын Ерөнхий прокурор

2025 оны санхүүгийн нэгдсэн тайланд харьяа 44 байгууллагын санхүүгийн тайлан нэгдсэнээс 26 байгууллагад дүгнэлт гаргаж, 18 байгууллагыг түүвэрт хамруулсан.

Ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайлан болон харьяа байгууллагад өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 142.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс 0.6 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож 3.2 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох, 2 албан шаардлага хүргүүлж, 136.8 сая төгрөгийн зөрчилд 34 зөвлөмж өгсөн болно оо.

Монгол УЕП-ын төсвийн багцад Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 7.8 тэрбум төгрөгийн гэрээний үнэтэй 6 төсөл арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь бүрэн хэрэгжсэн. Өмнөх оны аудитаар нийт 335 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар 5 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажиллажээ.

4.Шүүхийн шүүхийн сахилгын хорооны дарга.

Тус төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн. Аудитаар нийт 52.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1 сая төгрөгийн зөрчилд нэг төлбөрийн акт тогтоосон. 33.2 сая төгрөгийг таслан зогсоох 2 албан шаардлага хүргүүлж, 18.2 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

Шүүхийн сахилгын хорооны даргын төсвийн багцад Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 0.3 тэрбум төгрөгийн гэрээний үнэтэй 2 төсөл арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж бүрэн хэрэгжүүлсэн.

Өмнөх актаар өмнөх оны аудитаар 10.2 сая төгрөгийн санхүүгийн асуудлаар 3 зөвлөмж, нийцлийн асуудлаар 5 зөвлөмж, 1 хариуцлага тооцох албан шаардлага өгсөн нь биелэлт 97.3 хувьтай байна.

5.ХЭҮК-ын дарга.

Тус төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн тайланд хязгаарлалттай дүгнэлт өгсөн. Аудитаар 676.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 3.7 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоосон, 343.7 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 2 албан шаардлага хүргүүлж, 329.4 сая төгрөгийн зөрчилд нэг зөвлөмж өгсөн.

ХЭҮК-ын даргын төсвийн багцын Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2.3 тэрбум төгрөгийн 2 төсөл арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлэхээр бүрэн хэрэгжүүлж ажилласан.

6.Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын дарга тус төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн тайланд хязгаарлалттай дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 44.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 39.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлагыг хүргүүлж, 5.1 сая төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгсөн.

Өмнөх оны аудитаар 4.2 тэр тэрбум төгрөгийн 9 зөрчил илрүүлснээс 4.1 тэрбум төгрөгийн 6 албан шаардлага, 91.9 сая төгрөгийн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

7.Монгол Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгч.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгдсэн тайланд харьяа 2 байгууллагын санхүүгийн тайлан нэгдсэнээс өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар 168.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1.5 сая төгрөгийн зөрчилд нэг төлбөрийн акт тогтоож, 35 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 2 албан шаардлагыг хүргүүлж 131.3 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгч ажилласан.

2025 онд Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн төсвийн багцад Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3.5 тэрбум төгрөгийн 9 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр ажиллаж бүрэн хэрэгжсэн байна аа.

Өмнөх оны аудитаар өгсөн нэг зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, зөрчил өмнөх оноос өссөн тул тайлант хугацаанд санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

8.Авлигатай тэмцэх газар.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны нэгдсэн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар 25.3 сая төгрөгийн зөрчил илэрч зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 2 зөвлөмж өгсөн.

АТГ-ын төсвийн багцад 2025 онд 2.3 тэрбум төгрөгийн 4 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж бүрэн хэрэгжүүлж ажилласан байна аа.

Өмнөх аудитаар 7.1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажиллажээ.

Дээрх төсвийн ерөнхийлөн захирагчдын аудитын тайлангийн дүн дүгнэлтээс үндсэнд дараах асуудалд анхаарал хандуулах шаардлагатай гэж үзлээ.

Үүнд.

Нэгдүгээрт, төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн төслийн саналыг боловсруулахдаа Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцүүлж тухайн жилд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт түүнд зарцуулах төсвийг үнэн зөв бодитой төлөвлөж тайлагнах.

2.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, бүртгэх, үр дүнг үнэлэх үе шат бүрд төсвийн ерөнхийлөн захирагч болон оролцогч байгууллага, албан тушаалтнуудын хяналт, хариуцлагыг сайжруулах.

3.Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн байдлын тайлан болон бусад эргэлтийн хөрөнгө дансанд хөрөнгө оруулалтын дүнд бий болсон болон ашиглалтад орсон хөрөнгийг ашиглагч байгууллага гэж шилжүүлээгүй, ажлын гүйцэтгэл, санхүүжилтийг үе шат

бүрээр бүртгээгүй зэрэг зөрчил илэрч байгаад дүн шинжилгээ хийж эрх бүхий төрийн байгууллагуудад асуудлыг тавьж шийдвэрлүүлэх талаар үүрэг чиглэл өгөх.

4.ХЗДХ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж шилжилт хөдөлгөөнд хяналт тавих.

5.Төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн аудитын шийдвэрийн хэрэгжилтэд анхаарч, аудитын шийдвэрийн хууль, тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгаа дүн шинжилгээ хийж цаашид гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж төсөв санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх талаар холбогдох байгууллагад чиглэл өгч төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3 дахь заалтын хэрэгжилтийг бүрэн хангуулж дотоод хяналтын тогтолцоогоо сайжруулах шаардлагатай байна аа.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Цэдэнжав даргад баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

ШЕЗ-өөс Золзаяа Шүүхийн ерөнхий зөв зөвлөлийн дарга, Эрдэнэтулга ШЕЗ-ийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Наранбилиг ШЕЗ-ийн Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга, Улсын дээд шүүхээс Заяадэлгэр Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга, Эрдэнэчимэг Шүүхийн сургалт, судалгаа мэдээллийн академийн захирал, Сүглэгмаа Улсын дээд шүүхийн ахлах нягтлан бодогч, Шүүхийн сахилгын хорооноос Энхтөр Шүүхийн сахилгын хорооны дарга, Мөнхзориг Шүүхийн сахилгын хорооны ажлын албаны дарга, Ариунжаргал Шүүхийн сахилгын хорооны ерөнхий нягтлан бодогч, ХЭҮК-оос Сүнжид ХЭҮК-ын дарга, Ихтамир ХЭҮК-ын Тамгын газрын даргын албан үүргийг албан түр орлон гүйцэтгэгч, Захиргаа удирдлагын хэлтсийн дарга Б.Бадамсэрээжид ХЭҮК-ын Санхүү хөрөнгө оруулалтын тасгийн дарга, ерөнхий нягтлан бодогч, УЕПГ-аас Чулуунбат УЕП-ын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга, АТГ Баасанням АТГ-ын Тамгын хэлтсийн дарга, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссоос Цасчихэр Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын нарийн бичгийн дарга, Очирсүрэн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын ажлын албаны дарга, ХЗДХЯ-аас Батбямба ХЗДХЯ-ны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Отгонбаяр ХЗДХЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга, Хатантуул ХЗДХЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын газрын ахлах шинжээч, Б.Болормаа ХЗДХЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын газрын ахлах шинжээч, ЦЕГ-аас Батчулуун ЦЕГ-ын Санхүү, ар талын албаны дарга цагдаагийн хурандаа, Ралдыжамц ЦЕГ-ын Санхүү, ар талын албаны Санхүүгийн хэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогч, цагдаагийн хошууч, Хил хамгаалах газраас Бямбасүрэн ХХЕГ-ын дарга, Хилийн цэргийн командлагч, хошууч генерал, Чойжилсүрэн ХХЕГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, ерөнхий нягтлан бодогч хурандаа, Ариунаа ХХЕГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын төсөв төлөвлөлтийн ахлах офицер, дэд хурандаа, ШШГЕГ-аас Намсаманд ШШГЕГ-ын дарга, хурандаа Намсаманд, Өнөртуяа ШШГЕГ-ын Санхүү, үйлдвэр хөрөнгө оруулалтын газрын дарга, Энх-Од ШШГЕГ-ын Эдийн засаг төлөвлөлтийн хэлтсийн дарга хошууч, Давааням УБЕГ-ын дарга УБЕГ-ын Санхүү, үйлчилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон

гүйцэтгэгч Энхнаран, Шүүх шинжилгээний ерөнхий газраас Алтансүх Шүүх шинжилгээний ерөнхий газрын Санхүү хангамжийн газрын дарга, цагдаагийн хурандаа, Батцэцэг Шүүх шинжилгээний ерөнхий газрын Санхүү төлөвлөлтийн хангамжийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч, цагдаагийн дэслэгч, Гадаадын хэргийн харьяатын газраас Энхсүх Гадаадын хэргийн харьяатын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Солонгоо ГИХГ-ын Санхүү хангалтын үйлчилгээний газрын дарга, Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс Жамъянхүү Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Уранчимэг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Захиргаа удирдлагын хэлтсийн ахлах нягтлан бодогч, Архивын ерөнхий газраас Нямгэрэл АЕГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Цэндсүрэн Архивын ерөнхий газрын Мэргэжил арга зүйн удирдлагын газрын дарга, Лхагвасүрэн АЕГ-ын Санхүү аж ахуйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Мэдээлэл шуурхай удирдлагын төв Ганзориг, Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн дарга, цагдаагийн хурандаа, Уянгаа Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн Захиргаа удирдлагын газрын Санхүү ар талын тасгийн дарга, цагдаагийн хошууч, Цагдаагийн хошууч, Дотоод хэргийн их сургуулиас Сүхболд Дотоод хэргийн их сургуулийн захирал, бригадын генерал Гантулга, Дотоод хэргийн их сургуулийн Санхүү төлөвлөлтийн хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа, Баярсайхан Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн төлөвлөлт үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал, дэд хурандаа, Мөнхбаяр Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн Санхүү хангамжийн албаны дарга, ахмад, Хууль зүйн туслалцааны төв Уянга, Хууль зүйн туслалцааны төвийн дарга, Болор-Эрдэнэ Хууль зүйн туслалцааны төвийн ахлах нягтлан бодогч, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Энхбаяр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Гангэрэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Үндэсний аудитын газраас Цэдэнжав Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч, Цэвэлмаа Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Баттуяа Нийцлийн аудитын газрын захирал тэргүүлэх аудитор, Баярсайхан Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Цэвэгдорж Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн захирал, тэргүүлэх аудитор, Долгорсүрэн Санхүүгийн аудитын газрын аудитын менежер, Нацагдорж Санхүүгийн аудитын газрын аудитын менежер, Цэгмиддорж Тусгай чиг үүргийн аудитын газрын менежер, Энхдалай Санхүүгийн аудитын газрын аудитын менежер, Оюунхүү Гүйцэтгэлийн аудитын газрын ахлах аудитор, Сангийн яамнаас Хулан Сангийн дэд сайд. Сангийн дэд сайд нь байна уу? Тэнд байж байгаа юу? Ер нь энд ингээд дурдагдсан хүмүүс байх ёстой шүү. Анар Сангийн яамны ТНБД, Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Хуягцогт Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга, Тулга Сангийн яамны Санхүү бодлогын газрын дарга, Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Мөнхсүх Сангийн яамны Төрийн сангийн газрын санхүүжилт тайлан бүртгэлийн хэлтсийн дарга, Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Ганзориг Сангийн яамны хөгжлийн санхүүжилт хөрөнгө оруулалтын газрын хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Бат-Эрдэнэ Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Баяр-Эрдэнэ Сангийн яамны Төрийн сангийн газрын санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Алтанхорол Сангийн яамны Төрийн сангийн газрын санхүүжилт тайлан бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн гэсэн ийм хүмүүс ажлын хэсэгт оролцоод энэ хуралд сууж байна аа.

Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Төсвийн Ерөнхийлөн захирагч нараас төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгдсэн тайлантай холбогдуулан

асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Нара гишүүнээр тасаллаа. Даваагийн Цогтбаатар гишүүнээр тасаллаа. Нара гишүүний микрофоныг өгье.

М.Нарантуяа-Нара: Оройн мэнд хүргэе. Одоо 9 цаг 36 минут болж байна. Тэгээд Байнгын хорооны даргаа би нэг ийм санал тавимаар байна аа.

Одоо манай ХЗБХ 28 гишүүнтэй. Тэгээд энэ энэ оройн цагаар манай энэ бүх яамдуудын энэ мэргэжлийнхэн бүгдээрээ ингээд орой болтол хүлээгээд сууж байгаад хүндэтгэлтэй байна.

Гэхдээ бүхэл бүтэн 2025 оны төсвийн гүйцэтгэл хэлэлцээд сууж байхад манай Байнгын хороо зургаахан гишүүнтэй энэ асуудлыг ингэж хэлэлцэхгүй ээ. Татвар төлөгчдийн мөнгийг хэрхэн яаж захиран зарцуулсан юм, хэдэн хувьтай хэрэгжүүлсэн юм. Энэ дээр бид нар дор бүрнээ судалсан асуудлаа гишүүн тус бүр тавих ёстой ийм байдлаар энэ бид нар ямар зүгээр хуулийн ангийн оюутнууд тоглоод байгаа биш дээ. Энэ асуудлыг дараагийн хурлаар хэлэлцэх ийм санал гаргаж байна.

Д.Цогтбаатар: Энэ чинь Нара гишүүн ийм учиртай юм байгаа юм. Гишүүд бүгдээрээ энэ дээр асуудлуудтайгаа танилцуулаад бид нар 2 дахь хэлэлцүүлэг дээрээ явж байна шүү дээ. Тэгээд энэ асуудлуудтайгаа танилчихсан. Өнөөдөр бол энэ дээр санал хурааж бид нар батлах юу байхгүй байгаа байхгүй юу. Тийм учраас л бид нартай гишүүд яагаад гэвэл гишүүд бүгдээрээ өөрсдөө энэ асуудлуудтайгаа танилчихсан байгаа. Яаж энэ төсвийн хэлэлцүүлэг явдаг вэ гэхлээр энэ бүх гишүүд аль хэдийн энд сууж байгаа хүмүүс аль хэдийн өөр өөрийнхөө сувгаар бүх гишүүдтэй очоод өчнөөн юмнуудаа ярьчихсан байж байгаа. Та өөрөө тэрийг мэднэ шүү дээ. Тан дээр ч аягүй бол хүмүүс орж ирээд асуудлуудаа яриад энэн дээр дэмжиж өгөөрэй гээд л яриад явж байгаа.

Тэгэхээр тэр утгаараа яах вэ манай гишүүд түрүүн бүгдээрээ сууж байгаад л 2 хууль хэдүүлээ гаргалаа шүү дээ. Гэхдээ таны хэлж байгааг би хүлээж авч байна. Гишүүддээ бас би хандаж энэ Байнгын хорооны гишүүддээ ийм асуудал дээрээ хүндэтгэлтэй хандаарай. Ялангуяа би өнөөдөр сая ажлын хэсгийн гишүүдийг ийм олон хүнийг би бүгдийг нь уншиж байгаа нь энэ орой болтол энэ хүмүүс суулаа шүү гэдгийг улс орон даяар хэлж өгч байгаа юм аа. Зөв зөв таны хэлж байгаа зөв шүү.

Би бас гишүүддээ энийг уламжилъя аа.

Цогтбаатар гишүүний микрофоныг өгье.

Да.Цогтбаатар: Та бүхэнд оройн мэнд хүргэе. Алийн болгон шүүмжлэх вэ дээ. Энэ хууль зүйн салбар харьцангуй миний ойлгосноор зөрчилтэй, хязгаарлалттай, дүгнэлт харьцангуй бага гаргасан салбар гэж ойлгож байгаа. Тэгэхдээ энэ ХЭҮК Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комисс 2 дээр хязгаарлалттай дүгнэлт авчихсан талаараа нэг яагаад энэ талаар ийм хязгаарлалттай дүгнэлт авчхаж байгаа талаараа нэг дэлгэрэнгүй мэдээлэл өгөөч гэж байгаа юм.

Хоёрт энэ Байнгын хорооны дарга сая хэлсэн энэчээ нэр дурдагдаад байгаа яг энэ хууль зүйн салбарын харьяа агентлаг газрын дарга нар нь бүгд байх ёстой гээд. Яах вэ бүгд байгаа юм шиг байна. Зарим нь бол алга байна. Дарга анхаарах

юм уу? Жишээлэх юм бол нөгөө ГИХГ-ын дарга гэж ирээгүй байна. Өө уучлаарай. Тэгээд энэ ирсэн бол нөгөө мэдээллүүдийг чинь нөгөө дэлгэрэнгүй мэдэх гээд байгаа учраас одоо жишээлэхэд ГИХГ-ын дарга бол шинээр томилогдох шиг болсон. Тэгээд яг энэ өнгөрсөн хугацааныхаа алдаа дутагдалтай яг ингээд гүйцэд танилцаж амжсан эсэхийг нь би мэдэхгүй байна. Тэгээд амжсан бол юун дээрээ анхаарч ажиллах тиймэрхүү төлөвлөгөө өгөх юм уу байгаа талаараа мэдээлэл өгөөч гэж байгаа юм.

Д.Цогтбаатар: Холбогдох сая асуултад гарсан байгууллагууд хариултаа хэлье. Индэр дээр гарч яахгүй бол та нарын микрофон яахгүй. Индэрийн микрофоныг өгье. Өөрийгөө танилцуулаад тэгээд хариултаа өгөөрэй.

Б.Бадамсэрээжид: ХЭҮК-ын Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Бадамсэрээжид Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. 2025 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай дүгнэлт авсан. Үүн дээр 214 сая төгрөгийн авлага үүсгэсэн, 328 сая төгрөгийн өглөг үүсгэсэн ийм асуудал байгаад байгаа юм. Авлага дээр болохоор Ахмадын сан болон нэмэлт санхүүжилтийн дансыг Сангийн яам жилийн эцэст төрийн сандаа төвлөрүүлээд энийг манайх авлагаар бүртгэхэд Аудитын газраас авлага үүсгэсэн байна гэдэг ингээд зөрчилд тооцоод ингээд явчихсан байгаа. 328 сая төгрөгийн өглөг дээр манайх төсвийн гүйцэтгэлээрээ 94 хувийн гүйцэтгэлээ гарсан санхүүжилтийн гүйцэтгэл 702 сая төгрөгийн санхүүжилтийг авч чадаагүй байгаа.

Тэгээд ерөнхийдөө санхүүжилтийн 50 хувиар авч чадаагүй санхүүжилтийн 50 хувиар ингээд өглөг үүсгэчихсэн ийм асуудал байгаад байгаа юм. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Дараагийн байгууллага нь Аудитын газар Цэдэнжав дарга байсан уу? Сая хариулахад. Цагаатгах комиссоос. Өөрийгөө танилцуулаарай. Ажлын хэсгийн гишүүн.

Ч.Цасчихэр: Та бүхэнд энэ оройн мэнд хүргэе.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын нарийн бичгийн дарга Цасчихэр байна.

Манайх 2 асуудал дээр хязгаарлалттай дүгнэлт авсан. Нэг нь үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 15.1 сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг ТӨБЗГ авч тавьж ингэж шийдвэрлэх арга хэмжээг аваагүй. Энийг одоо тухайн үеийн нэг нөхцөл байдалтай уялдаад манай санхүүгийн буруутай үйл ажиллагаа болсон гэж бид нар хүлээн зөвшөөрч энэ асуудлыг тавиад тооллого тооцоогоо эхлээд асуудлаа шийдвэрлүүлэх гээд явж байгаа.

Нөгөө нэг асуудал нь болохоор анхан шатны баримтын бүрдэл дутуутай 10.5 сая төгрөгийн үйлчилгээний зардалд зарцуулсан ийм зөрчил гарсан. Энэ 2 дүгнэлтийг бид нар анхаарч цаашид тийм асуудал гаргахгүй гэдэг.

Д.Цогтбаатар: Аудитын газраас хариулах уу? Харьяатын газрын дарга.

Б.Энхсүх: Гадаад хэргийн харьяатын газрын хугацаа асуудлуудтай бүрэн танилцсан. Тэгээд Гадаад иргэн харьяатын газрын дунд үнэ цэнтэй зөрчилгүй дүгнэлт авсан. Тэгээд 13 асуудал дээр 77 сая төгрөгийн зөрчилтэй холбоотой 77 сая

төгрөгийн асуудлыг засаад явж байгаа. Цаашид энэ төрлийн зөрчлүүд гарахгүй чиглэлээр анхаарч ажиллана аа.

Д.Цогтбаатар: Сая тэгээд энэ Цогтбаатар гишүүний хэлж байгааг та нар анхаараарай. Гишүүд өнөөдөр ингээд 9 цаг 40 минут хүртэл суугаад энэ асуудлуудыг хэлэлцээд байгууллагуудыг хүндэтгээд ажиллаж байна шүү дээ. Тэгэхэд байгууллагын дарга нар та нар төсвөө ярих болохоороо өөрсдөө гүйж орж ирээд л ярьдаг. Тэгээд энэ асуудлаа ингээд хэлэлцэж байхад байгууллагын удирдлагууд орж ирнэ шүү. Ер нь Байнгын хороо холбогдох сайд нар нь орж ирээгүй байхад асуудлыг хэлэлцэхгүй шүү дээ. Сайд нартай л харьцана. Их Хурал сайд нартай л хариуцлага тооцно.

Тэгэхээр энэ холбогдох агентлаг байгууллагын газрын дарга нар бол Байнгын хорооны гишүүдэд хүндэтгэлтэй хандаж ирж суух ёстой шүү. Тэр ажилгүй завгүй гэх юм бол бид нар ч ажилгүй завтай хүн энд байхгүй шүү дээ. Тэгээд гишүүд сууж байгаад л хуралдаж байгаа. Тэгэхээр энийг бол та нар анхаарч үзээрэй.

Тэр Хууль зүйн сайд тэр Гадаад иргэдийн харьяатын байгууллагын.

Сая тэгээд дарга нь байхгүй байна гээд байсан чинь. Ааг за за. Сая дарга нь харин байхгүй байна гээд би тэгээд гайхаад байхгүй юу. Гэхдээ ямар ч байсан энэ дотор байхгүй байгаа дарга нарыг дурдсангүй. Байхгүй байгаа шүү Магнайсүрэн даргаас авхуулаад л тийм. Эдийн засгийн байнгын хороон дээр асуудлаа хэлэлцүүлж байгаа юу. Би гарцыг чинь гаргаж өмнөөс чинь хариулаад өглөө. Гэхдээ агентлагийн дарга нар байх ёстой шүү.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Цогтбаатар гишүүн, Баасанжаргал гишүүнээр тасаллаа. Цогтбаатар гишүүний микрофоныг өгье.

Да.Цогтбаатар: Өнөөдөр энэ төсвийн гүйцэтгэлтэй холбоотой Сангийн яам аудит, тэгээд сайд нар бол нэлээн ачаалалтай ажиллаж байгаа энийг ойлгож байгаа. Миний анзаарч байгаагаар сая Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо, одоо ингээд Хууль зүйн байнгын хороо гээд давхардсан Байнгын хороонуудаар аль болох ингээд хүртээмжээрээ яваад ажиллаад байна. Энийг ойлгож байна аа. Тэгээд энэ төсвийн ерөнхийлөн захирагч нартай холбоотой асуудлууд маш их гарч байгаа. Аудитын дүгнэлт дээр яг ингээд дэлгэрэнгүй явна гэвэл маш олон асуудал байгаа. Яг ингээд би нөгөө уг нь дэлгэрэнгүйгээр нь аудитаас бүүр материал авчихсан. Энийг Зарлагын хяналтын дэд хороон дээр дахиж нэг бүрчлэн ярилцана гэж бодож байгаа. Ер нь бол Хууль зүйн байнгын хорооны дарга ер нь Улсын Их Хурлын даргад ч гэсэн хандаж хэлэхэд бид нар төсөв батлахдаа 2 сар хэлэлцдэг, 5 үе шатаар ярьдаг. Энд сууж байгаа дарга нар бүгдээрээ манай тэр зардал тийм ач холбогдолтой учраас бид нар заавал авах ёстой гээд л бараг гишүүн болгоны өрөөний үүдийг сахиад явдаг. Тэгээд тэр тусмаа ХЗБХ-н дээр хуулиараа олгогдсон хуулиараа өгөх ёстой гэж ярьж байгаад л бүх төсвийг нь аль болох шийдэх гэж хичээдэг. Гүйцэтгэлийг нь ярих гэхээр нөгөө зарим дарга нар чинь ингээд байхгүй байгааг анхаарах ёстой байх. Энэ дээр юу гэдэг юм анхааруулаад ингээд илж таалаад л яваад байх шиг байгаа юм.

Би одоо 2 жил анзаарч байгаа юм. Энэ Улсын Их Хурал нь Улсын Их Хурал шиг Байнгын хороо нь яг Байнгын хороо шиг Улсын Их Хурал дээр энэ хууль

хэрэгжиж чадахгүй юм бол бусад газар хэрэгжинэ гэдэг ойлголт үнэхээр бүрхэг. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн гээд Улсын Их Хурлын нь дарга ч уншиж байна, Байнгын хорооны дарга нар ч уншиж байна. Сангийн яам, аудит, сайд нарыг ойлгож байна. Бусдыг нь бол ойлгоно гэхэд үнэхээр хүндрэлтэй. Томилогдоод ажил авахдаа эсвэл төсөв батлуулж авахдаа уургын морь шиг авдаг.

Буцаад тайлагналаа яриад, гүйцэтгэлээ яриад, жаргал зовлонгоо ярья гэхээр ургаа хад шиг бүгдээрээ зарим нь алга болчихдог. Тэгэхээр энэ асуудал дээрээ маш сайн анхаарч явж байхгүй бол Улсын төсвөөр 34 их наяд төгрөг баталж өгч байгаа. Төрийн өмчит ААН-үүд дээр яг балансын бүртгэлээрээ бол 133 их наяд төгрөг байна. Энийг ингээд зах зээлийнх нь үнэлгээгээр тооцох юм бол бүүр энэнээс илүү их дүн гарна. Тэгэхээр энэ дээрээ бүгдээрээ хаа хаанаа анхааралтай, хариуцлагатай ажиллаарай л гэдгийг дахиж хэлэх гэсэн юм.

Д.Цогтбаатар: Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Би нэг товчхон санал хэлэх гээд байна. Дараа нь би байгууллагуудаас бичгээр авъя гэж бодоод хэлчихье. Бид нарт энэ нөгөө тайлан баланс гээд бүх дэлгэрэнгүй мэдээлэл 6 сарын 17-ны өдөр ирсэн. Яг үнэндээ бүх байгууллагуудын тайлан баланстай бид нар бол айхтар тэгж дэлгэрэнгүй танилцах шаардлагагүй гэж бодож байгаа.

Харин эсрэгээрээ бид нар энэ байгууллагуудын үр дүн нь өөрөө энэ зарцуулсан санхүүтэйгээ яаж уялдаж байгаа юм бэ гэдэг мэдээлэл бид нарт хамгийн чухал байх ёстой. Тэрнээс биш бензин тэдэн төгрөг зарцуулсан тэдэн төгрөгийн цалин гэдэг бол яг бид нарт ямар ч нэг их айхтар тийм ач холбогдолтой биш байхгүй юу. Тэгээд цаас ч дэмий үрээд цаг ч дэмий үрээд байх юм хэдүүлээ.

Тэгэхээр байгууллагууд яах вэ бид нарт энэ юм мэдээлэл дотор энэ үр дүнтэй уялдуулаад 1, 1 ийм хүснэгтэд ганцхан ганцхан өгүүлбэрээр тайлбар ирчихсэн л байна л даа. Тэгээд манай Үндэсний аудитын газар ч гэсэндээ цаашдаа анхаараад өгөөрэй. Ялангуяа манай энэ ХЗБХ-ныхон энэ жилийн төсвийн гүйцэтгэлийг үнэлэх гүйцэтгэлийнхээ шалгуур үзүүлэлтийг бүх байгууллагууд өөрчилсөн шинэчилсэн. Бүгдээрээ санаж байгаа тиймээ. Бөөн юм болж байж бүгдээрээ шинэчилцгээсэн, өөрчилсөн.

Тэгэхээр ирэх жил бол бид нар яг тэр гүйцэтгэлээрээ л яг мөнгийг хөөнө. Яг энэ үр дүн гарсан уу гарахад яг энэ мөнгө нь зарцуулагдсан уу л гэдгийг хөөмөөр байна гэсэн үг. Тэгэхээр яг 2026 оныхоо эхний гүйцэтгэлийг та бүхэн яг одоогийн байгаа гүйцэтгэлийнхээ шалгуур үзүүлэлтэд уялдуулаад байгууллага болгон яг үр дүнтэйгээ танай төсөв яаж уялдсан юм гэдэг нэг товчхон мэдээллүүд байх юм уу. Уг нь энэ нэг их айхтар дэлгэрэнгүй мэдээлэл байх шаардлагагүй юм. Гэхдээ байгууллага болгон өөрийнхөө хэмжээнд бэлдээд манай ХЗБХ гишүүдэд хүргүүлээрэй гэдгийг хүсье. Тэгээд энийг чинь бид нар дараа нь 2027 оны төсвийг дахиад хэлэлцэхэд дээрээс нь төсөв батлахад яг энэ нөгөө гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд хэр оновчтой байв аа? Дахиад сайжруулах уу үгүй юу гэдгээ бид нар хармаар байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ зүйлүүд дээрээ манай байгууллагын удирдлагууд анхаараад өгөөрэй гэж хүссэн юм.

Д.Цогтбаатар: Ингэе. Сая гишүүд ингээд үг хэлж дууслаа. Сүнжид дарга орж ирж байна. Яг үнэн би түрүүн хэлсэн. Зарим байгууллагын удирдлагууд байхгүй байна гээд надаа энд бүртгэл авчраад өгч байна. Энд 4 байгууллага, одоо Сүнжид дарга ороод ирлээ.

Тийм учраас энд ингээд 4 байгууллага ирээгүй байна. Энэ удаа би нэр дурдаж хэлэхээ больё. Тэгэхдээ би тэр 4 байгууллагад өөрийнхөө Байнгын хороогоор дамжуулж та байсангүй шүү гэдгийг нь би мэдэгдэнэ. Сайдад нь бас хэлнэ гэсэн үг.

Тэгэхээр ер нь цаашдаа энэ нөгөө түрүүн хэлсэн юугаар нэгэнт төсвөө хэлэлцүүлж та нар батлуулдаг байж энэ дээр байж байх ёстой.

Хоёрт ер нь зүгээр Байнгын хорооны гишүүддээ ч гэсэн хэлэхэд бид нар энэ салбарын ингээд хариуцаад ажиллаж байгаа хүмүүсийн хувьд энэ салбарын ажиллаж байгаа хүмүүсээ дэмжиж ажиллах ёстой. Заримдаа ингээд төсвийг нь оруулаад ирэхлээр тэр Их Хурал дээр дараа нь нэгдсэн чуулган дээрээ очоод юм хаашаа эргэхийг бид хэлж мэдэхгүй. Гэхдээ манай Байнгын хороо салбараа хариуцаж байгаа Байнгын хорооны хувьд асуудлыг нь дэмжээд өгдөг байх хэрэгтэй. Тэгэхгүй бол асуудлыг нь үгүй үгүй энд тасалж өгөөд унагаагаад явж байсан түүх бий. Би өөрөө тэрийг бүүр хатуу гэрчилж мэдэж байгаа байхгүй юу.

Тэгээд нэгэнт уначихсан юм бол ороод босдоггүй. Би төсвийг нь баталж өгөхийн ач холбогдлыг хамгийн энгийн жишээгээр хэлье. Энэ шүүх дээр Заяадэлгэр дарга энд сууж байна. Сая энд тэгсэн нээрээ ахиад гарчхаж байгаа байхгүй юу. Тэгээд тэр 4 үзүүлэлтээс 3 нь манай Байнгын хороо шийдэж өгсөн тэрний нэг нь төсвийг нь бид нар үнэхээр хангалттай сайн шийдэж өгсөн байгаа. Ингэж байж тэр нөгөө шүүхийн хүрэлцээгүйгээсээ болж аягүй олон иргэдийн гомдол байнга ирж байдаг. Тэгээд энэ ачааллыг чинь бууруулж өгөхөд энэ бид нар шийдэж өгөөд маш олон асуудлыг нь төр өөрийнхөө зүгээс хийж өгөх юмаа хийж өгөхгүй байж шаардлага баахан тавиад байдаг байсан. Энийг хийх ёстой шүү гэж зүтгүүлсээр байгаад бид нар гаргаад энэ дээр нэмээд мэдээжийн хэрэг шүүхийнхэнтэй ярьж байгаад нөгөө шүүхийн, Дээд шүүхийн бүх хурал чинь лайв стрийм явж байгаа. Шүүхийн процессын ил тод байдлыг нь бид нар хангаж өгөөд ингээд хэд хэдэн асуудал шийдээд л өгөхөд сая нээлттэй нийгэм жишээ нь Америкийн ТББ шүү дээ. Эндээс тэр судалгаа хийгээд гаргаад ирэхэд манай шүүхийн үзүүлэлтүүд сайжраад гараад ирсэн байгаа юм.

Тэгэхээр энд байгаа бид нарын хийж байгаа үйл ажиллагаа чинь бодит амьдрал дээрээ үр дүн болж очиж байгаа. Тэрийгээ бид нар тал талаасаа дэмжээд тал талдаа хамтраад ажиллахад үр дүн гарна шүү. Тэгээд саяын тэр юунд үр дүнд айттар баярлах хэрэггүй. Ахиц гарсанд бид нар баяртай байна.

Түүнээс хийх ажил тэрнээс их хурд байгаа шүү. Шүүх бусад хууль, хяналтын бүх байгууллагуудад хандаад хэлэхэд энийгээ тал талдаа бодож ажиллая. Ингээд гишүүд үг хэлж дууслаа.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаар асуулт асууж үг хэлж дууслаа.

Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороон хороонд Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар танилцуулна.

21.54 цаг

Ингээд дараагийн асуудалдаа оръё.

Арван тав. “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

“Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье ээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд Шүүхийн сахилгын хорооны болон ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний албан тушаалын зэрэг зиндаа, цалин хөлс, нэмэгдлийн хэмжээг Улсын Их Хурал тогтооно гэж заасны дагуу Шүүхийн сахилгын хорооноос 2026 оны 6 дугаар сарын 3-ны өдөр ШЕЗ-өөс 2026 оны 6 дугаар сарын 5-ны өдрүүдэд ШЕЗ-ийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүний цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай саналыг Монгол Улсын Их Хуралд ирүүлсэн байна.

Улсын Их Хурлын тогтоолын төслийг гишүүдэд тараасан байгаа.

Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Тогтоолын төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй тул тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргаж байна аа.

Тэгье баярлаж байгаа, баярлаж байгаа гишүүддээ. Санал хураалтдаа манайхан бэлдсэн үү? Саяын горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

56.3 хувиар санал дэмжигдлээ.

“Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Баярмаа танилцуулна аа.

21.56 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Уг асуудлыг 21 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Арван зургаа. Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо болон Хүний эрхийн Үндэсний Комиссын 2027 оны төсвийн төслийн талаар хэлэлцэх

Улсын дээд шүүх, ШЕЗ, Шүүхийн сахилгын хороо болон ХЭҮК-ын 2027 оны төсвийн талаар хэлэлцэх асуудалдаа оръёо.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. ШЕЗ-ийн дарга Золзаяа, ШЕЗ-ийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Эрдэнэтулга, ШЕЗ-ийн Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга Наранбилиг. Энэ чинь зөв үү? Улсын дээд шүүхээс Заяадэлгэр Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга, Эрдэнэчимэг Шүүхийн Сургалт судалгаа, мэдээллийн академийн захирал, Сүглэгмаа Улсын дээд шүүхийн ахлах нягтлан бодогч, Шүүхийн сахилгын хорооноос Энхтөр Шүүхийн сахилгын хорооны дарга, Мөнхзориг Шүүхийн сахилгын хорооны ажлын албаны дарга, Ариунжаргал Шүүхийн сахилгын хорооны ерөнхий нягтлан бодогч, ХЭҮК-оос Сүнжид ХЭҮК-ын дарга, Үнэнтөгс ХЭҮК-ын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, Ихтамир ХЭҮК-ын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Захиргаа удирдлагын хэлтсийн дарга, Бадамсэрээжид ХЭҮК-ын Санхүү хөрөнгө оруулалтын тасгийн дарга, Ерөнхий нягтлан бодогч, УЕПГ-аас Чулуунбат УЕП-ын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга, АТГ-аас Баасанням АТГ-ын Тамгын хэлтсийн дарга, Улсын Дээд шүүхийн 2027 оны байж байгаарай.

16.1.Улсын дээд шүүхийн төсвийн төслийн талаар:

Улсын Дээд шүүхийн 2027 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга Заяадэлгэр танилцуулна аа.

Заяадэлгэр дарга индэр дээрээс танилцуулъя.

С.Заяадэлгэр: Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Та бүхний энэ оройн амгаланг айлтгая аа.

Улсын Дээд шүүх нь Монгол Улсын Үндсэн хууль, Шүүхийн тухай хууль болон Төсвийн тухай хууль холбогдох хууль тогтоомжийн хүрээнд 2027 оны төсвийн танилцуулгыг төсвийн төслийг боловсруулан та бүхэнд танилцуулж байна аа. Энэ төсвийн төслийг боловсруулахдаа 2020 оны Улсын Их Хурлын 52 дугаар тогтоолоор батлагдсан Алсын хараа-2050 Монгол Улсын урт у хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлын 24 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын 3Г-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2024 оны Улсын Их Хурлын 33 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого, 2025 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2027 оны хөгжлийн төлөвлөгөө зэрэг бодлогын үндсэн баримт бичгүүдийг үндэслэн үйл ажиллагааныхаа 2027 оныхоо төсвийг боловсрууллаа.

Энэ бодлогын баримт бичгүүдэд гол тусгагдсан зорилго, зорилтууд, агуулга бол авлигыг бууруулж иргэдийн шүүхэд итгэх итгэл шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх, ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх, үндэсний аюулгүй байдал болон цахимаар түүнд үйлчлэх зарчим иргэн төвтэй үйлчилгээг бүрдүүлэх энэ зөв засаглалаар тэргүүлэх эхний үзүүлэлтээр эхний 90 орны нэг болно гэсэн бүтээмжийн болон засаглалын бодлого чиглэлүүдийг үйл ажиллагаандаа гол чиглэл болгож ажиллалаа.

Тэгээд Монгол Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгчийн захирамжаар батлагдсан 5 жил жилийн стратеги төлөвлөгөөг төлөвлөгөөнд тусгагдсан

зорилтуудаас 2027 онд хэрэгжих үндсэн чиглэлүүдээ түүж чиглэлүүдээ боловсруулсан байгаа. Ер нь Улсын Дээд Шүүхийн үйл ажиллагааны хувьд өнгөрсөн жилд 2887 хэрэг хүлээж авсны 983 нь эрүүгийн, 1323 нь иргэний, 579 нь захиргааны хэргүүд байсан ба энэ бүх хэргүүд жилээс жилд буурахгүй байгаа. Мөн эрүү, иргэн, захиргааны хяналтын шатны бүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа буюу 546 хэргийг шууд дамжуулалттайгаар явуулж таслан шийдвэрлэх ажиллагаагаа хэрэгжүүллээ. Энэ хугацаанд мөн 2 тайлбарыг шинээр баталснаар 2021 оны оноос хойш 18 хуулийг зөв хэрэглэх тайлбарыг батлан гаргаж нийт хуулийн байгууллагууд шүүхийн үйл ажиллагаанд бүрдүүлж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Энэ хугацаанд мөн Улсын дээд шүүхээс хууль эрх зүйн 33 баримт бичигт төсөлд санал өгсөн. 101 асуудлыг нийслэлийн шүүгчийн хурал зөвлөгөөнөөр шийдвэрлэсэн зэрэг нь Улсын дээд шүүхийн ачаалал жилээс тэгж жилд өсөж байгааг харуулж байна аа.

Улсын Дээд шүүхийн хувьд гадаад харилцаагаа өргөжүүлэх зорилтыг тавин ажиллаж, шинээр өнгөрсөн жилд бол Вьетнамын Улсын Ардын дээд шүүх Сингапур Улсын дээд шүүхтэй харилцан ойлгосон санамж бичгийг шинээр байгуулж Шүүхийн академийн хувьд Европын холбооны Асерын академи, Бүгд Найрамдах Турк Вьетнамын академиуд зэрэг олон Улсын түвшинд ижил түвшний академи хүрээлэнгүүдтэй хамтын ажиллагааны гэрээг байгуулж шүүхийн үйл ажиллагаанд олон Улсын туршлагыг нэвтрүүлэх сургалт судалгааны ажлыг өргөтгөх чиглэлд анхааран ажиллаж байна аа.

Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн 2027 оны төсвийн төслийг нийтэд нь авч үзвэл 34 тэрбум 349 сая төгрөг байхаар нийтдээ өргөн мэдүүлж байгаа. Үүнээс урсгал зардлын төсөв нь 30.7 тэрбум, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаа 3.6 тэрбум төгрөгөөр төсөвлөж ирүүлсэн. Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгчийн төсвийн багцын 2027 оны төсвийн төслийг боловсруулахдаа хяналтын шатны шүүн таслах ажиллагаа болон шүүн таслахаас бусад ажлууд, холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт, бичигт тусгагдсан бодлого зорилт, үр дүнг хэрэгжүүлэх шаардагдах зардлыг батлагдсан цалингийн хэмжээ мөн холбогдох байгууллагуудаас баталсан тариф, инфляцын түвшин, тогтмол хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлттэй уялдуулан төсөвлөсөн.

Энэ нь 2026 оны нийт батлагдсан төсвөөс 17.5 хувийн өсөлттэй байхаар тооцоо гарч байгаа. Энэ өсөж байгаа хэсэг нь ямар хэсэг байна вэ гэхээр 40 хувь нь болохоор одоо ирэх жил тэтгэвэр тогтоолгохоор хүсэлт гаргасан шүүгч болон албан хаагчдын тэтгэмж нэг удаагийн тэтгэмж буюу 36 сарын 1 удаагийн тэтгэмж эзэлж байна. 15 хувийг нь сургалт, номын санг хөгжүүлэхтэй холбоотой зардлууд өсөж гарч ирж байгаа. Сургалтын хувьд бол Шүүхийн академи дээр шинээр байгуулагдсан гэр бүлийн шүүх болон шинэ шинэ шүүгчийн сургалтын хэсгүүд мөн ОУБ дээр өмнө нь донор байгууллагуудаас хариуцан санхүүждэг байсан хэсгүүд төсөл хаагдсанаар Шүүхийн академи дээр шилжин ирж хэрэгжих болсонтой холбоотой зардлын өсөлтүүд гарч байгаа. Мөн энэ хүрээнд бид бүхэн нэмэгдэж төсөвлөсөн бас нэг зардал нь бол энэ Ахмад настны тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуульд байгууллагад үүрэг болгон заасан хуулийн заалтын хэрэгжилтийг хангахад 8.3 хувь нь энэ чиглэлд ноогдохоор байгаа хүсэлтийн хувьд. Ингээд энэ эдгээр зардлуудыг нарийвчлан дэлгэрэнгүй байдлаар нэг тайлбарлаж та бүхэнд танилцуулсан байгаа.

Хөрөнгө оруулалтын зардлын хувьд тодотгох зүйл байгаа. Улсын Дээд шүүхээс хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, шүүхийн үйл ажиллагааны өнөөгийн энэ тулгамдсан асуудал буюу ачааллыг бууруулах, сургалт, судалгааны ажлуудыг хөнгөвчлөх, шүүхийн шийдвэр болон мэдээллийн сангуудыг их өгөгдлийн санг зөв алдаагүй, эрсдэлгүй бүрдүүлэх, түүний техник тоног төхөөрөмж аюулгүй байдал, программын хөгжүүлэлтүүдийг шинэ түвшинд авч үзэх чиглэлд зорилт тавьж ажиллаж байгаа. Энэ нь бол Засгийн газрын хүрээнд программ хангамжийн зардлуудыг нийтээр нь бууруулах зорилт тавьж байгаа боловч хиймэл оюун буюу энэ шууд худалдан аваад хэрэглэх боломжгүй төслүүдэд бол хөрөнгө оруулалтыг дэмжиж байгаа гэсэн ойлголт зорилго бодлого чиглэл байгаатай нийцэж байгаа гэж үзэж байгаа.

Монгол Улсад бол энэ эх хэлний загвар буюу хиймэл оюуныг төрийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд Улсын Дээд Шүүх дээр хэрэгжих гэж байгаа энэ төсөл маань өөрөө нэлээн суурь шинжтэй өгөгдлийн сангаа өөр дээрээ бүрдүүлж гадагшаагаа гаднын сервер рүү алдахгүй байх, мөн цаашид энэ хөгжүүлэлтийнх нь үйл ажиллагаанууд өөртөө өөр дээрээ төвлөрөх талаараа чиглэл дээрээ энэ онцлог байгаа.

НҮБ-аас өнгөрсөн жил баталсан шүүхэд хиймэл оюуныг нэвтрүүлэхэд баримтлах зарчим гэж байгаа. Энэ дээр бол хамгийн гол асуудал нь шүүхэд хиймэл оюуныг нэвтрүүлэхэд ер нь эрсдэл өндөртэй салбар учраас анхаарах 15 гол зарчим чиглэлийг удирдлага болгож өгсөн байдаг.

Энэ нь өөрөө ChatGPT зэрэг зэрэг нөгөө нэг ард иргэдийн хүрээнд нийтлэг хэрэглэгдэж байгаа энэ гадаад олон нийтийн энэ хэрэглээний хиймэл оюунуудыг шүүхэд ашиглахыг ер нь хориглодог. Яагаад гэвэл шүүхийн хэмжээнд байгаа хаалттай эмзэг энэ мэдээллүүдийн эрсдэл хамгаалах шаардлагаас энэ нь өөрөө хамаардаг.

Нөгөө талдаа шүүхийн аюулгүй байдал, мэдээллийн нууцлалын чанар өөрөө өндөр байдаг учраас кибер аюулгүй байдлын хамгаалалтууд болон техник тоног төхөөрөмжийн найдвартай байдал өөрөө их чухал байдаг учраас эдгээр дээр онцлон эрсдэлийг тооцоолох чиглэл дээр тодорхой зарчмуудыг гаргаж өгсөн байдаг. Олон Улсын эдгээр зарчмууд болон олон Улсын гадаадын шүүхүүд дээр хэрэглэгдэж байгаа энэ туршлагаудыг судалж үзсэн. Улсын Дээд шүүхийн хувьд түлхүү Сингапурын Дээд шүүх болон Солонгосын Дээд шүүхийн мэдээллийн Ай Ти центрүүдийн үйл ажиллагаатай 2 шүүхийн хоорондын гэрээний үндсэн дээр техник технологийн албан хаагчдын тэгээд сургах болон туршлага судлах ажлуудыг зохион байгуулаад судалгаа хийсний үндсэн дээр эрсдэлийн.

Д.Цогтбаатар: Ганц минут нэмж өгье.

С.Заяадэлгэр: Энэ чиглэл рүү ийм судалгаануудыг хийсэн байгаа. Тэгээд та бүхэнд поверпойнт доор мэдээллийг дэлгэрэнгүй ингээд танилцуулчихсан байгаа.

Төгсгөлд нь шүүхийн үйл ажиллагааны индекс олон Улсын индексүүд олон улсад буурч байх цаг үед Монгол Улсын шүүхийн индекс өссөн. Энэ нь бодлого төлөвлөлт энэ чиглэлийн үзүүлэлт шалгуурууд дээрээ илүү түлхүү өсөлт нь гарч өгсөн байгаа. Энэ нь түрүүн Байнгын хорооны даргын дурдсан энэ бодлогын энэ

дэмжлэг чиглэл хамтын ажиллагаа энд Хууль зүйн байнгын хорооныхоо нийт гишүүдэд талархал илэрхийлж байна аа.

Ингээд Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн төсвийн багцын 2027 оны өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцэн хянаж өгөхийг хүсье ээ.

Д.Цогтбаатар: Заяадэлгэр даргад баярлалаа.

Улсын дээд шүүхийн 2027 оны төсвийн төслийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардалтай холбогдуулан асуулт асууж үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү? Улсын Дээд шүүх тийм. Тулга гишүүнээр тасаллаа. Алтангэрэл гишүүний микрофоныг өгье. Баасанжаргал гишүүнийг оруулаарай.

О.Алтангэрэл: Энэ манай Дээд шүүхийн энэ программ хангамж нэн ялангуяа энэ хиймэл оюуны хөгжүүлэлтийн чиглэлээр хийж байгаа үйл ажиллагаануудтай манай Хууль зүйн байнгын хорооны гишүүд бүр нь очиж танилцмаар юм байна лээ. Тэгээд үнэхээр би түрүүнд нь Заяадэлгэр даргаас тодорхой танилцуулгуудыг сонсож байсан. Тэгээд манай Монгол Улсын бусад төрийн байгууллагуудтай харьцуулахад энэ хиймэл оюун ухааныг хөгжүүлэх энэ шүүхийн практикт нэвтрүүлэх чиглэлээр өөрсдөө үндэсний бие даасан систем хөгжүүлэх чиглэлээр маш олон зүйл хийсэн юм байна лээ.

Дээрээс нь энэ аюулгүй байдлаа хангах чиглэлээр бас нэлээн ахицтай. Ахицтай гэдэг нь бусад байгууллагуудтай харьцуулахад харьцангуй урагшаагаа алхсан ийм байдалтай байгаа юм байна лээ. Тэгээд одоо Улсын дээд шүүхийн хувьд үйл ажиллагаа явуулж байгаа байр савны хувьд хэрэглэж байгаа, программ хангамж, хөгжүүлж байгаа зүйлийнхээ хувьд нэлээн ахиц дэвшилтэй байгаа учраас бид цаашдаа энэ үйл ажиллагааг нь улам дэмжих бид шүүхийн асуудал ярихаар зөвхөн байр савны асуудал ярьдаг. Байр саваа хэдүүлээ мэдээж ярина. Тэр шаардлага нь байгаа. Тэрнээс гадна өөрсдийнхөө үйл ажиллагаанд шинэчлэл хийгээд харьцангуй орчин үе цаг үетэйгээ хөл нийлээд явж байгаа энэ санаа санаачилгыг ХЗБХ Монгол Улсын Их Хурлын зүгээс дэмжих ёстой гэсэн ийм байр сууриа илэрхийлж үг хэлье.

Д.Цогтбаатар: Тулга гишүүн.

Б.Тулга: Хянаад ороод ирсэн төсвийн саналтай танилцаж байна. Тэгээд энэ сургалт гээд нэг 2.2 байх шиг байна тэ? Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх гээд 1.9, 2.2. Энэ дээр яг хэчнээн шүүгчийг хамарсан ямар хэмжээний сургалт юу явуулдаг юм бэ? Бүх шүүгч нар уу тэ?

Д.Цогтбаатар: Индэр дээрээс хариулахгүй бол нөгөө наана чинь болохгүй.

Д.Эрдэнэчимэг: Тулга гишүүний асуултад хариулъя. Шүүхийн академийн захирал Эрдэнэчимэг байна. Манай академийн хувьд хуулиар хүлээсэн үндсэн чиг үүрэг нь шүүгчдийн сургалт зохион байгуулах, судалгаа хийх, шүүхтэй холбоотой мэдээллийг олон нийтэд түгээх гэсэн ийм чиг үүрэгтэйгээр ажилладаг. Тэгээд сургалтын хувьд бол бид нар шүүгчийн сургалт зохион байгуулах нэгдсэн бодлогыг батлаад нэгдсэн бодлогын хүрээнд жилдээ Монгол Улсын хэмжээнд байгаа нийт шүүгч нар 4 кредит хангаж ажиллах ёстой байдаг. Тэгээд энэ 4 кредитийн сургалт нь заавал судлах сургалт буюу сонгон судлах сургалт гэж хуваагдаад тэгээд заавал

судлах сургалт нь мэргэжил болгоноороо ингэж чиглэж сургалтууд тогтмол зохион байгуулагддаг байгаа. Үүнээс гадна сонгон судлах сургалтыг маш олон төрөл хэлбэрээр яг хэрэгцээтэй байгаа чиглэлээр нь өгөхийг зорьж ажилладаг учраас сонгон судлах сургалтууд бас нэлээн явж байгаа. Энэ хичээл үйлдвэрлэлийн зардал дээр зөвхөн сургалт зохион байгуулахаас гадна сургалтын цахим платформтай холбоотой сургалтын хэрэглэгдэхүүн буюу ном сургалтын гарын авлага хэвлэхтэй холбоотой зардлууд давхар орж явсан байдаг. 530 шүүгчтэй бүгдэд нь бүх сургалтаа давхардсан тоогоор орж явдаг байгаа. Өнгөрсөн жилийн хувьд бол бид нар давхардсан тоогоор нийт 2 мянган шүүгчид нийтдээ сургалт зохион байгуулсан байгаа. Энэ сургалтдаа бас гадаад дотоод сургалтаа бүгдийг нь хамааруулаад энэ зардлаасаа төлөөд явдаг. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Эхний энэ асуултыг нөгөө хөрөнгө оруулалтын зардал дээр Шүүхийн сургалт, судалгаа мэдээллийн академи ингээд 2026 оноос эхлээд хөрөнгө оруулалтын зардал огт төлөвлөөгүй байна энэ зөв үү гэдэг дээ.

Тэгэхээр өмнөх хөрөнгө оруулалтын зардал нь бодвол шинээр байгуулагдсантай холбоотой байсан юм байлгүй. Гэхдээ нөгөө цахим энэ тэртэй чинь холбоотой зардал, шүүхийн академи дээр гарахгүй байсан уу гэдэг нэг асуулт.

Хоёрт нь Дээд шүүх яг энэ нөгөө үр дүнгээ иргэдэд хүрэх үр дүн гээд энэ хоёрыгоо тодорхойлоод тодорхойлчихсон байгаа нь сайн байна. Гэхдээ одоо жишээ нь энийг ингэмээр байна. Хууль хэрэглээний нэгдмэл байдалд дэмжлэг үзүүлнэ гэчихсэн. Гэхдээ хууль хэрэглээний нэгдмэл байдал ямар үзүүлэлтээр өсөх юм гэдэг ийм тоогоор илэрхийлмээр байна. Тэгээд нөгөө бид нарын 2027 оны төсөв дээр баталсан үр дүн дээр бид нар бүгдээрэн дээр нь тоо тавьчихсан байгаа. Суурь үзүүлэлтүүдээ гаргахаар тавьчихсан байгаа.

Тэгэхээр тэр тоонууд ерөөсөө энэ дээр байхгүй байгаа байхгүй юу.

Тэгэхээр Дээд шүүх мэдээж тусдаа үзүүлэлттэй байна гэж байхгүй байлгүй. Гэхдээ яг тэр үзүүлэлтдээ захирагдах байх. Дээрээс нь нэмээд илүү нарийвчилж байгаа юм байна гэж хараад байна. Хууль зүйн мэдээлэл зөвлөгөө шуурхай авах боломж бүрдэнэ гээд одоо иргэдийн хууль зүйн мэдээлэл авах дундаж цаг хугацаа хэд хоног байдаг юм. Тэрийг AI ч гэдэг юм уу ийм цахим үйлчилгээ нэвтэрснээрээ хэд хоног болгох юм ч гэдэг юм уу. Ингээд нөгөө төсөв чинь өөрөө та бүхний үр дүнтэй яаж уялдах юм бэ гэдгийг яг ийм тоон үзүүлэлт рүү хэдүүлээ шилжүүлдэг энэ хувилбар руугаа орох хэрэгтэй байгаа. Тэгэхдээ ямар ч байсан үр дүн, иргэдэд хүрэх үр дүн 2-ыг тодорхойлоод ороод ирсэнд талархаж байна аа.

Тэгээд Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн тэр хөрөнгө оруулалтын зардал дээр та хэд маань нэг юм хэлэх үү?

Д.Цогтбаатар: Заяадэлгэр дарга, индрийн микрофон өгье.

С.Заяадэлгэр: Улсын Дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн академийн хувьд энэ жил хөрөнгө оруулалтын зардал төлөвлөгдөөгүй. Урсгал зардлын хүрээнд номын сангаа өргөжүүлэх, цахим хэлбэр рүү шилжүүлэхтэй холбоотой 200 гаруй сая төгрөгийн урсгал зардал гарахаар байгаа юм. Энэ нь бол Улсын Дээд шүүх өөрөө 6

мянга орчим номын фонд сантай. Энэ нь Улсын Дээд шүүхийн шүүх болон судлаач албан хаагчдын хэрэгцээнд ашиглагддаг бол ирэх жил Шүүхийн академи үүн дээр өргөтгөөд бүх шүүгч нарын хэрэгцээнд номын сангаа ашиглуулах боломжийг хангах хүрээнд бага хэмжээний урсгал зардлын төлөвлөлт байгаа. Бусад хөрөнгө оруулалтууд бол үндсэндээ хийгдээд зохих түвшинд хүрсэн гэж үзэж байгаа.

Улсын дээд шүүхийн Тамгын газар дээр нийт хөрөнгө оруулалтаа цахим болон хөрөнгө оруулалтууд нь нийт дүнгээрээ манай Тамгын газар дээрээ нэгтгэгдээд явж байгаа. Ер нь мэдээллийн технологийн үйлчилгээ болон аж ахуйн холбогдолтой нэлээд олон төрлийн үйлчилгээнүүдийг манай Тамгын газраасаа 1 байртай байгаатай холбоотой хамтад нь авч явж байгаа. Хүрэх үр дүнгийн хувьд бол хууль хэрэглээний нэгдмэл байдал гэдгийг энэ хөрөнгө оруулалтынхаа төсөл дээр онцлоод аваад үзчихсэн байгаа. Гэвч 2026 оны төсөв батлагдах үед бид 2 үзүүлэлтээр л зорилтот түвшнээ тодорхойлдог байсан бол Хууль зүйн байнгын хороо энэ дээр бид бүхэнд санал авсан л даа. Тэгээд ингээд өргөтгөөд 13 үзүүлэлтээр зорилт хүрэх үр дүнгээ тодорхойлдог болгох болгоод тогтоол Улсын Их Хурлаас гарчихсан. Энэ нь өөрөө 9 сард төсөв нэгтгэн өргөн баригдах үед Сангийн яам Төсвийн тухай хуульдаа заачихсан байгаа учраас төсөвтэйгөө хамт дахин дараагийн нэгдсэн төсөвтэй хамт орж ирэх ийм хуулийн зохицуулалттай байгаа.

Д.Цогтбаатар: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Би хоёр үг хэлээдэхье.

Энэ шүүхтэй холбоотой танайх тэр платформ хөгжүүлж байгаа дижитал платформ хөгжүүлж байгаа нь бол үнэхээр сайн. Би бол прокурорт яг дижитал тийм платформ хөгжүүлэх ёстой. Хажуугаар яг хүнээс хараат бус энэ ажлын дүгнэлт гаргаж байгаа. Дүгнэлтийн энэ хяналт жинхэнэ утгаараа хараат бус явах боломж яг энэ дижитал платформыг дагаж гарч ирнэ. Тэгэхээр шүүх дээр ч гэсэн энийг харин өөрсдөө санаачлаад энийг хийгээд явж байгааг би их дэмжиж байгаа.

Ялангуяа танай энэ IT чиглэлийн боловсон хүч чинь үнэхээр чадварлаг хүмүүс байна лээ. Яг энэ жишгээр прокурор бусад байгууллагууд энийг хэрэгжүүлээд явах боломжтой. Та нар тэгэхээр тэр технологи юман дээрээ хуваалцах би боломж байгаа болов уу гэж бодож байгаа юм. Хоёр дахь нь тэр шүүхийн болон ер нь энэ шүүх дээр байгаа хэргүүдтэй холбоотой лайв стриймээс гадна би нөгөө телевизийн суваг байгуулъя гэдэг энэн дээрээ та нар бас анхаарч ажиллаарай. Тэгээд энийгээ харин нэгтгээд одоо энэ Шүүхийн сахилгын хороо бусад энэ байгууллагууд яагаад гэвэл тэр бүгдтэй нь хамаатай учраас ШЕЗ ч гэсэн тал талаасаа та нар төсвөө нэг байгууллага дээрээ яачихвал наадах чинь их хүнд болчихож байна шүү дээ. Тэгэхээр хэд хэдэн байгууллагууд төсвөө хувааж тавиад 1 тийм суваг явах хэрэгтэй байгаа шүү. Тэгээд тэрэн дээрээ харин ёстой төсвийг нь та нар оруулна уу гэхээс үйл ажиллагаанд нь оролцохгүй. Энийг яг хараат бусаар ёстой нөгөө мэргэжлийн хүмүүс ингээд ороод ийм кэйсүүд хэлэлцэж байна. Энэ дээр ийм ийм алдаа дутагдал гарч байна. Энэ дээр илт ийм завхрал харагдаж байна гээд. Энэ чинь л нөгөө хамгийн найдвартай шүүхийн шийдвэрийн шударга байдлыг хангаж өгнө. Тэгэхээр ил тод байдал гэдэг хамгийн том хяналт.

Тэгээд энэ хяналтыг тавихын тулд ганцхан тэр лайв стрийм биш энэ телевизийн суваг хэрэг болно шүү. Энэ дээрээ бол та нар анхаарч ажиллаарай гэж хэлмээр байна аа. Тэгээд ер нь ингээд хичээгээд тал талаа аасаа анхаарал тавиад ажиллахад бол гардаггүй үр дүн гэж үнэхээр байхгүй шүү. Энэ Монголын нийгэм цэвэршиж нийгэм эрүүл болох боломж үнэхээр бий. Тэрэн дээр бүгдээрээ санал

санаачилгатайгаар ажиллаад энэ асуудлыг нэг урдаа гаргасан бол тэрийгээ шийдтэл хэн ч санаа амрахгүй дор дороо манай Байнгын хорооны гишүүд ч дор дороо байнга энийг анхаарч шүүмжлэх юман дээрээ шүүмжилж ажиллаж байх ёстой л гэдгийг хэлмээр байна аа.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа.

Улсын дээд шүүхийн 2027 оны төсвийн саналыг хасагдуулахгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагчдад хүргүүлэхийг, Төсвийн төслийн эцсийн хувилбарыг Улсын төсөвт нэгтгүүлэхээр санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлье гэсэн нөгөө түрүүн би юуг нь уншсан. Хасагдуулахгүйгээр манай Байнгын хороон дээр төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Гишүүд орж ирээрэй Сайнзориг гишүүн.

Санал хураалтдаа бэлдье.

Саяын уншиж танилцуулсан томьёоллоор дэмжье гэж санал хураалт явуулъя.

Санал хураалт.

56.3 хувиар санал дэмжигдлээ.

Одоо саяын энэ гишүүдийн хэлснийг та нар нээрээ анхаараарай. Бас бид нар ингээд баталж өгчхөөд та нарын төсвийг Байнгын хорооны гишүүд бүгд хамгаалаад л явж байгаа. Эцсийн дүндээ ажлын үр дүн л хэрэгтэй шүү дээ. Тэгэхээр тэрийгээ та нар анхаарч ажиллаарай. Санал хураалтын дүнг танилцууллаа.

56.3 хувиар санал дэмжигдлээ.

22.24 цаг

16.2.Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсвийн төслийн талаар:

ШЕЗ-ийн 2026 оны төсвийн төслийг хэлэлцье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг түрүүн танилцуулчихсан. Та нар ажлын хэсэг сая хэлэлцүүлээд яачихсан хүмүүс бол ажлын хэсэг гарч байж болно оо.

Ингээд ШЕЗ-ийн 2027 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг ШЕЗ-ийн дарга Пунцагийн Золзаяа танилцуулна аа. Индэрийн микрофон өгье.

П.Золзаяа: Та бүхэнд оройн мэнд хүргэе. Би товчхон ярья гэж бодож байна. Шүүхийн тухай хуулийн 74.1-д зааснаар ШЕЗ, Улсын Дээд шүүхээс бусад шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж хянуулах үүрэгтэй. Энэ чиг үүргийн дагуу та бүхэнд 2027 оны ШЕЗ-ийн төсвийн төслийг танилцуулж байна аа.

2026 онтой харьцуулахад 2027 оны төсвийн төслийн санал нэлээн өндөр дүнтэй явж байгаа. 646 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн. Ингээд яагаад ийм болсон бэ гэдэг дээр эдийн засгийн ангиллын хувьд бол 2 урсгал зардал буюу хөрөнгийн зардал өссөн энэ хүчин зүйл нөлөөлж байгааг мэдээлэх нь зүйтэй гэж үзэж байна. Яагаад энэ 2 ангиллын хувьд ингэж өссөн бэ гэдэг дээр та бүхэнд тодорхой энэ үндэслэл шалтгааныг нь хэлье гэж бодож байна аа. Хөрөнгийн зардлын хувьд бол шүүхийн шинэтгэл явагдаж эхэлснээс хойш бол ер нь шүүхийн тогтолцоо, институт, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, шүүгчийн ур чадвар шүүхийн хараат бус байдал бие даан ажиллах нөхцөлөөр хангах гэсэн энэ чиглэлд голчлон анхаарч ажилласан байна.

Яг ингэж шинэтгэлийн хүрээнд ингэж ажиллахдаа бол энэ барилгын асуудлыг нэг их хөндөөгүй ер нь олон жилийн хугацаанд ингэж орхигдуулсан шинжтэй байгаад байгаа юм. Тэгээд 2024 оноос хойш ингэж үе шаттайгаар энэ барилгын шүүхийн байрыг стандартын дагуу байгуулах зорилгоор төлөвлөж хөрөнгө оруулалтаа шийдвэрлүүлж ирсэн. Ингээд барилгын хувьд ингээд үзэхэд өнөөдөр бол 88 шүүх 42 шүүхийн барилгад ингэж үйл ажиллагаагаа явуулж байгаа. Энэ 42 барилгаас судлаад үзэх юм бол өөрийн гэсэн байргүй шүүх байна.

Дээрээс нь бусад прокурортой хамт үйл ажиллагаа явуулж байгаа шүүх байна. Өөрийн байр байгаа боловч олон жилийн нөгөө насжилттай стандартын шаардлага хангахгүй, зориулалтын бус хүүхдийн цэцэрлэг банк гэсэн ийм байгууллага, зочид буудал гэсэн ийм зориулалтаар анх барьсан ийм барилгуудад шүүх үйл ажиллагаа явуулсаар ирсэн байна аа.

Тийм учраас энэ 2025 оноос эхлэн энэ барилгын тухайд шийдвэрлэх зайлшгүй ийм шаардлага үүссэн байна. Ингээд одоо баригдаж байгаа 5 барилга байгаа. 2027 онд нийт 8 шүүхийн барилгыг шинээр барих ийм төсөв тусгагдсанаараа энэ хөрөнгийн зардал нэлээд өндөр тогтоогдож 2027 оны төсвийн хэмжээ ингэж өндөр харагдаж байгаа юм аа. Энэтэй холбоотой барилгатай холбоотой судалгааг тайланд бид өгсөн байгаа. Энийг мөн дэлгэрүүлээд тодорхой баримтуудаар дэлгэрүүлж өгч болно. Ингээд эхний энэ төсвийн төсөл төсөлд нөлөөлж байгаа энэ хүчин зүйл нь бол энэ байгаа юм.

Хоёр дахь урсгал зардал яагаад өссөн бэ гэхээр урсгал зардлын ер нь 62 хувийг цалин хөлс нэмэгдэл урамшуулал эзэлж байна. Орон тоотой холбоотойгоор ингэж өсөх ийм үндсэн шалтгаан нь байгаа. 2026 онд орон тоог батлахад 216 захиргааны ажилтны орон тоог бууруулсан байгаа. 2199 болгосон. Энэ үед энэнээс өмнө болон үүнээс хойш үргэлжлэн шүүхийн нөгөө хэрэг маргааны хэрэг маргааны тоо нэлээн нэмэгдчихсэн. Статистик үзүүлэлтүүд байна. Жишээлбэл иргэний хэрэг 30 хувиар нэмэгдсэн, эрүүгийн хэрэг 17 хувь байсан байх аа тэгж нэмэгдсэн байж байгаа. Ингээд үүнтэй холбоотойгоор захиргааны ажилтны тоог ер нь нэгэнт бууруулчихсан учраас хэмнэж ирсэн. Нэг шүүгч туслахтай, нарийн бичигтэй байх гэдэг энэ бодлогын үүднээс авч үзсэн боловч ингээд батлагдсан орон тооны хүрээнд шийдвэрлэх боломжгүй байсан.

Тийм учраас энэ орон тооны хувьд яг захиргааны ажилтны орон тоогоо яг шүүгч болгон туслах байх нарийн бичиг байх гэдэг бодлогоор жоохон нэмэгдүүлэх нэг ийм зорилго байгаа.

Хоёрт нь гэр бүл энэ хүүхдийн хэргийн анхан шатны шүүх давж заалдах шатны шүүх байгуулагдаж байгаатай холбоотойгоор гэр бүлийн мэргэжилтэн гэдэг энэ ажилтан нэмэгдэж байгаа. Тэгээд эдгээр үндэслэлүүдээр бол захиргааны ажилтны тоо нэмэгдсэн, шүүгчийн тоо хэвээрээ байгаа. Ингээд ажилтны тоо нэмэгдэхээр цалингийн хэмжээ нэмэгдэж байна.

Дагаад ингээд нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал ингээд нэмэгдсэн байна аа. Тэгэхээр яг энэ 2 гол энэ хүрээнд энэ төсвийн хэмжээг бол ингэж нэмэгдэж харагдаж байгаа гэдгийг би та бүхэнд ингэж хэлэх гэсэн юм аа. Ингээд шаардлагатай асуултад хариулья.

Төсвийн төслийг баталж өгөхийг та бүгдээс хүсье ээ.

Д.Цогтбаатар: Золзаяа даргад баярлалаа.

Улсын Их Хурлын тамгын газраас ШЕЗ-ийн 2027 оны төсвийн төсөлд хийсэн дүн шинжилгээний талаарх танилцуулгыг та бүгдэд хүргүүлсэн байгаа. ШЕЗ-ийн 2027 оны төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардалтай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү.

Тулга гишүүнээр тасаллаа. Алтангэрэл гишүүний микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Энэ нөгөө Гэр бүлийн хуулийн гэр бүлийн процессын хуулийн ажлын хэсгийн хүрээнд бид нар энэ Баасанжаргал гишүүн бид нар Канад улсад очиж туршлага судлаад явж байсан юм.

Тэгээд манай ерөнхий зөвлөлийнхөн нөгөө хамт бүрэлдэхүүнд орж яваад тэгээд тэр барилгын мэргэжилтнүүд яваад явж байсан юм. Тэгээд нөгөө 2 залуу тэр чинь инженер залуу байсан байх захиад л тэр шүүхийг нь хараарай яаж барьсан байна. Судлаарай гээд л. Сүрхий яваад л үзсэн юм. Тэгээд л янзын янзын барилгууд байна аа. Тэр хамгийн айхтар барилгад нь ороод л үзлээ. Бараг хаалга цонх нь ингэдэг юм байна гээд. Тэгээд автомат биш ч юм алга, эко биш ч юм алга тэр барилгад. Ямар гоё байр вэ гээд. Тэгээд үзэж үзэж байгаад танай энэ байр хэд болсон юм гэсэн чинь тэрбум доллар гэж байгаа байхгүй юу. Гурав аравны хэдэн их наяд төгрөгөөр тэр Канадын нэг ийм гэр бүлийн нэг ийм том шүүхийн барилга нь баригдчихсан байгаа юм. Тэр чинь тэр улсад байгаа хэчнээн олон шүүхүүдийн зөвхөн нэг барилга нь тийм ээ.

Тэгээд эндээс юу ойлгож авсан юм бэ гэхээр энэ үнэхээр шүүх гэдэг бол бид нар хараат бус байдал, тэгээд хууль хэрэглээ олон зүйл шаардахаас гадна орчин чухал байна гэж. Өнөөдөр яг үнэндээ манай шүүхүүдийн нөхцөл байдал туйлын хэцүү байгаа. Шүүх хуралдааны танхимаасаа шалтгаалаад хэрэг шийдвэрлэлт удааширдаг. Тэр шүүх хуралдааны дотор байгаа агааржуулалт зай талбай энэ зүйлүүд ер нь их хэцүү түвшинд байгаа шүү дээ. Тэгэхээр бид энэ барилга байшинтай холбоотой юм ярихаас арга байхгүй. Яагаад гэвэл энэ чинь өөрөө Монгол Улсын иргэдэд үйлчилдэг байхгүй юу. Шүүгч нар суугаад байгаа юм биш, шүүхийн ажилтнууд дотор нь ажиллаад байгаа юм биш. Өдөр тутамдаа Монгол Улсын иргэдэд үйлчилдэг. Тэгээд энэ ачаалал энэ тэр бол бүүр ярих юм байхгүй асар ихэссэн.

Тийм учраас би нэг юу асуух гэж байгаа юм. Энэ нөгөө Нисэх рүү баригдаж байсан нөгөө нэгдсэн цогцолбор билүү тэр маань нэг яваад хил хамгаалах байгууллагынх нь тэр тендер энэ тэрд нь ороод нэг явж байсан. Тэрний маань явц ер нь хэр байна аа? Хэзээ ер нь ашиглалтад орох шинж бүхий байна? Дээрээс нь одоо энэ нөгөө нэмж тусаж байгаа барилгууд маань энэ төсвийн хүрээнд та бүхний хүсээд байгаа энэ төсөв хөрөнгө тавигдчих юм бол хэдэн хувьтай яаж шүүхийн ачаалал яаж буурах талаар нэг тайлбарлаад өгөөч.

Д.Цогтбаатар: Индрийн микрофон өгье.

Б.Эрдэнэтулга: Гишүүний асуултад хариулъя. Шүүх ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Эрдэнэтулга байна. Хан-Уул дүүргийн 21 дүгээр хороонд Буянт-Ухаа 2 хорооллын хойно байгаа цогцолбор барилгын асуудлыг та хөндлөө. Энэхүү барилга маань 2014 онд анх санхүүжилтэд тавиад тухайн жилдээ зоорийн давхрыг тавиад царцчихсан барилга байсан. Ингээд энэхүү барилгыг бид бүхэн 2025 оны төсөвт тавигдаад 2025 онд нийтдээ 27.3 тэрбумаар барилга угсралтын ажил дууссан. Энэ жил бол 24.8 тэрбумаар гадна засал дэд бүтэц дотор өрлөгүүдийн ажил дуусагдана. Ингээд үлдэх 38 тэрбум төгрөгийг ингээд 2027 оны төсөвт тавигдах юм бол энэ барилга маань бид бүхэн 2027 оны сүүлээр 2028 оны эхэнд бүрэн ашиглалтад оруулна аа. Ийм байна. Түрүүн Золзаяа дарга хэлсэн байгаа. Нийт бид бүхэн Архангай, Дархан, Багануур, Өмнөговь, БЗД-ийн Эрүүгийн шүүхийн урд гээд 5 барилгын ажил эхлүүлсэн байгаа. Энэ жилдээ бид бол Архангай, Багануур, Өмнөговь гэдэг шүүхийн барилгыг ашиглалтад оруулна. Ингээд явж байгаа ингээд явах юм бол шүүх байргүй гэсэн шүүхүүдийн асуудал шийдэгдэнэ. Цогцолбор барилга ашиглалтад орсноор баруун талд байгаа эрүүгийн хэргийн шүүх, иргэний хэргийн шүүх, шүүхийн тусгай архив, хялбар ажиллагааны шүүхүүд ингээд бүрэн ашиглалтад орно. Ингэхээрээ бас шүүхэд ирж байгаа ачааллууд буурна. Иргэд аятай тухтай нөхцөл байдлаар үйлчлүүлэх тийм бүрэн боломж нээгдэнэ ээ. Ийм байгаа. Ерөнхийдөө бол ХЗБХ-оос тавигдсан төсвийн хүрээнд бид бүхэн энэ төсвийг үр зохистой хийж ажлыг нэлээн түргэн хугацаанд ашиглалтад оруулж барилгажилтын ажлыг дуусгаж байгаа.

Д.Цогтбаатар: Индрийн микрофоныг өгье.

Б.Эрдэнэтулга: 2027 онд нийтдээ энэ цогцолбор барилгын үлдэгдэл 38 тэрбум төгрөг суугдсан байгаа. Мөн шинээр эхлүүлэх Төв аймаг, Ховд, Завхан, Ханбогд гэсэн аймгуудын Хэнтий гэсэн шүүхүүдийн барилга гээд нийтдээ 188 тэрбумын барилгыг төсөвт суулгасан. Ингээд та бүхнийг хэлэлцэж, баталж өгнө үү гэж хүсэж байна.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Би яах вэ зүгээр тэгээд улс орны эдийн засгийн нөхцөл байдлууд амаргүй л байгаа. Тэгэхдээ яах вэ урсгал зардал дээр энэ шүүхийн системийн асуудлыг бас нэг Засгийн газар, Сангийн яам маань нэг ойлгож хүлээж аваасай гэж бодож байна. Хөрөнгө оруулалтын асуудлууд дээр бололцоотой байдлаар нь тусгах, тэгээд бид хэд яах вэ энд нэг юм батлаад л явуулна. Нөгөөдөх маань нээрээ бүрэн тусах уу гэдэг дээр л нэг тийм жоохон болгоомжлол байгаад байгаа юм. Тэгээд би яах вэ зүгээр үндсэн 3 асуудлаар юм хэлье гэж бодож байна. Миний хэлэх гэж байсан үндсэн санааг Алтангэрэл гишүүн маань хэлчихлээ. Яах вэ эцсийн дүндээ энэ төрийн 3 эрх мэдлийн, 3 институт дотор яах вэ Улсын Их Хурал

Засгийн газар нь яаж ийж байгаад л хоорондоо маргасан мэтгэсэн янз бүр болоод асуудлуудаа шийдэж байгаа.

Тэгээд шүүхийнхэн орж ирэхээр яг яг энэ чиглэл дээр нь яг тийм улс төржөөд гүйгээд байж чадахгүй хүчтэй лобби хийгээд энэ дотор холхиод байж болохгүй хэцүү л дээ. Тэгэхээр энийг нь л мэдэрч бид хэд бас нэг дэмжиж өгөх ёстой газар нь манай ХЗБХ болчихоод байгаа юм. Тэгэхээр энийг яах вэ би 1 дүгээрт би зарчмын хувьд хэлье. Тэгэхдээ ер нь зүгээр яах вэ нөхцөл байдлыг яг та хэд маань ойлгож байгаа байх гэж бодож байна.

Тэгэхээр яах вэ бодитой л хэрэгжих тийм зүйлүүдээ өгсөн нь дээр байх.

Тэгээд би яах вэ нэг бодоод байдаг зүйл байгаа. Энэ шүүхийн барилгуудыг ерөнхийдөө төр хувийн хэвшлийн түншлэлээр барих асуудлуудыг уг нь яг бусад салбартаа нэг байхгүйгээр ярьж үзэх ёстой юм шиг байгаа юм аа.

Тэгээд энэ төлбөрийг яг Улсын төсөв дээрээс дарамт багатайгаар 5-10 жилдээ хувааж төлөх байдлаар энэ цогцолбор барилгын хэмжээнд уг нь нэг шийддэг гарцыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль дээр жоохон нээж байгаад одоогийн процесс бол 3 жил бүтэхгүй. Тэгээд энийг нэг ийм шүүх эрх мэдлийн хувь дээр нэг 1, 1 удаа хөрөнгө оруулалт яачихвал эд нар нэг их дахин дахин юм гуйгаад байхгүй, урсгал зардлын л асуудал байгаа.

Тэгэхээр энийг нэг Байнгын хорооны дарга хэдүүлээ нэг ажлын хэсэг гаргаад бас нэг судалж үзээд уг нь нэг шийдээд тэгээд яг энэ хаана хаана шүүхийн барилга дутагдалтай байна энэ бүх зүйлүүдийг нь нэг иж бүрнээр нь шийдээд энийг Улсын төсөв дээр жоохон хагасалж хуваах байдлаар цувуулж өгөх байдлаар ингээд нэг шийдэх гарцыг нь судалъя гэж 1 дүгээрт бодоод байгаа юм.

Хоёрдугаарт энэ шүүхийн ачаалал их байгаа. Сая Сэлэнгэд нэг прокурор ороод ирсэн чинь хүүхэд нь шүүх хуралдааны нарийн бичиг байж байгаад гараад шүүхээрээ зогсож байна гэж сонссон. Нэг нь декрет аваад явчихсан. Тэгээд яах вэ зүгээр энэ шүүх хуралдааны нарийн бичигтэй холбоотой цалин хөлс, ажиллах баталгаа, цаашдаа магадгүй ажлыг хөнгөвчлөх тал дээр ер нь та хэд энэ төсөв дээр юу тусгаж байна. Магадгүй тэр чимэгэ маягийн программ хангамж ч гэдэг юм уу. Уг нь энэ чиглэл рүүгээ яваад механик ийм ажлуудыг нэг их тийм нарийн бичиг юунуудаар яг л хийлгэхийг багасгамаар л байгаа юм. Тэгээд энэ хүрээндээ бас нэг хууль эрх зүйн асуудал байгаа. Энийг манай сая Алтангэрэл гишүүн би Дээд шүүхэд үзсэн л гээд байгаа юм. Ер нь бол шүүх эрх мэдлийн байгууллагын болон хууль сахиулах байгууллагын цахимжилтыг дэмжих.

Д.Цогтбаатар: Нэг минут нэмж өгье.

П.Сайнзориг: Гарах ёстой юм байгаа юм. Тэгээд энэ яах вэ эрүүгийн хэрэг дээр бол бүтээгдэхүүн доороосоо мөрдөгчөөс эхэлж байгаа юм. Завсар дунд нь маш олон институцүүд оролцсон. Нийтийн эрх зүй, өмгөөлөгч нар, шинжээч нар оролцоно. Иргэн захиргаан дээр яах вэ хавтаст хэрэг угаасаа анхнаасаа шүүх дээр үүсэж байгаа учраас эндээс явна ч гэдэг юм уу.

Тэгэхээр энэ нэгдсэн Германд байдаг шиг энэ шүүх эрх мэдлийн цахимжилтыг дэмжих төв буюу дундын гэж гүйцэтгэх эрх мэдэл, шүүх эрх мэдэл

дундаа энэ чинь удирдлагыг нь зохицуулах гээд байна шүү дээ. Аюулгүй байдал бүх юмаа хангаж явдаг энэ чиглэл рүү орох ёстой юм. Тэгээд яах вэ энэ шүүхийн цахимжилт дээр ер нь ямар хэмжээний төсөв тавьж тавьж байна? Энийг уг нь уялдуулмаар байгаа юм. Ингээд тус тус тусдаа юм хийгээд байвал бүтэхгүй, уялдахгүй, дараа нь нөгөө нэгдэхгүй.

Тийм учраас би яах вэ зүгээр ийм 3 бүлэг асуудал байна. Эхнийх нь санал. Тэгээд та нарт яг ийм бодитой энийг нэг шийдэх Улсын төсөв дээр дарамт багатайгаа шийдэх ямар хувилбарууд байна? Зүгээр бодсон юмнууд байна уу үгүй юу? Төсөв харахгүйгээр. Энэ дээр нэг 3 асуулт дээр зарчмын зүгээр товчхон товчхон хариулаач.

Д.Цогтбаатар: Индрийн микрофон өгье. Золзаяа дарга.

П.Золзаяа: Шүүхийн ачааллыг яаж бууруулах вэ гэдэг бол ШЕЗ-ийн ёстой нэг номерын бодлого болж байгаа. Тэгээд энэнтэй холбоотойгоор эхний 1 дүгээрт ямар бодит боломж байгаа вэ гэхээр шүүхийн захиргааны ажилтны орон тоог нэмэх нь их зөв юм байна гэдэг зүйл практик дээр нотлогдлоо. Тэр юу вэ гэхээр Хялбар ажиллагааны шүүх дээр гэр бүлийн шүүхэд ажиллах 20 туслах нарийн бичгийн даргыг Хялбар ажиллагааны шүүх дээр 2 сараас хойш ажиллуулсан юм. Тэгтэл ноднингийн хэрэгтэй ингээд харьцуулахаар 4 мянган хэрэг шийдэж байсан. Өнөөдөр иргэний хэргийг үзэхээр 8 мянган хэрэг шийдээд ингээд өсчихсөн. Тэгээд энэ туслах байгаа байгаа учраас энэ хэргийг ингэж шийдвэрлэж байна гээд шүүгч нар энэ дээр нэлээн сэтгэл хангалуун байгаа.

Тэгэхээр захиргааны орон тоон дээр бол бас тэр асуудлыг харсанд их баяртай байна. Дараа нь энэ цахимжилтаар бид нар ачааллыг бууруулах бас нэг зорилго тавьж байгаа. Эхний үр дүн нь гарсан. Тэр нь юу вэ гэхээр нөгөө шийдвэрийг цахим систем shuuh.mn дээр байрлуулахад ингээд нөгөө нууцлалд оруулаад тэр ажиллагааг хийгээд тэгээд систем рүүгээ хөрвүүлээд маш их удаан ажиллагаа байдаг байсан. Тэгээд ядаж энэ ажлыг шууд нэг товч дараад л тэр нь нөгөө хиймэл оюун ухаанд суурилсан байгаа.

Ингээд нөгөө маскладаг юмыг нь нөгөө ингээд цаанаасаа арилгаад ингээд хийчхэж байгаа ийм боломж гарч ирж байгаа юм. Цахимжилттай холбоотой хамгийн 2 дахь том зорилго юу юм бэ гэхээр зөрчлийн хэргийг цахимжуулах гэж нэлээн эрч хүчтэй явж байгаа бид нар. Одоо ялангуяа тэр интеграцын хүрээнд бол цагдаагийн байгууллага, прокурортой ингээд бид нар хамтраад энийг ядаж 8 сарын 1 гэхэд оруулчих юмсан гэдэг ийм зорилго тавиад ажиллаж байна аа. Хэрвээ ингэх юм бол үнэхээр ажил хөнгөрнө. Зөрчлийн хэрэг цахимжчих юм бол энэ ажлын нэлээн ачааллыг хөнгөлнө. Өөр арга замаар шийдвэрлэх юмыг бид нар зорьж байгаа. Одоо энэ 3 жилийн хугацаанд энэ цахимжилтын хүрээнд хамтарч ажиллах ийм алхмууд хийгдээд явж байгаа. Гэхдээ ганцхан Ерөнхий зөвлөл гэхгүй прокурор дээр илүү түшиглэнэ. Тэгээд танай эрүүгийн цахимжилт дээр бид нар тусламж үзүүлье гэсэн ийм өөр бас нэг ийм их юугаар хөрөнгө оруулалтаар зарим асуудлыг шийдвэрлэх ажиллагаа явж байгаа.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Тэгэхээр хэдүүлээ нэг яах вэ би ийм байгаа улс орны эдийн засаг, нөхцөл байдал хүнд байгаа. Тэгээд яг шүүх эрх мэдлийн дэд бүтцийн

асуудлыг үе үед орхигдуулаад л явсан. Тэгэхээр энийг уг нь нэг удаадаа бусад эрх мэдэл барьцах институт байхгүй билүү? Уг нь энийг нэг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нэг шийдээд Улсын төсөв, ачааллыг яг ямар ямар үеэр хуваарилах вэ гэдэг нэг зарчмын нэг ийм шийдэл болчихмоор байгаа юм гэдэг зүйл байгаа.

Хоёрдугаарт яах вэ тэр цахимжилтын асуудлаа маш болгоомжтой хийгээрэй.

Ер нь яах вэ их гоё боловч манай барилгын салбар алдааг нь давтчихсан байхгүй юу. Баахан төсөл хөтөлбөрүүд авчраад хийсэн. Нөгөөдүүл нь 21 аймгийн газрын мэдээлэл жишээ нь холбогдохгүй сангууд хийчихсэн, мэдээлэл хийнэ тэгээд ийм зүйлүүд ер нь явчих гээд байна. Прокурор нь ч нэг тусдаа хөдлөөд, шүүх нь ч нэг тусдаа хөдлөөд. Шүүхийн гол бүтээгдэхүүнүүд чинь өөрөө гүйцэтгэгч мэдлийн байгууллага буюу мөрдөгч доороос гарч ирж байдаг. Ерөөсөө ингээд уялдаагүй бид хэд жоохон явчих гээд байгаа шүү. Энэ асуудлуудыг уг нь нэг одоо.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүн ээ түрүүний тэр өөрийн чинь санал би ингэж хэлмээр байна. Та тэр төр хувийн хэвшлээр барилгууд бариулах энэ боломж юу байна. Судлаад үзье Байнгын хорооны түвшинд гээд тэгж байна шүү дээ. Саналаа боловсруулаад өөрөө жоохон энэ байгууллагуудтайгаа хамтраад тэгээд нэг санал тал талаас асууж байгаад боловсруулаад надад танилцуулаадхаач.

Тэгэхээр би тэрийг бүүр дэмжиж байгаа. Тийм учраас харин ямар шийдэл байна? Тэрийг хэдүүлээ алтернатив өөр арга замыг бодохгүй бол нэг л сурснаараа ингээд л бариад л яг тэрүүгээрээ нүдээд л бүтэхгүй байхад л нүдээд байвал үр дүн гарахгүй байхгүй юу. Тэгье. Зүгээр харин би тэр төр хувийн хэвшлийн юун дээрээ бусад орны практик юм хараарай. Яагаад гэвэл шүүх арай онцгой шүү. Би тэгээд нөгөө төр хувийн хэвшлийн юугаар дараа нь яаж тэрийгээ нөгөө хувийн хэвшил нь мөнгөө гаргаж авах вэ гэдэг чинь аягүй том асуудал болчихож байгаа байхгүй юу.

Тэгэхээр тодорхой хугацаанд шүүх нь түрээсэлж байгаад төсөвтөө тэрийгээ суулгаж байгаад тэгээд нөгөөдүүл нь оруулсан хөрөнгөө гаргаад авахлаар шүүхдээ бүрэн шилждэг байх уу? Тэр хувилбаруудаа концессынхоо хувилбаруудыг сайн бодоорой.

Тулга гишүүн микрофоныг өгье.

Б.Тулга: Шөнийн мэнд хүргэе гэчих юу. Энэ цэвэр зээлийн дүн гээд танай дээр ганцхан тийм толгой орж ирээд байх юм. Энэ бичлэгийн алдаа юм уу аль эсвэл ийм зээлтэй холбоотой юм танай төсөв дээр байгаа юм уу, нэг.

Хоёрдугаарт нь мэдээж энэ гишүүд ч хэлж байна. Манай Байнгын хороон дээр бол энэ салбарын ялангуяа энэ танай шүүх, ШЕЗ-ийн төсвийг Их Хурлаар батлуулах ёстой. Гэхдээ ер нь бол энэ намар ирэх жилийн эдийн засгийн хүндрэлээс өгсүүлээд төсөв бол нэлээн амаргүй батлагдах ийм нөхцөлд бид нар ажиллаж байгаа гэдгийг та бүхэн сайн бодоорой. Тэр үүднээсээ энэ дотор нөгөө танай энэ 2025 он, 2026 он, 2027 онтой харьцуулсан энэ төсвийн чинь өсөлтүүдийг харахаар хэд хэдэн ийм том төсчихсөн тэгээд энэ ар талын хувиа яаж тавьчихсан юм бэ дээ? Би тэрнийг сайн ойлгохгүй байх юм. Их том том өсөлттэй ийм ангиллууд байна аа. Тэгэхээр энэ ангиллуудаа бид нарт маш ойлгомжтойгоор Их Хурал дээр төсвийг хэлэлцэх үеэр

батлах ийм үндэслэлүүдийг гаргаж өгөхгүй бол яг энэ танилцуулга дотроос бол тэр үндэслэлүүдийг чинь олж харж авч чадахгүй байна аа.

Тэгэхээр та бүхэн одоо бид нар та бүхний өмнөөс үүрэг хүлээж байна шүү дээ. Их Хурал дээр төсөв энийг энэ чигээр та бүхний зорьж байгааг батлуулах үүрэг хүлээж байгаа гэдэг утгаараа. Жишээлбэл ном хэвлэл бол 3900 хувиар өссөн гэж байгаа юм. Зүгээр 11 саяас 450 сая болсон байх жишээтэй. Тавилга 5.2 тэрбумаас 23 тэрбум болсон байна. Мэргэжлийн үйлчилгээний төлбөр 226 саяас 4.1 тэрбумаар өсөж орж ирсэн байх жишээтэй. Тэгээд л ингээд л 11 саяас 1.6 тэрбум гээд ингээд бүүр айхтар айхтар үсэрчихсэн юмнууд харагдаад байна л даа.

Тэгэхээр энэ дээр их тийм бодитой яалт ч үгүй ийм болсон юм. Ийм хөтөлбөр байгаа юм гэдэг энэ тооны цаад талд юмнуудыг маш ойлгомжтой тайлбарлаж өгөхгүй бол бас Сангийн яам тэгээд Их Хурал дээр танагдах магадлал их өндөртэй харагдаж байна гэдгийг та бүхэнд анхааруулъя.

Тэтгэвэрт гарах нэг удаагийн мөнгөн тэтгэмж дээр 2025, 2026, 2027 оныг харахаар ердөөсөө нугалаад нугалаад дабльдаад өсөөд явчихсан байх юм. Энэ тэтгэвэрт гарч байгаа хүний тоотойгоо шууд холбоотой байна уу, аль эсвэл цалингийн, тэтгэврийн хэмжээ нэмэгдсэн хасагдсантай холбоотой ийм өсөлт байна уу? Яагаад гэвэл 2027 онд бол 2025 оноос дахиад бараг 4 дахин өндөр өсөж орж ирж байна шүү дээ. 4 аравны 5 тэрбумаас 11.7 тэрбум, одоо 2025 онд 4 гэдэг их том өсөлтүүд харагдаад байна. Энэ ар талд нь яг хүн байна уу, аль эсвэл мөнгөний өсөлт тодорхой шийдвэр журам шийдвэртэй холбоотой байна уу гэдгийг анхаарч гаргаж ирээрэй.

Тэр хөрөнгийн зардал бас л ялгаагүй 170 саяас 54.9 тэрбум болж өсөх жишээтэй.

Тэгэхээр энэ бол их тийм сайн гаргаж ирэхгүй бол танагдах магадлал өндөртэй харагдаад байна шүү гэж та бүхэнд анхааруулъя. Ирэх онд шилжих 2027 онд шилжиж баригдаж дуусах барилгууд Хан-Уул.

Д.Цогтбаатар: Нэг минут нэмж өгье.

Б.Тулга: Хан-Уул дүүргээс бусад энэ 3 шилжих барилга чинь яг төсөв нь ингээд үлдсэн төсвөөрөө орж байгаа юу? Ингээд дуусаж байгаа юу гэсэн санаа өөрөөр хэлбэл 2027 ондоо дуусах уу? Шинэ барилгууд дээр бүгдийг нь 100 хувиар тавьчихсан байгаа юм байна шүү дээ.

Ийм асуултуудыг асууя аа.

Д.Цогтбаатар: Эрдэнэтулга дарга. Индрийн микрофон өгье. Түрүүний нөгөө юу байгаа нийт зарлага ба цэвэр зээлийн дүн гээд энэ маань санхүүгийн хэллэгээр ингэж бичигдсэн байгаа. Энэ дээр таны хэлдэг залруулга болон өссөн дүнгүүдийн талаар танилцуулж бас танд тодорхой зөв бичгээр хүргүүлье ээ.

Шүүхийн цогцолбор барилгын нийт төсөв үлдэх төсөв 38 тэрбумд тавигдсан энэ дуусчихна. Дүүргийн эрүү, иргэний хялбар ажиллагааны шүүх дээр яг 5.2 тэрбум төгрөг ингээд дэд бүтэцтэйгээ болон үлдэх өртөгтэй ингээд яваад мөн дуусна. Дорнод аймгийн шүүхийн барилга энэ жил 5 тэрбум тавигдсан. Ирэх жилийнх дээр

2027 дээр 8 тэрбумд тавигдвал мөн дуусна аа. Ингээд энэ барилгууд ингээд шилжих барилгуудад бүгд дуусаж явж байгаа.

Түрүүний тэр нөгөө тэтгэмжтэй холбоотой асуудал маань нөгөө тэтгэвэрт гарах шүүгчдийн тоо болон нөгөө цалин хөлсний өсөлттэй холбоотойгоор энэхүү дүнгүүд өсчихсөн байгаад байгаа. Зарим нөгөө тавилгын асуудлууд байгаа. Энэ маань өөрөө нөгөө нийт шинээр баригдаж байгаа шүүхүүд болон шүүх цогцолбор барилга, түүнтэй холбоотойгоор энэ тавилгуудын асуудлууд ингээд орж ирж байгаа учраас энэ онд болохоор ингээд 23 тэрбумаар ингэж орж ирж байгаа. Энэ маань өөрөө нийт нөгөө цогцолбор барилгын, нэгдсэн цогцолбор барилгатай холбоотой тэр барилгуудын 1 тавилгуудтай холбоотой орж ирсэн байгаа.

Жишээ нь ингээд цогцолбор байрлах нийтдээ ойролцоогоор 93 метр талбайтай, 45 хүний суудалтай, 59 танхим үүсэж байгаа. Энэтэй холбоотойгоор энэ зардлууд ингээд нэлээн өндөр дүнгээр орж ирж байгаа учраас ийм байгаа шүү.

Д.Цогтбаатар: Болсон уу? Тэгвэл ингээд ШЕЗ-ийн 2027 оны төсвийн төслийн ХЗБХ-оор хянагдсан.

ШЕЗ-ийн 2027 оны төсвийн төслийн ХЗБХ-оор хянагдсан хувилбарыг хасагдуулахгүйгээр Улсын төсөвт нэгтгүүлэхээр санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Манайхан санал хураалтдаа бэлдээрэй.

Саяын томъёоллыг дэмжье гэж санал хураалт явуулъя.

Санал хураалт.

62.5 хувиар санал дэмжигдлээ.

16.3.Шүүхийн сахилгын хорооны төсвийн төслийн талаар:

Шүүхийн сахилгын хорооны 2027 оны төсвийн төслийг хэлэлцье ээ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Түрүүн танилцуулчихсан юм байна.

Шүүхийн сахилгын хорооны 2027 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг Шүүхийн сахилгын хорооны дарга Энхтөр танилцуулна аа. Энхтөр дарга индэр дээр. Микрофон өгье.

С.Энхтөр: Байнгын хорооны дарга, гишүүдэд энэ оройн мэндийг дэвшүүлье ээ.

Шүүхийн сахилгын хороо бол 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн болон 2021 оны 1 сарын 15-ны өдрийн Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу бол байгуулагдсан. Шүүхийн сахилга хариуцлагатай холбоотой

сахилгын хэргийг хянан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлэх бүхий байгууллага байгуулагдсанаасаа хойш бол 4.6 жилийн хугацааг бол үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ хугацаанд бол 1800-аад төрийн байгууллага, эрх бүхий байгууллага, албан тушаалтан, иргэдийн өргөдөл мэдээллийг хүлээн авч бол нийтдээ 62 шүүгчид 82 сахилгын шийтгэлийг бол оногдуулж шийдвэрлэсэн байдаг юм. Ингээд өнгөрсөн 2025 оны хугацаанд бол Шүүхийн сахилгын хороо нь 326 өргөдөл мэдээллийг хүлээн авч бол хянан шийдвэрлэсэн. Энэ нь бол өнгөрсөн оныхыг бодох юм бол 16 хувиар бол өнгөрсөн жилийн хагас жилийн байдлаар бол 16 хувиар нэмэгдсэн байгаа. Өнгөрсөн оны ажлын өргөдөл мэдээллийг шалгах ажиллагаа 16 хувиар нэмэгдсэн байгаа.

Сахилгын хороо нь бол ингээд хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлээд бол өнөөдрийг хүртэл үйл ажиллагаагаа явуулах хугацаандаа нийтдээ бол Шүүхийн тухай хуульд заасны дагуу Сахилгын хороо өөрийнхөө ажлын алба, үйл ажиллагааны дүрэм, бүтэц, орон тоо, албан тушаалтнууд ажлын албаныхаа албан тушаалтнуудын цалинг бол хэлэлцэж баталдаг. Анх бол 64 орон тоотой бол нийт гишүүд 9 гишүүн, ингээд 55 ажлын албаны ажилтнуудтай орон тоогоо баталсан. Өнгөрсөн хугацаанд бол улс орны эдийн засгийн үйл ажиллагаа тэгээд төрийн албан хаагчдын цомхотголтой холбоотойгоор бол одоо Сахилгын хорооны 9 гишүүн болон ажлын албаны 41 албан хаагч нартай нийлээд 50 хүний бүрэлдэхүүнтэй бол үйл ажиллагаа явуулж байна. Ингээд 50 орон тоотой. Тэгээд манайх бол Улсын хэмжээнд бол дангаараа ганц байгууллага үйл ажиллагаа явуулдаг ямар нэгэн салбар бол төлөөлөгчийн газар бол байдаггүй. Ингээд Улсын хэмжээнд бол өргөдөл мэдээллийг бол өөрсдийн болон цалин хөлс томилолтын зардлын хүрээнд ингээд үндсэн зайлшгүй урсгал зардалтай холбоотойгоор гарах зардлын хүрээнд бол үйл ажиллагаагаа явуулсаар өнөөдөр ирсэн.

Монгол Улсын Дээд шүүхийн хуучин Чингэлтэй дүүрэгт байрладаг байрны зүүн талын 2100м² талбайг бол өнгөрсөн оны 12 сард бол албан ёсоор эзэмшлийг бол шилжүүлж гэрчилгээг нь авснаар бол ингээд өөрийн байртай үйл ажиллагаа явуулж байгаа. Ингээд 2 мянга, анх өөрсдийнхөө ажил албан хаагчдын бүтэц орон тоо цалин хөлсийг баталснаас хойшоо бол нэмэгдүүлээгүй байсан. Энэ жилээс бол мөн энэ бусад төрийн албан хаагч нартай нийцүүлж бол цалин хөлсийг нэмэгдүүлсэн.

Энийг бол 2027 оны 1 сараас эхэлж хэрэгжүүлэхээр болсонтой холбогдуулан бол зайлшгүй гарах зардал бол үндсэндээ 3 төрөлд бол ангилагдаж хуваагдаж байгаа. Цалин хөлс НДШ-ийн одоо байгаа 55 орон тоогоор тэгэхдээ 50 орон тоо явж байгаа. 55-аар бодоход бол 5.3 тэрбум төгрөгийн цалин НДШ-ийн ийм зардлыг бол төсвийн төслийг бол баталгаажуулсан. Мөн ба бараа ажил үйлчилгээний зайлшгүй зардал буюу бензин томилолт ингээд урсгал бусад зардал бол 1.3 тэрбум буюу төсвийн бол 15 хувийг нь эзэлж байна. Бусад урсгал зардал дээр бол манайх анх байгуулагдсан байгууллага. Сахилгын хорооны гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 2027 онд дуусахтай холбоотойгоор бол шүүгч бус 4 гишүүн бол тэтгэвэрт суух насны хэмжээнд хүрсэн учраас нэг удаагийн тэтгэмж оногдуулж байгаа. Энэ нь бол 900 гаруй тэрбум нэг албан хаагчид ингээд 5 хүний тэтгэмж, 900 тэрбум төгрөг. Тэгээд нийгмийн хариуцлагын хүрээнд бол дотоод журам 900 сая төгрөг тэгээд нийгмийн задаргаа нь оччихсон байгаа. Та бүхэнд хүргэгдчихсэн байгаа. Тэгээд нийгмийн хариуцлагын хүрээнд бол байгууллагын дотоод журам эд нараар нэг удаагийн буцалтгүй тусламж дэмжлэг гэдэг дээр 98 сая төгрөгийн ийм зардал. Тэгээд эхнээсээ ингээд байгууллагын албан хаагч нар тэтгэвэрт сууж байгаа учраас

ахмадын сангийн зардал гээд үндсэндээ нэг цалингийн сангийн 2 хувьтай тооцоод нэг нийтдээ нийлээд бас нийт төсвийн 15 хувь буюу 1.1 тэрбум төгрөг нь бол энэ бусад урсгалд шилжүүлэх зардал дээр орж ирээд ингээд 7.7 тэрбум төгрөгийн хүрээнд бол 2027 оны төсвийн төслийг боловсруулж та бүхэнд хүргүүлсэн байгаа. Тэгээд энэхүү төслийг дэмжиж өгнө үү гэж та бүхнээс хүсье ээ.

Тэгээд нэмэлт асуулт байвал нарийвчлан хариулж болно оо.

Д.Цогтбаатар: Энхтөр даргад баярлалаа.

Улсын Их Хурлын Тамгын газраас Шүүхийн сахилгын хорооны 2027 оны төсвийн төсөлд хийсэн дүн шинжилгээний талаарх танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн байгаа. Шүүхийн сахилгын хорооны 2027 оны төсвийн төслийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардалтай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгье. Байхгүй байна. Шүүхийн сахилгын хорооны 2027 оны төсвийн төслийн талаар асуух асуулт алга байна. Ингэхээр Шүүхийн сахилгын хорооны 2027 оны төсвийн төслийн ХЗБХ-оор хянагдсан хувилбарыг хасагдуулахгүйгээр Улсын төсөвт нэгтгүүлэхээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя

Манайхан санал хураалтдаа бэлдээрэй. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

62.5 хувиар санал дэмжигдлээ. Манай Байнгын хорооны гишүүд Төсвийн байнгын хороонд давхар сууж байгаа. Одоо энэ саналаа харин дэмжинэ шүү дээ. Ингээд 62.5 хувиар санал дэмжигдлээ.

16.4.Хүний эрхийн Үндэсний комиссын төсвийн төслийн талаар:

ХЭҮК-ын 2027 оны төсвийн төслийг хэлэлцье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг түрүүн танилцуулсан байгаа. ХЭҮК-ын 2027 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг ХЭҮК-ын дарга Дугарын Сүнжид танилцуулна аа. Сүнжид даргын микрофоныг өгье. Индрийн микрофон.

Д.Сүнжид: Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга, Хууль зүйн байнгын хорооны гишүүд ээ,

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын ХЭҮК-ын 2027 оны төсвийн төслийг НҮБ-ын Ерөнхий Ассемблейгаас баталсан Парисын зарчимд нийцүүлэн боловсруулж 2026 оны 6 дугаар сарын 5-ны өдөр Улсын Их Хурлын даргад хүргүүлээ. Монгол Улсын ХЭҮК-ын 2027 оны төсвийн төсөл нь нийтдээ 41.6 тэрбум төгрөгөөр төсөвлөсөн. Энэнээс хөрөнгийн зардал 25.1 тэрбум төгрөг, 3 дахь жилдээ байрны зардлыг бид нар оруулж байна аа. Өмнөх 2 жил ХЗБХ-оор дэмжигдсэн. Тэгэхдээ цаашаа дэмжигдээгүй ээ чуулганаас. Тэр зардлаа эргэж дахин оруулж ирсэн. Урсгал зардлын хувьд 16.5 тэрбум төгрөг байхаар тооцлоо. Энэ нь 2026 оны төсвөөс 6 тэрбумаас нэмэгдүүлж байгаа ийм зардал юм аа.

Энэний 2.2 тэрбум төгрөг нь цалинтай холбоотой. Бид нар сая 9 хувийн орон тооны цомхотголтой холбоотой 8 орон тоо хассан юм. Түүнээсээ 6-г нь эргэж нэмэгдүүлэе гэдэг санал өгөөд энэний зардал нь 2.2 тэрбум төгрөг болохоор тооцоо гарч байна аа. Ингээд Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 31 дэх хэсэгт заасан шаардлагын дагуу эдийн засгийн ийм 2 ангиллаар хөтөлбөр, арга хэмжээ, хүрэх үр дүнгийн хамт 2027 оны төсвийн төслийг боловсрууллаа. Энэ төсвийн төсөл нь алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 6 зорилго зорилттой, хөгжлийн зорилтот хөтөлбөрийн 10 зорилттой. Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн нэг зорилго зорилттой Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 зорилтуудтай тус тус хуваарилж байгаа.

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хууль Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, Хүүхдийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль гээд ингээд шинэчилсэн найруулгын нийтдээ 9 хуулиар 20 чиг үүргийг ХЭҮК хүлээдэг. Энэ дундаас онцлох 3 механизм байдаг аа.

Энэний 1 дүгээрт нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан гишүүнд туслах чиг үүрэг бүхий орон тооны нэгж ажиллах учиртай. Энэ нь комиссын Тамгын газарт харьяалагддаг.

Хоёрт нь Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1-д энэ нь комиссын дэргэд хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хороо ажиллана аа. Мөн гишүүнд туслах чиг үүрэг бүхий орон тооны нэгж ажиллана аа. Бүтэц орон тоог комисс батална гэж заасан байдаг.

Гуравт нь ХЭҮК-ын тухай хуулийн 29.2-т Тамгын газар нь комиссын чиг үүргийг дагнан хэрэгжүүлэх газар хэлтэстэй байх бөгөөд хүний хувийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, хамгаалах үйл ажиллагаанд хяналт тавих тусдаа нэгжтэй байна гэж тус тус заасны дагуу 2027 оны төсөвт Комиссын албан албан хаагчдын орон тоо, цалингийн сан, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардлыг тооцож тусгалаа.

Хууль зүйн байнгын хорооны эрхэм гишүүдээс ХЭҮК-ын 2027 оны төсвийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Асуулт байвал хариулъя.

Д.Цогтбаатар: Сүнжид даргад баярлалаа.

Улсын Их Хурлын Тамгын газраас ХЭҮК-ын 2027 оны төсвийн төсөлд хийсэн дүн шинжилгээний талаарх танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн байгаа. ХЭҮК-ын 2027 оны төсвийн төслийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардалтай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү.

Д.Сүнжид: Одонтуяа гишүүн. Нара гишүүнээр тасаллаа. Цогтбаатар гишүүний микрофоныг өгье.

Да.Цогтбаатар: Үдшийн мэнд хүргэе.

ХЭҮК-ын төсөв яах вэ бид нар энэ ХЗБХ-н дээр сэтгэлд өөг гэдэг шиг ингээд батлаад л явуулчих байх. Тэгээд нөгөө улсын төсөв чинь өөрөө яг өнөөдрийн байдлаар бодит байдал дээрээ орлого маань тасарчихсан, намрын чуулганаар сюрприз бариад Улсын төсвийг 2026 оны Улсын төсвийн тодотголтой цуг өргөн барина. Тэгээд цуг өргөн барихад юу болох вэ гэхээр зардлаа таная л гэж орж ирнэ. Нэмэлт хөрөнгө оруулалтууд нэг ч байхгүй гэдэг байдлаар яригдаад явж байгаа. Тэгээд 2027 он дээр одоо яг энэ чигээрээ нэг ийм та хэдийн хүслээр болдог бол 41 тэрбум төгрөгөөр баталчих л байх. Даанч хүслээр болохгүй байх. Тэгэхдээ энэ дотроос та хэдийн үйл ажиллагааг сайжруулах талаас нэг хэдэн зардал тавигдчихсан байгааг нэг тодруулж асуух гэсэн юм. Энэ гадаад томилолтын зардлыг жишээлэхэд та хэд нэлээн ахиу дүнгээр нэмж тавьсан байна. Энэ дээр юу өөрчлөгдөж гарч чадах вэ?

Бусад урсгал шилжүүлэг гэдэг дээр бас нэлээдгүй дүнгээр өссөн байгаа. Энэ дээр юу өөрчлөгдөж чадах вэ? Тэгээд тэр хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал гэдэг чинь 146 сая төгрөг байсан. Одоо бол тэрбум 400 болно оо гэж байгаа юм. Тэгээд энэ доторх зардлуудыг нь ингээд харахаар нэлээн олон төрлийн зардлуудаа та бүхэн бүүр байхгүй байсныг нь жишээ нь шинээр нэмээд тавьчихсан байгаа юм. Тэгээд ер нь ХЗБХ та хэдийн ажлыг нэлээн сайн дэмжиж явдаг. Гэтэл та хэд өөрсдөө байж боломгүй алдаа гаргадаг аа. Хамгийн сүүлийн жишээ сая 1 сэтгүүлчтэй холбоотой хувь хүний үзэмжээр даргын цүнх баригчийн талд хамаг шийдвэрийг нь гаргаж өгөөд явуулчихсан. Дарга нар нь тэгээд бараг нэгнээсээ холдуулаад би тэр үед байсан байгаагүй, би мэдэхгүй, чадахгүй гээд асуудал яриад сууж байдаг ийм хариуцлагагүй байдлаар битгий ажиллаач гэж та бүхнээс хүсэх гэсэн юм. Тэгээд энэ саяын 3 зардалтай холбоотой танилцуулгыг та дэлгэрэнгүй хийх юм бол ядахдаа бид нар одоо 20 тэрбумаар байшин барьж өгч чадна гэж худлаа ярихгүй ч гэсэн дээ бусад энэ урсгал зардалтай холбоотой асуудлуудыг чинь шийдэж өгөхийн төлөө явж болох байх. Тэгэхдээ энэ барилгатай холбоотой асуудал яах вэ зүгээр одоо байгаа байрандаа байж байхад үйл ажиллагаа яг шинэ байранд очсоноос юугаараа дордох гээд байгаа вэ гэдгийг илүү дэлгэрэнгүй ярихгүй бол заавал байртай байх ёстой гээд нэг баян айлын хүүхэд шиг юм яриад яваад байвал бид нар улсын төсөв даахгүй байх л гэдгийг та зөв тайлбарлах ёстой байх л гэдгийг хэлэх гэсэн юм.

Д.Цогтбаатар: Индрийн микрофон өгье.

Д.Сүнжид: Цогтбаатар гишүүний асуултад хариулья.

Эхний урсгал зардал ер нь яаж өсөв өө гэж өмнө нь энэ 2026 оны төсөвлөсөн зардал бол 13.5 тэрбум. Тэгээд тодотгол яваад 10.5 тэрбум болсон ингэнгүүт томилолттой холбоотой бид нар 21 аймагт 1 референт л ажилладаг. Тийм учраас бид нар орон нутагт болон гадаад томилолттой холбоотой энэ томилолтын зардлаа гүйцэт тавьдаг нь 1 дүгээрт орон нутгаар явна гэж тооцож байгаа юм. Аймгуудаар явна бүсчилнэ мөн эсвэл аймгуудаар явах дутуу. Энэ жил бид нар 12 аймгаар явсан. Одоогийн байдлаар 6 сарын байдлаар гадаад, дотоод бүх томилолт дуусчихсан хүрэхгүй байгаад байгаа учраас энэ дээрээ тулгуурлаад ирэх жил дээр энэ явах томилолтуудыг тусгаж өгсөн байгаа юм. Тэгээд энэ дээр ахиад нэг онцлог байгаа. Сая хэлсэн Хүний эрх хамгаалагчийн тухай хууль дээр тусдаа нэгжтэй байна гээд тусдаа чиг үүрэгтэй. Энэ дээр тусдаа зардал хэрэгтэй болдог оо. Эрүү шүүлтээс

урьдчилан сэргийлэх үйл ажиллагаан дээр тусдаа зардал хэрэгтэй болдог. Ялангуяа таны онцолж асуусан нөгөө 2 дахь зардал байна. 1 тэрбум дээр тэр сургалт үйлдвэрлэл дээр энэний 30 хувь нь сая ХЭҮК-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж байгаатай холбоотой сургалтын 30 хувь нь зөвхөн дангаараа эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны нэгжээс хэрэгжүүлнэ гэж тооцож тавьсан ийм дүн байгаад байгаа юм. Тэгээд хүний хувийн мэдээллийг хамгаалах дээр бас нөгөө хуульдаа заачихсан чиг үүрэг нь давхар явдаг.

Тэгэхээр энэ 3 чиг үүрэг дээрх сургалт нь явна гомдлоо шийдэх нь явна, судалгаа нь явна, зөвлөгөө нь явна. Энэ бүхэнтэй холбоотой энэ зардлууд нэмж орж ирж байгаа юм. Байрны тухайд нэг ийм асуудал байна. ЗГ-ын 11 дүгээр байранд бид нар бид нарыг анх бүрэн эрхээ эхэлж байгаад ер нь энэ байгууллага анх 25 жилийн өмнө байгуулагдаад түрээсэлдэг тэндээ байж байя. Эхлээд ордонд байсан юм байна лээ. Тэгээд нөгөө ЗГ-ын 11 дүгээр байранд, тэндээс Эдийн засаг, хөгжлийн яам бид нар өөрсдөө бүтнээрээ энд 4 давхар баймаар байна гээд ЗГ-ын 12 дугаар байр руу манайх шилжсэн түрээс өгөөд л явж байгаа.

Энэ 25 жилийн хугацаанд ХЭҮК өөрийн байртай байсан түүх байхгүй. Байртай болно оо гээд энэ ЗГ-ын 12 дугаар байр руу шилжихдээ ЗГ-аас нэг газар өгсөн, ногоон нуурын тийшээ. Энэ дээр ер нь байраа барьж авбал цаашдаа иргэний нийгмийн байгууллагуудыг орох гарах номын сан бий болгох, түншлэлийг хөгжүүлэх иргэдийн орон зайг бий болох ийм боломжтой юм гэдэг утгаараа. Тэгээд энэ газар нь солигдсон, траст орсон гээд нэг ийм үйл явдал болсоор байгаад яах вэ одоо газрын асуудлаа шийдүүлчихсэн байгаа. Байрны асуудал бид ярьж л байгаа төсөөллийг ингээд явж байгаа ийм л юм. Тэгэхээр түрээсийг бид нар төлөөд л явж байгаа ийм одоо бол ЗГ-ын 12 дугаар байранд мянган м2 дээр түрээс төлөөд явж байгаа ийм дүр зурагтай байгаа гэдгийг тайлбарлая.

Д.Цогтбаатар: Одонтуяа гишүүний микрофоныг өгье.

С.Одонтуяа: Би нэг ийм санал хэлэх гэсэн юм энэ төсөв 5 дугаар сарын 15-аар билүү ингээд өргөн барьчихсан. Гэтэл миний энэ 37 гишүүний хамт өргөн барьсан ХЭҮК-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдаагүй байсан учраас тэрэнтэй холбоотой төсөв энэ 2027 оны төсөвт суугаагүй байсан юм. Тэгэхээр одоо бид нар сая төсвийг нь биш энэ хуулийг батлаад энэ 7 хоногт эцсийн хэлэлцүүлэг нь орчихно. Тэгээд хууль батлах үед маш олон гишүүд хэлсэн. Энэ чинь тэгээд төсөв мөнгийг нь батлаарай. Тэгэхгүй бол тэгээд сүүлд нь 2-ын хооронд ингээд юм хийх вий гээд. Тэгэхээр би энэ дээр Байнгын хороон даргаа танд нэг албан бичиг биччихсэн байгаа. Түрүүн бас Хурлын даргад хэлсэн. Юу вэ гэхээр энэ хууль батлагдсантай холбогдуулж 2027 оны төсөвт энэ эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны төсвийг тодорхой нэмж өгөөч гээд. Тэгээд энэ ингээд нэлээн л нарийн тооцоо гаргаж үзлээ.

Ер нь ХЭҮК-т хуваарилагдаж байгаа бүх төсвүүдийг 2022, 2025 онд хуваарилсан төсвүүдийг дундажлаад үзэхээр 2-6 хувь нь энэ эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанд ерөнхийдөө ингээд хуваарилагдаж байгаа. 2025 онд 7 хүн байсан бол одоо 2026 онд нэг 9 хүн ч гэдэг юм уу. 7 хүн байсан.

Тэгэхээр бид энэ нэг их зарлаад л Их Хурал энийг анхаарч байна хүний амь нас бараг эрсдэхгүй болно гээд ингэж баахан зарлачхаад хууль батлуулчхаад ямар

ч төсөвгүй бол энэ хүмүүс чинь хөдөө ч явж чадахгүй, сургалтынхаа гарын авлагыг ч бэлдэж чадахгүй нөгөө цэргийн ангиуд дээр хийх хууль маань хэрэгжихгүй болох гээд байгаа юм аа.

Тэгэхээр Байнгын хорооны дарга болон манай гишүүд энийг ойлгоод энэ 2027 оны төсөвт нь энэ зардлын тодорхойг нэмж тусгаж өгөөч гэдгийг би хэлэх гэсэн юм аа санал.

Д.Цогтбаатар: Одонтуяа гишүүнээс энэ албан тоот ирсэн байгаа. 2026 оны 6 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хурал 037507 гэсэн ийм тоот ирсэн байгаа. Тэгээд энэ Одонтуяа гишүүний энэ чиглэлийн ер нь санаачилгыг би өөрөө эхнээсээ дэмжээд явж байсан. Тэгээд мэдээжийн хэрэг энэ ажил хийхээр нэг ажил хийхэд дагаад л дараагийн асуудал гарч байдаг. Энэ яах аргагүй өөрөө ингээд л аливаа хийж байгаа ажлын логик. Тэгээд нэгэнт бид нар энэ ажлыг эхлүүлсэн дараа нь үр дүнг нь гаргах л ёстой гаргахгүй юм бол зүгээр 2-ын хооронд яг Одонтуяа гишүүний хэлж байгаагаар зүгээр хэлбэр төдий хийгээд нэг олон нийтэд ажил хийж байгаа харагдаад тэгээд үр дүн байхгүй бол тийм ажил хийгээд ч хэрэггүй.

Тэгэхээр энийг дагаад одоо нээрээ тэр цэргийн ангиуд эд нар руу явахад төсөвгүй бол яаж явж угаасаа энэ ажлуудыг чинь хэрэгжүүлэх вэ дээ. Тэгэхээр энэ нөгөө төсөв орж ирсний дараа энэ асуудлууд нь яах аргагүй тодорч гарч ирж байгаа болохоор энийг цаашдаа тусгаж өгөөд энийг төсөв боловсруулахдаа холбогдох байгууллагууд нь энийг төсөвтөө тусгаад явах ёстой. Сүнжид дарга энэ дээр өөрөө анхаараад энийг оруулах тал дээр ХЗБХ-оосоо дэмжлэгээ аваад яваарай. Энийг манайх протоколдоо тусгаж өгөөд энийг ингээд дэмжээд оруулах тал дээр дэмжээд ажиллаад явах ёстой гэж протоколд тэмдэглүүлж үлдээмээр байна аа.

Нара гишүүний микрофоныг өгье.

М.Нарантуяа-Нара: Шөнийн 11 цаг 15 минут болж байна. Оройн мэнд хүргэе шөнийн мэнд хүргэе. ХЭҮК-ын 2027 оны төсвийн төслийн санал 2026 онд батлагдсан төсвөөс 31000000166.9 сая төгрөгөөр буюу 296.6 хувиар нэмэгдүүлж орж ирж байгаа юм байна. Би энэн дээр гайхаж байна. Би ер нь энэ ХЭҮК гэдэг байгууллага яг хүний эрхийг хангах хамгаалахад чиглэсэн байгууллага юм уу эс үгүй бол нэг баахан гоё том том зузаан боть шиг ийм том том ном эвлүүлээд тэ рапорт бөглөөд хүний эрхийн зөрчлүүдийг зүгээр бүртгээд тэгээд хэрэгжилтийг нь болохоор ялгамжтай хандаад хэнд вэ гэдгээс ялгамжтай хандаад байж байдаг байгууллага юм уу гайхаж байна.

Миний гарт 2016, 2017 оны энэ комиссын 16 дахь илтгэл байна. Энд маш ноцтой асуудлуудыг тэмдэглээд эндээс үүдээд энэ мэргэжлийн Байнгын хорооны тогтоол хүртэл гарчихсан байхад хэрэгжилт байхгүй. Энэ ХЭҮК энэ өмнөх удирдлагынхаа энэ гаргасан энэ зөвлөмжүүдийг биелүүлэх хэрэгжүүлэх ажил хамаардаг уу, хамаардаггүй юм уу? Энэ 2017 оны энэ хүний эрхийн энэ ном дээр чинь 50 дугаар хуудсан дээр нь Баян-Өлгий аймгийн уугуул тувачууд урианхайчуудын эрхийн асуудлыг ноцтой тэмдэглээд хүний эрхийн энэ 16 дахь илтгэл дээр тэмдэглэчхээд байхад одоо 9 жилийн дараа бид нар мөн л ийм ноцтой асуудалтай сууж байна. Танай байгууллагад ер нь Баян-Өлгий аймгийн бид нарын нэрлэснээр казахчуудыг үндэсний цөөнх гэдэг. Тэгвэл үндэсний цөөнх дотор амьдарч байгаа бусад цөөнхийн асуудлаар гомдол ирж байсан, түүнийг хэрэгжүүлсэн, хөөсөн, хангасан, хамгаалсан тийм протоколууд байна уу? Би бол

итгэхгүй байна. Энэ хараа ном хэвлэл гэсэн чинь 173 сая төгрөг. Та нар мянган ийм том том гайхамшигтай сайхан ном хэвлээд яадаг юм. Нэгэнт хүний эрх хангагдаж хамгаалагдахгүй байхад та нар хэдэн мянган гайхамшигтай ном боть хэвлээд ч хий дэмий татвар төлөгчдийн мөнгө урсаж байгаа. Мянган сайхан ордон байгуулаад ч хүний эрх ингэж зөрчигдөж хүн уугуул төрсөн өлгий нутгаасаа хавчигдан шахагдаж олгой авах нэрийдлээр үрийн сувгийг нь боож ийм үйлчилгээ үзүүлж байхад та нар тэр алс хязгаарт хүртэл тулж очиж ажиллаж, хүний эрхийг хангаж, хамгаалж чадахгүй байж та нар мянган.

Д.Цогтбаатар: Нэг минут нэмж өгье.

М.Нарантуяа-Нара: Үнэхээр учир дутагдалтай. Тэгээд л нэг л гадаад явсан, нэг л гадаад томилолттой. Бөөн зардал урсаад л байдаг. Одоо 25 тэрбумаар ордон бариулна гэнэ ээ. Би энийг эсэргүүцэж байна. Угаасаа энэ Улсын Их Хурал дээр очоод угаасаа унах байх. Ордон барьж өгөөд та нар сайхан албан тасалгаанд суухаас өөр ер нь юу бодож байгаа юм? Юм хэлэхээр үргэлж дандаа төсөв хүрэлцэхгүй, хүн хүч хүрэлцэхгүй, хүмүүсээ яаж чадавхжуулах юм, яаж алслагдсан орхигдсон цэгүүдэд хүрч ажиллах юм гэж бодохоосоо илүү дандаа өөрсдийнхөө тав тухыг боддог. Ийм сэтгэл зүрхтэй хүмүүс ХЭҮК-ыг ахалж байгаа цагт энэ хэдэн 100 тэрбумыг урсгаад ч энэ хэзээ ч үр дүнд хүрэхгүй. Урьд урьдынхаа өөрсдийнхөө гаргасан энэ мундаг илтгэлүүдээ хэрэгжүүлэхгүй юм жил болгон ийм мундаг илтгэлүүдээр бид нар яадаг юм?

Д.Цогтбаатар: Индрийн микрофон. Сүнжид дарга хариулъя.

Д.Сүнжид: Зарим нь санал, зарим нь асуулт гэж ойлголоо. Асуултад нь хариулъя. Энэ өмнө нь хэлсэн нөгөө байртай холбоотой асуудал өмнө нь 2 жил орсон л юм. Ордон байгуулах тухай асуудал ер нь биш. Энэ байгууллага өөртөө ер нь байртай байгаагүй. 2 дахь асуулт нь хэзээнээс энэ Их Хурлын тогтоолыг хэрэгжилтийг нь эргэж тайлагнадаг болсон бэ гэхээр 2020 оноос хойш. 2020 оны ХЭҮК-ын тухай хуульд шинэчилсэн найруулга орсон. Тэр цагаас хойш ХЗБХ хэлэлцээд Байнгын хорооны тогтоол гардаг байсан бол Улсын Их Хурлын чуулганаар ордог чинь сүүлийн 5 жилийн хугацаа. Нийтдээ бид нар нэг 20 чиг үүрэг хүлээж байна аа. Энэ дээр олон асуудал байна. Олон Улсын гэрээ конвенцод санал өгч байна. Хууль болгонд бид нар хүний эрх эрх чөлөөг зөрчиж байгаа эсэх дээр санал өгч байна. Гомдол хүлээж авч байна. 25 жилийн хугацаанд комиссоос хүлээж авсан гомдол шийдвэрлэсэн байдлыг харах юм бол сүүлийн 5 жил бид нар 40 хувийг хүлээж авсан. Эхний 20 жил бид нар 60-ыг авсан. Жилд ирэх тусам энэ гомдлын тоо болон бид нарын ажиллаж байгаа байдал өсөж байгаа. Аймаг болгонд нэг референт ажилладаг гишүүнээ, нэг.

Тэгээд үндэсний байгууллага гэж бид явдаг аа. Аймаг болгонд нэг референт ажилладаг. Нэг референт нь нөгөө бүх сумдууддаа хүрэх ёстой, хүний эрхийн боловсрол, гомдол, зөвлөгөө судалгаа энэ бүх ажлаа дагнан хариуцаад явж байдаг ийм онцлогтой ийм байгууллага.

Нэмэх нь хүний эрхийг хангах тогтолцоон дээр энэ бол одоо нөгөө Үндсэн Үндсэн хууль дээрээ ч байгаа. Энэ дээр ганц байгууллага хариуцахгүй Улсын Их Хурал, ҮХЦ, Шүүх, ЗГ-ын бүх байгууллагууд, прокурорууд, мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг байгууллагууд, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага гээд төрийн болон төрийн бус байгууллагууд хамтдаа

байж байж хүний эрхийг хангахын тогтолцоо өөрөө бүрэн болдог. Энийг нь үндсэн хуулийн 19.1 дээр ч гэсэндээ төр гэдэг нэг нийтлэг үгээр бид нар заасан байдаг аа. Таны тэр санаа зовж байгаа асуудал үндсэндээ зөв. Тиймээ бид нар ч гэсэн санаа зовж байна. Тэгэхдээ бид нар энэ дээр эв нэгдлийг хангах үүрэгтэй. Бид нар энийг Үндсэн хууль өөрөө хэлсэн. Үндсэн хууль нь өөрөө тэгш шударгаар энэ боломжийг нь олгоод зэрэгцэн найрсгаар хамтран ажиллах амьдрах учиртай. Одоо тэгээд энэ Үндсэн хуулийнхаа зарчмыг л бид нар бариад явж байна аа.

Тэгэхээр 2018 онд тэр нөгөө Хууль зүйн байнгын хорооны тогтоол байгаа. ХЗБХ-ных. Тэрний хэрэгжилтийг нь эргэж нөгөө 2018 онд дүгнэдэг байгаагүй юм байна лээ. Тэгээд 2020 оноос эхлээд одоо бол жил болгон 20 оноос эхлүүлээд ер нь Их Хурлын тогтоолын хэрэгжилт ямар байгаа юм? Хувь нь хэд юм. Ямар асуудал ЗГ-ын түвшинд л үүрэг өгч байгаа шүү дээ Улсын Их Хурлын тогтоол бол энэ илрүүлээд гаргаад судлаад тавьчихсан тогтолцооны институцийн, механизмын энэ асуудал дээр ямар арга хэмжээ авах юм бэ гэдгийг Засгийн газар дээр үүрэг болгочихсон байгаа.

Тэгээд тэрний хэрэгжилтийг нь Засгийн газар болон Улсын Их Хурлаас манайхаас энийг нь хянаад явж байгаа.

Д.Цогтбаатар: Нэг минут нэмж өгье Нара гишүүнд.

М.Нарантуяа-Нара: Би танаас Урианхайчууд, Тувачууд, Баян-Өлгийд амьдарч байгаа цөөнх доторх цөөнхийн хүний эрхийн зөрчлийг хэлэлцсэн протокол шийдвэрлэсэн тийм протоколыг асуусан 1 дүгээрт.

Хоёрдугаарт эв эе эв нэгдлийг сахина гээд бусад үйлдэж байгаад нь нүдээ аниад, хохирч байгааг нь авч хэлэлцэхгүй байх тухай асуудал эв нэгдлийн тухай ойлголт биш. Таныхаар бол яах юм? Үндэсний цөөнх гээд эв нэгдэл гэнгүүтээ тэр цөөнх дотор дээрэлхүүлж байгаа нутаг усаа орхиод гарахаас өөр аргагүй байгаа үр хүүхдээрээ үргэлж заналхийлүүлж, айлгаж, айдас дарамтад амьдарч байгаа хүмүүс нутгаа орхихоос өөр аргагүй болоод явж байгаа асуудлыг нүдээ аниад байж байх ёстой юм уу. Тэр хүмүүсийн асуудлыг хэн хэлэлцэх юм? Хүний эрхийн Комисс тэрийг хэлэлцэхгүй юм уу. Авч хэлэлцэхгүй юм уу?

Дээрээс нь та энэ барилга байшин байгууламж барьснаар хүний эрхийн зөрчил хэдэн хувиар буурна гэж үзэж байгаа юм.

Д.Цогтбаатар: Индрийн микрофон.

Д.Сүнжид: Хүмүүс энэ зорилтот бүлгүүдийн асуудал тийм амархан байсан бол туйлын утгаар нь шийдэж болно шүү дээ. Тийм биш болоод л бид нар ингээд хууль тогтоомжийг ч гэсэндээ боловсруулахдаа бүрдүүлбэр хэсэгт нь аль зорилтот бүлэгт ямар байдлаар эерэг сөрөг нөлөө үзүүлэх юм бэ? Үүнийгээ судлаад дүгнээд гарах үр дагаврыг нь тооцооч гээд Улсын Их Хурлын тэр юун дээр хуулийн төслийн бүрдүүлбэрийг хүртэл шаардаж байгаа юм.

Тэгэхээр ийм асуудлыг журмынх нь дагуу шийдвэрлэх учиртай. Асуудал байвал тэрийг шийдвэрлэх ёстой. Тэгээд зарчим журмын дагуу шийдвэрлэнэ. Тэр барилга барьснаар гомдол багасна ч гэж юу байх вэ дээ. Одоо бид нар хүний эрхийн зөрчлүүдийн нэг 5 шалтгаан л ярьдаг шүү дээ.

Нэгдүгээрт хууль тогтоомж өөрөө сайжрах ёстой. Хоорондоо уялдаа холбоогүй, хийдэлтэй, давхардалтай олон хуулиуд байна.

Хоёрдугаарт институт хоорондын асуудал үнэхээр хоорондоо болохгүй байна, хаягдаж байна.

Гуравт нь мэдээж санхүүгийн асуудал ярьдаг, нөөцийн асуудал ярьдаг, 4-д нь төрийн албан хаагч өөрийнх нь хандлага, мэдлэг, ур чадвар, дадалтай холбоотой асуудлыг ярьдаг.

Д.Цогтбаатар: Индрийн микрофоныг гүйцээгээд өгье.

Д.Сүнжид: Тэгэхээр энэ саяын хэлээд байгаа тэр 4 шалтгаан чинь ингээд бүгдээрээ хоорондоо иж бүрэн цогцоор нь хүний эрхийн асуудал дээр бид нар энийг хамтад нь шийдэхгүйгээр нэг асуудлыг шийдээд тэгээд энэ нь туйлын сайхан юм уу, эерэг юм уу, сөрөг үр дагавар гэдэг тийм ойлголт байхгүй шүү дээ, өрөөсгөл. Хариулж дууслаа.

Д.Цогтбаатар: Гүйцээгээд хариулаад хэлээрэй.

Д.Сүнжид: Одонтуяа гишүүн нөгөө эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгж дээр та буруу мэдээлэлтэй байна. 10 хувь, хүний нөөц 10 хувь, төсөв 10 хувь байгаа. Нөгөө 2 хүний хувийн мэдээлэл хамгаалах болон хүний эрх хамгаалагч гэж адилхан хуулиар тодорхойлогдсон 2 тусдаа механизм дээр харин бага байгаад байгаа юм.

Гурван хувиас хэтрэхгүй энэ тэр байгаад байгаа хүний нөөц нь ч гэсэндээ арай бага 5, 6 хүнтэй. Нөгөөдөх нь 8 хүнтэй ч гэдэг юм уу нэг ийм байдалтай байгаа шүү.

Д.Цогтбаатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Би нэг ганц 2 зүйл хэлчихье гэж бодож байна. Би асуулт байхгүй учраас Сүнжид дарга суу. Аан энэ дээр Хүний эрхийн Комисс бид нарт нэг хүний эрхийн комисстой учраас ийм эмзэг асуудлаар ч гэсэн энэ асуудал ингэж гарч ирж яригдаагүй байхад тэр цөөнх дотор байгаа цөөнхийн асуудал чинь байгаа шүү гээд харин баримт бичиг дээрээ тусгачихсан байгаа юм. Шийдэл яах аргагүй эмзэг асуудал учраас хуулийн хүрээнд тэгээд бодлоготойгоор эвтэйгээр ингэж хандах нь зөв.

Та нар саяын энэ гишүүний хэлж байгаа нэг юман дээр энийгээ гаргаж ирж тавьчаад тэгээд энэ асуудлаа шийдүүлэх тал дээрээ илүү идэвхтэй ажиллах ёстой. Аль аль нь цөөнх байгаа, аль алинтай нь энэ асуудлаараа яриад явах ёстой байх. Түүнээс одоо энд ингэж юу ирээд ийм асуултад ороод яах аргагүй л тэгээд та нар яаж ажлаа сольж байшин барьж ийм асуудал байхад та нар байшин барьснаараа яаж шийдэх гэж байгаа юм гээд ингээд асууж байгаа чинь асуух л асуулт байхгүй юу. Тэгэхээр тэрэн дээрээ гүйцээгээд энэ асуудлаа хэрэв та нар гаргаж ирээд тавьчихсан бол ийм байгаа юм гээд. Тэгвэл дараа дараагийнхаа юмыг аливаа асуудлыг ингээд шийдэгдтэл урагшаа ахиц гартал нь үр дүнг нь гартал та нар явж байх ёстой. Энэ улсад яагаад гэвэл хүний эрхийн асуудлаар хамгийн зоригтой ярих ёстой байгууллага чинь танай байгууллага.

Тэгээд энэ дээрээ бол цаашдаа ч гэсэн та нар саяын энэ ярьж байгаа зүйлийг анхаараад бодож үзэх ёстой. Тэгээд өшөө гүйцээгээд хийх юмнууд ингээд дутуу орхигдчихсон байна шүү, энийг ингээд хийх ёстой шүү. Энэ улс орны эв нэгдэл харилцан ойлголцлын төлөө энэ асуудлыг чинь ярих ёстой гээд та нар харин яриад явж байх ёстой байсан шүү. Түүнээс энийг чинь ингээд орхичихсон болохоор дараа нь ингээд л асуудал гараад ирж байгаа юм.

Орхигдсоноор асуудал хэзээ ч шийдэгддэггүй гэдгийг л хэдүүлээ ойлгож авах ёстой. Асуудал хэрэв байгаа бол тэрийг шийдэхийн төлөө л явж байх ёстой. Тэр утгаараа сая яригдаж байна гэж ойлгох ёстой. Нэг зүйл би хэлмээр байна. Тэр танай барилгын асуудал дээр би танайхыг хамгийн их дэмждэг хүн, дандаа дэмждэг. Энэ барилгын асуудлыг хамгийн түрүүн би гаргаж тавьж байсан. Бүүр 12 онд би Монгол Улсад Ази Номхон далайн төвийн хүний эрхийн төвийг байгуулах ёстой гэдэг саналыг өөрөө гаргаад ярьж байсан хүн байхгүй юу. Тэгээд дараа нь НҮБ-ын байнгын төлөөлөгчтэй энэ асуудлыг чинь та нар ч өөрсдөө мэдэж байгаа. Энийг ингээд бариад өгөөч гээд. Гэхдээ би энийг ярихдаа харин олон Улсын санхүүжилт дэмжлэгээр бариулахын төлөө бүс нутгийн хүний эрхийн төв гэж бариулахын төлөө явъя гэж би яриад байсан. Та нар энийг санаж байгаа юу. Тэгэхгүй та нар ингээд төсөв рүү оруулж ирээд байх юм. Яг л ийм асуулт гарна шүү дээ. Тэгээд ийм мөнгө оруулаад ирчихээр энэний дагуу чинь яаж хүний эрх сайжрах юм гэж асуухад зүй ёсны асуудал. Тэрийг чинь би ч тэгж асуумаар байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэн дээрээ та нар тэр олон Улсын санхүүжилтийн эх сурвалж юмаа бодож байх ёстой. Түрүүнд Цогтбаатар гишүүний тэр хэлж байгаа асуудал бол би бичиг баримттай нь бүрэн гүйцэд танилцаагүй учраас хамаагүй нэг их юм яриад яах вэ? Би та нарт итгэж байдаг учраас. Гэхдээ нөгөө талаасаа надад лав тэр олдсон мэдээллээс үзэхэд та нар яагаад ч зөв хандлага гаргаагүй байна лээ шүү. Тэгэхээр надаа энийгээ нэлээн сайн нарийвчилж орж ирж та нарт тайлбар байгаа бол орж ирж танилцуулаарай. Түүнээс тэр юун дээр надаа мянган тайлбар хэлээд хэрэггүй. Тэр сэтгүүлчдийг би та нараас ч өмөөрнө. Хүний эрхийг хамгаалдаг нь та нар функцээрээ боловч өөрсдөө хамгаалж чадахгүй байгаа бол өмнөөс нь би ярьж өгье. Тэгээд нийтэд байгаа мэдээллийг биометрийн мэдээлэл авсан гээд хэрэв тийм юм яригдсан бол тэр шал буруу. Би зүгээр тийм биш байгаасай гэж бодож байгаа.

Тийм учраас таныг би над дээр оруулж ирж наадхаа танилцуулаарай гэж хэлж байна шүү дээ. Тийм учраас энэ танай дээр анхаарах асуудлууд байгаа. Яагаад би энийг хэлж байгаа вэ гэхээр танайх энэ төрийн байгууллагуудыг цочроогоод ийм асуудлууд байгаад байна гээд яриад явж байх ёстой байгууллага. Тэгтэл танайх бол дэндүү брократ ноомой ийм зүгээр төрийн байгууллага л болчихсон байхгүй юу. Та нар төрийн байгууллага биш шүү дээ. Энэ олон нийтээс мандат авчихсан би та нарыг хэлдэг шүү дээ. Хэд хэдэн хурал дээр ажлаа өгөхөөс битгий ай. Очоод зад үзэлцэж байгаад тэгээд ажлыг чинь авбал бүүр хэлж байгаад энэ дарга ингээд би энэ иргэнийг өмөөрсөн чинь энэ дарга шахаж байгаад миний ажлыг авч байна ард түмэн мэдээрэй гэж байгаад ажлаа өгөөд нулимаад гар л даа. Тэгж байж хүний эрхийн төлөө тэмцдэг байхгүй юу. Түүнээс даргаараа суух гээд хоорондоо юугаа булаацалдаад ингээд яваад байх юм бол ажил чинь явахгүй. Би та нарыг дэмжиж ажилладгийн хувьд шаардлага тавьж ажиллана.

Тэгээд дараагийн юу руугаа оръё.

Асуулт асууж, үг хэлж дууслаа. Хүний эрхийн Үндэсний комиссын 2027 оны төсвийн төслийн ХЗБХ-оор хянагдсан хувилбарыг хасагдуулалгүйгээр Улсын төсөвт нэгтгүүлэхээр санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Уучлаарай. Санал хураалт биш. Эхлээд юу санал хураалтдаа бэлдье. Орж байна уу? Санал. Хураалтдаа бэлдье.

Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

62.5 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд Улсын Улсын дээд шүүх, ШЕЗ, Шүүхийн сахилгын хороо болон Хүний эрхийн Комиссын 2027 оны төсвийн төслийг хэлэлцэж дууслаа.

23.30 цаг

Ажлын хэсэгтээ баярлалаа.

Дараагийн асуудалдаа оръё.

Арван долоо. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Байнгын хорооны тогтоолын төсөл “Ажлын хэсэг байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын даргын үүрэг болгосны дагуу Улсын Их Хурлаас 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр батлагдсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх “Ажлын хэсгийг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг боловсруулж та бүхэнд хүргүүлсэн болно оо.

Тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол

2026 оны ... дугаар сарын ... дугаар өдөр, дугаар, Улаанбаатар хот.

Ажлын хэсэг байгуулах тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалтыг үндэслэн ХЗБХ-оос тогтоох нь.

1. Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр батлагдсан Монгол Улсын Шүүхийн тухай хууль, шинэчилсэн найруулгын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж Хууль зүйн байнгын хороонд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Х.Баасанжаргал, Монгол Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүд П.Сайнзориг, О.Алтангэрэл та нар анхааралтай сонсоорой. Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр батлагдсан Монгол

Улсын шүүхийн тухай хууль шинэчилсэн найруулгын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж Хууль зүйн байнгын хороонд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулах.

Тэгээд Сайнзориг гишүүн би тийм Баасанжаргал гишүүн ажлын хэсгийн ахлагч, ажлын хэсгийн гишүүд Сайнзориг гишүүн, Алтангэрэл гишүүн, Уянгахишиг гишүүн, Номинчимэг гишүүн ингээд Улсын Их Хурлын гишүүдээс бүрдсэн байгаа.

2.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжлийн албан хаагчдыг ажиллуулахыг ажлын хэсэг Баасанжаргалд зөвшөөрсүгэй.

Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар гэсэн байгаа.

Баасанжаргал гишүүн энэ дээр нэг мэдээлэл хийе гэсэн байгаа. Тэр боломжийг олгоё. Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Үгүй ээ манайхан та хэд нэг юмыг надад зайлшгүй шийдэж өгөөч гэж хүсэх гээд байгаа юм. Юу гэвэл нөгөө 2021 онд баталсан хууль тэгээд одоо 5 жил нь болчихсон учраас энэ хуулийн хэрэгжилтийн үнэлгээг зайлшгүй хийе гээд тэгээд Шүүхийн сахилгын хороо болон Их Хурлын дарга холбогдох нөгөө шүүхийн байгууллагуудтай уулзаад ийм ажлын хэсэг байгуулъя гэдэг шийдэлд хүрсэн юм. Миний хувьд нөгөө манай гэр бүлийн хүн шүүхэд ажилладаг учраас би яг энэ хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх ажлыг хэсэгт орох нь зөв үү буруу юу гэдэгтэй яг үнэндээ бол эргэлзээд л байна.

Яг энэ салбарыг бол үнэхээр мэддэг энэ салбарын төлөө ажиллахад бол бэлэн. Тэгээд ямар ч байсан гишүүддээ энэ тухай би бол нээлттэй хэлээд шийдүүлэх нь зөв байх гэж бодож байна.

Д.Цогтбаатар: Тэмүүжин гишүүн үг хэлье.

Хуулийн хэрэгжилт дээр сонирхол зөрчил гарахгүй ээ. Ер нь бид нар сонирхол, зөрчлөө яг зөв тодорхойлж сурах хэрэгтэй. Сонирхлын зөрчил үндсэндээ бизнесийг хөнгөвчлөх эс үгүй бол төсвөөс мөнгө авах бол өөрийнх нь бизнес энд орж байна уу үгүй юу гэдэг дээр л гарахаас биш яг энэ дээр сонирхлын зөрчил гарахгүй. Харин зүгээр шүүхийн хуулийн биелэлтийн ажлын хэсэг дээр би ормоор байна.

Х.Баасанжаргал: Тэгвэл Тэмүүжин гишүүнийг нэмье. Энэ дээр байна шүү дээ нэг ийм асуудал байгаа юм. Хэдүүлээ ёстой ХЗБХ энэ асуудлыг Баасанжаргал гишүүн гаргаж тавьж байгаа нь маш зөв. Тэгээд хэдүүлээ нэг юмыг ойлгох хэрэгтэй. Манайд ашиг сонирхлын зөрчил гэхээр сөрөг юм гэж ойлгоод байдаг байхгүй юу. Хэн ч ашиг сонирхол нь зөрчилдөөд нөхөр нь тэнд ажиллаж байгаад амьдрал яг л ийм байхгүй юу. Тэгэхээр ашиг сонирхлын зөрчил гэдэг бол амьдралд гарч болзошгүй тэгээд тэрийгээ гаргаж ирж хэлээд энэ ажилд ямар нэгэн байдлаар нөлөөлчих үү үгүй юу гэдэг асуудал.

Тэгээд тэр нь одоо жишээлбэл нөхрийнх нь яг карьерт нөлөөлөх гэж байгаа юу үгүй юу гэвэл энэ чинь ерөнхий хууль институцийн хэрэгжилтийн тухай асуудал ярьж байгаа болохоор ашиг сонирхлын зөрчлөө харин одоо бид нар ингээд сөрөг

гээд байхаар юу болчхож байгаа вэ гэхээр хүмүүс энийгээ хэлж чадахгүй би нэг ашиг сонирхлын зөрчилтэй муу хүн болчих гээд байна гээд үгүй эсрэгээрээ энэ чинь хэлээд, мэдэгдээд, тэгээд жишээлбэл тодорхой яг тодорхой хүний асуудал байвал санал хураалтад орох уу үгүй юу ийм л тухай асуудал болохоос энэ чинь ирвэл зүгээр ямар ч амьдралд гарч болзошгүй асуудал байхгүй юу.

Тэгэхээр би Тэмүүжин гишүүний саналтай нэг байна. Гишүүн харин энд Тэмүүжин гишүүнийг ажлын хэсэг дээр нь нэмье. Удирдах хүнийг нь Баасанжаргал гишүүн өөр хүн тэгвэл тавиад явчихна зөв үү? Удирдах хүнийг нь харин хэн байх вэ? Зүгээр та нар нэг саналаа хэлэх үү? Номинчимэг гишүүнээр тэгвэл ахлуулаад хийчихье.

Ингээд саяын ажлын хэсгийг ахиад би зүгээр юугаар нь уншихъя. Ажлын хэсгийн ахлагч Номинчимэг гишүүн, ажлын хэсгийн гишүүдээр Сайнзориг, Алтангэрэл, Уянгахишиг, Баасанжаргал л тэгээд Тэмүүжин гишүүн гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр явчихъя.

Тэгээд энэ тогтоолын төслийг дэмжье гэсэн томьёоллоор манайхан санал хураалтдаа бэлдээрэй. Саяын тогтоолыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Сайнзориг гишүүний микрофоныг өгье

П.Сайнзориг: Дарга энэ хуруу хөлөрчихсөн юм уу яасан юм болсонгүй. Болохгүй байна шүү. Үгүй үгүй улайгаад байна. Сая яг Тэмүүжин гишүүн хажууд байж байсан болоогүй шүү. Тэгээд өмнөх саналыг хүчингүй болгож дахин санал хурааж өгнө үү? Саяын саналыг хүчингүй болгох горимын саналыг дэмжье гэж санал хураалт явуулъя.

Санал хураалт.

68.8 хувиар санал дэмжигдлээ.

Тэгээд түрүүн уншиж танилцуулсан томьёоллыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

68.8 хувиар санал дэмжигдлээ.

23.40 цаг

Арван найм. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол “Ажлын хэсэг байгуулах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийг үндэслэн ХЗБХ-оос тогтоох нь:

1. Монгол Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжин нарын 20 гишүүнээс 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хороо хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Б.Сайнзориг Монгол Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүд С.Цэнгүүн Монгол Улсын Их Хурлын гишүүн, С.Эрдэнэболд Монгол Улсын Их Хурлын гишүүн.

2. Ажлын хэсэг Мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжлийн албан хаагчдыг ажиллуулахыг ажлын хэсэг Сайнзоригт зөвшөөрсүгэй.

Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар. Энэ тэгэхдээ гурвуулаа л нэг жоохон арай л яамаар байна. Тэгээд 2 1 хүнтэйгээ суугаад л шийдээд байх юм. Тийм байна. Зөв зөв. Тэгэхээр саяын би уншиж танилцуулсан дээр бүрэлдэхүүнийг шинэчлээд уншаадахъя.

Ажлын хэсгийн ахлагч Сайнзориг, ажлын хэсгийн гишүүд Алтангэрэл, Пүрэвдаваа, Эрдэнэболд, Нарантуяа-Нара гишүүн. Ийм 5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсгийг байгуулъя. Энийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураая.

Гишүүд санал хураалтдаа бэлдье.

Түрүүн уншиж танилцуулсан томьёоллоор дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

68.8 хувиар санал дэмжигдлээ.

23.42 цаг

Дараагийн ажлын хэсгийн танилцуулъя.

Арван ес. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Ажлын хэсэг байгуулах тухай толгой хэсэг яг адилхан хэвээрээ.

1. Монгол Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг нарын 37 гишүүнээс 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн

хууль, тогтоолын төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Номинчимэг, Монгол Улсын Их Хурлын гишүүн ажлын хэсгийн гишүүд Пүрэвдаваа гишүүн, Алтанхуяг гишүүн, Уянгахишиг гишүүн тэгэхээр энэ хэд болчихож байна. Ахиад нэг гишүүн Цэнгүүн гишүүнийг энэ дээр тэгээд л нэмчих үү? Тийм Цэнгүүн гишүүнийг нэмчихье энэ дээр өө санаачлагч юм уу Пүрэвдаваа гишүүн байгаа. Тулга гишүүн санаачлагч юм байна. Цогтбаатар, Цогтбаатар гишүүн орчих. Би өөрөө зурчихсан шүү дээ наадхыг чинь. Алтанхуяг гишүүн энд орчихсон байгаа байхгүй юу. Тэгээд Ганбат гишүүнийг оруулчихъя. Тэгэхээр ахиад би уншаад танилцуулчихъя. Ажлын хэсгийн ахлагч Номинчимэг, ажлын хэсгийн гишүүд Пүрэвдаваа, Алтанхуяг, Уянгахишиг, Ганбат гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр 5 гишүүн байна. Ийм бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг байгуулъя.

2.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжлийн албан хаагчдыг ажиллуулахыг ажлын хэсэг Номинчимэгт зөвшөөрсүгэй.

Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар.

Энэ уншиж танилцуулсан тогтоолыг дэмжье гэж санал хураалт явуулъя. Санал хураалтдаа бэлдье. Тэгвэл түрүүн уншиж танилцуулсан тогтоолын төслийг дэмжье гэж санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Байнгын хорооны гишүүддээ гүн талархал илэрхийлье ээ.

Шөнө 11:46 болж байна. Манай Байнгын хороо хуралдаж хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье ээ.

Гишүүддээ дахин талархал илэрхийлье. Баярлалаа.

11.46 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА